

**БАНКНЫ ӨӨРИЙН ХӨРӨНГИЙН ХҮРЭЛЦЭЭ БОЛОН ХӨРВӨХ ЧАДВАРЫН  
ХҮРЭЛЦЭЭГ ДОТООДДОО ҮНЭЛЭХ АРГАЧЛАЛЫН  
ЖУРАМ**

1. Нийтлэг үндэслэл

*Нэгдүгээр бүлэг. Засаглал, хяналт хариуцлага*

2. ИСААР, ИЛААР-н засаглал
3. Өөрийн хөрөнгийн хүрэлцээний мэдэгдэл болон Хөрвөх чадварын хүрэлцээний мэдэгдэл
4. ИСААР, ИЛААР-н үндсэн бүрэлдэхүүн хэсгүүд
5. Дотоод хяналт, баталгаажуулалт
6. Тайлагнал
7. Хяналт, хариуцлага
8. Хугацааны хэрэгжилт, шилжилт

*Хоёрдугаар бүлэг. ИСААР-н бүрэлдэхүүн хэсгүүд*

9. Банкны үйл ажиллагааны тасралтгүй байдал
10. Эрсдэлийг тодорхойлох
11. Эрсдэлийг тооцоолох аргачлал
12. Дотоод өөрийн хөрөнгийн тодорхойлолт болон чанар
13. Стресс тест

*Гуравдугаар бүлэг. ИЛААР-н бүрэлдэхүүн хэсгүүд*

14. ИЛААР-н зорилго
15. Стратегийн болон хөрвөх чадварын төлөвлөгөө
16. Эрсдэлийг тодорхойлох, тооцоолох, удирдах
17. Хараат бус баталгаажуулалт
18. Стресс тест

Хавсралт 1

Хавсралт 2

Хавсралт 3

## 1.Нийтлэг үндэслэл

1.1.Энэ журмын зорилго нь банкны Өөрийн хөрөнгийн хүрэлцээг дотооддоо үнэлэх аргачлал (цаашид “ИСААР” гэх), Хөрвөх чадварын хүрэлцээг дотооддоо үнэлэх аргачлал (цаашид “ИЛААР” гэх)-ыг тодорхойлох, эдгээр аргачлалуудыг хэрэгжүүлэх засаглал, хэрэгжүүлэхэд баримтлах зарчим, аргачлалын дагуу боловсруулах тайлангийн бүтэц, агуулгыг тогтоох, ИСААР, ИЛААР-д хяналт тавих болон тэдгээрийг тайлагнахтай холбоотой харилцааг зохицуулахад оршино.

1.2.Банк нь өөрийн үйл ажиллагааны цар хүрээ, онцлог, нарийн төвөгтэй байдалд нийцүүлэн өөрийн хөрөнгө болон хөрвөх чадварын хүрэлцээг хангах төлөвлөгөөг боловсруулан хэрэгжүүлж, энэ журмын 6-д заасны дагуу дотооддоо болон Монголбанканд тайлагнадаг бөгөөд хэрэгжилтэд хяналт тавьдаг байна.

1.3.Банк нь өөрийн үйл ажиллагаанд учирч байгаа бүх төрлийн материаллаг эрсдэлүүдийг тодорхойлж, үнэлэх эрсдэлийн удирдлагын тогтолцоотой байна.

1.4.Банк нь Монголбанкны “Банкны үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүдийг тогтоох, түүнд хяналт тавих журам”-ын дагуу тогтоосон зээлийн, гадаад валютын ханшийн, үйл ажиллагааны эрсдэлд харгалзах өөрийн хөрөнгө<sup>1</sup>, төлбөр түргэн гүйцэтгэх чадварын шаардлагыг хангахаас гадна энэ журмын 1.2-ын дагуу тодорхойлсон материаллаг эрсдэлүүдэд харгалзах өөрийн хөрөнгө болон хөрвөх чадварын шаардлагыг хангана.

1.5.Банк нь энэ журмын 1.3-ын хүрээнд бүх материаллаг эрсдэлүүдийг тодоройлж, 1.4-ийн дагуу өөрийн хөрөнгө болон хөрвөх чадварын шаардлагыг хангах хүрээнд дараах дөрвөн зарчмыг<sup>2</sup> баримтална:

### **Нэгдүгээр зарчим: Банк нь ИСААР болон ИЛААР-г хэрэгжүүлнэ**

1.5.1.Банк нь өөрийн хөрөнгө болон хөрвөх чадварын хүрэлцээг цогцоор нь үнэлэх тогтолцоог эрсдэлийн ерөнхий түвшинтэй уялдуулан бүрдүүлж, өөрийн хөрөнгийн болон хөрвөх чадварын хүрэлцээг хангах стратегитай байна.

### **Хоёрдугаар зарчим: Монголбанк нь хяналт шалгалтын үнэлгээг гүйцэтгэнэ**

1.5.2.Монголбанк нь банкны ИСААР, ИЛААР-н үр дүн, холбогдох стратеги төлөвлөгөөг хянаж, үнэлэх бөгөөд хэрэгжих боломжтой эсэхийг, мөн хяналт шалгалтын үнэлгээний аргачлалын хүрээнд тогтоосон өөрийн хөрөнгийн болон хөрвөх чадварын шаардлагатай нийцэж байгаа эсэхийг тодорхойлно.

1.5.3.Хяналт шалгалтын явцад аливаа дутагдал илэрсэн тохиолдолд Монголбанкнаас холбогдох арга хэмжээг авна.

---

<sup>1</sup> Базел стандартын Бүлэг 1-ийн шаардлага

<sup>2</sup> Базел стандаотын Бүлэг 2-ын зарчмуудтай нийцтэй

**Гуравдугаар зарчим: Монголбанк нь банканд зохицуулалтын доод шаардлагаас дээгүүр хүлээлт тавина**

1.5.4. Хяналт шалгалт хэрэгжүүлэх эрх бүхий байгууллага нь банкнаас өөрийн хөрөнгийн болон хөрвөх чадварын түвшнийг зохицуулалтын доод хэмжээнээс дээш хэмжээгээр хадгалахыг шаардах, банкнаас өөрийн хөрөнгө, хөрвөх чадварыг доод хэмжээнээс дээш хэмжээгээр нэмэгдүүлэхийг үүрэг болгох эрхтэй байна.

**Дөрөвдүгээр зарчим: Монголбанк нь хяналт шалгалтын арга хэмжээ авна**

1.5.4. Монголбанк нь банкны эрсдэлийн ерөнхий түвшнийг хангахад шаардлагатай өөрийн хөрөнгө, хөрвөх чадвартай хөрөнгийг доод хэмжээнээс буурахаас урьдчилан сэргийлэх зорилгоор эрт үе шатанд банкны үйл ажиллагаанд хөндлөнгөөс оролцоно.

1.5.5. Монголбанк нь өөрийн хөрөнгө, эдийн засгийн өөрийн хөрөнгө, хөрвөх чадварын шаардлага хангагдаагүй гэж үзсэн тохиолдолд банкнаас залруулах арга хэмжээ авахыг шаардаж болно.

1.6. Нэгдүгээр зарчмыг банк хэрэгжүүлэх бол хоёр, гурав, дөрөвдүгээр зарчмуудыг хянан шалгалт хэрэгжүүлэх эрх бүхий байгууллага хэрэгжүүлнэ.

1.7. Өөрийн хөрөнгийн болон хөрвөх чадварын хүрэлцээний үнэлгээ нь тасралтгүй үргэлжлэх үйл явц бөгөөд банк нь шинэ зах зээлд нэвтрэх, шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээ нэвтрүүлэх, банкны нэгдлийн оролцогчийн бүтцийн өөрчлөлт гэх зэрэг бүх төрлийн материаллаг өөрчлөлтүүдийг ICAAP, ILAAP-д тухай бүр тусгана.

1.8. Энэ журамд дурдсан нэр томъёог Банкны тухай хууль, Компанийн тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжид тодорхойлсон утгаар ойлгоно.

## **НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. ЗАСАГЛАЛ, ХЯНАЛТ ХАРИУЦЛАГА**

### **2. ICAAP, ILAAP-н засаглал**

2.1. ICAAP, ILAAP-н үндсэн бүрэлдэхүүн хэсгүүдийг дотооддоо баталсан журмын дагуу банкны Төлөөлөн удирдах зөвлөл (цаашид “ТУЗ” гэх) батална.

2.2. ТУЗ, Гүйцэтгэх удирдлага, ТУЗ-ийн дэргэдэх хороод нь ICAAP, ILAAP-г үр дүнтэй хэрэгжүүлэх чиглэлээр санал солилцож, шаардлага тогтоож ажиллана.

2.3. ТУЗ нь банкны Өөрийн хөрөнгийн хүрэлцээний мэдэгдэл болон Хөрвөх чадварын хүрэлцээний мэдэгдлийг батална.

2.4. ТУЗ нь ICAAP, ILAAP-н хэрэгжилтийг хариуцаж, холбогдох үүрэг, хариуцлагыг ажлын чиг үүргийн хуваарьт үндэслэн тодорхой, ил тод байдлаар хуваарилж, ICAAP, ILAAP-н засаглалын тогтолцоог тодорхойлно.

2.5. ICAAP, ILAAP-н засаглалын тогтолцоонд дотоод хяналт, баталгаажуулалтын үйл явцыг тусгана.

2.6. ICAAP, ILAAP-н иж бүрэн байдал болон банкны үйл ажиллагааны онцлог, цар хүрээ, нарийн төвөгтэй байдалтай нийцтэй эсэхэд ТУЗ-өөс хяналт тавина.

### **3. Өөрийн хөрөнгийн хүрэлцээний мэдэгдэл болон Хөрвөх чадварын хүрэлцээний мэдэгдэл**

3.1. Банк нь өөрийн хөрөнгийн хүрэлцээний үнэлгээг ICAAP-н үр дүн болон бусад холбогдох мэдээлэлд үндэслэн гүйцэтгэж, үнэлгээний товч үр дүнг тусгасан Өөрийн хөрөнгийн хүрэлцээний мэдэгдлийг жилд 1 удаа шинэчлэн боловсруулж, ТУЗ-өөр батлуулна.

3.2. Банк нь хөрвөх чадварын хүрэлцээний үнэлгээг ILAAP-н үр дүн болон бусад холбогдох мэдээлэлд үндэслэн гүйцэтгэж, үнэлгээний товч үр дүнг тусгасан Хөрвөх чадварын хүрэлцээний мэдэгдлийг жилд 1 удаа шинэчлэн боловсруулж, ТУЗ-өөр батлуулна.

3.3. Өөрийн хөрөнгө, хөрвөх чадварын хүрэлцээний мэдэгдэлд тусгасан банкны өөрийн хөрөнгө, хөрвөх чадварын үнэлгээний үр дүн, дүгнэлтүүд нь ICAAP, ILAAP-н үр дүн болон бусад холбогдох мэдээллээр баталгаажсан эсэхэд ТУЗ хяналт тавина.

3.4. Өөрийн хөрөнгө, хөрвөх чадварын хүрэлцээний мэдэгдлүүд нь ТУЗ-ийг банкны өөрийн хөрөнгө болон хөрвөх чадварын хүрэлцээ, тэдгээрт нөлөөлөгч голлох хүчин зүйлс, анхаарах асуудлууд, ICAAP, ILAAP-н агуулга, үр дүн, үзүүлэлт, үйл явц болон стратеги төлөвлөгөөтэй уялдсан байдлын талаарх мэдээллээр хангахуйц цогц хэлбэртэй байна.

### **4. ICAAP, ILAAP-н үндсэн бүрэлдэхүүн хэсгүүд**

4.1. ТУЗ нь ICAAP, ILAAP-н үндсэн бүрэлдэхүүн хэсгүүдийг батална:

#### **4.1.1. Засаглалын тогтолцоо**

4.1.1.1. дотоод аудитын нэгжийн ICAAP, ILAAP-н тайланг хянах, баталгаажуулахад гүйцэтгэх чиг үүрэг;

4.1.1.2. эрсдэлийн удирдлагын нэгжийн ICAAP, ILAAP-н тайланг боловсруулах болон бусад холбогдох нэгжүүдийн үйл ажиллагаатай уялдуулахад гүйцэтгэх чиг үүрэг;

4.1.1.3. актив, пассивын удирдлагын нэгжийн өөрийн хөрөнгийн болон хөрвөх чадварын хүрэлцээний төлөвлөгөөг бусад холбогдох нэгжүүдийн үйл ажиллагаатай уялдуулан боловсруулахад гүйцэтгэх чиг үүрэг;

4.1.1.4. ICAAP, ILAAP-н тайланг Гүйцэтгэх удирдлагаар урьдчилан баталгаажуулах тогтолцоо болон ТУЗ-д танилцуулж, эцэслэн баталгаажуулах тогтолцоо.

#### **4.1.2. Дотоод баримтжуулалтын тогтолцоо**

4.1.2.1. Энэ журмын нэгдүгээр болон хоёрдугаар хавсралтын дагуу боловсруулсан ICAAP, ILAAP-н тайлан, бусад дагалдах баримт бичгүүд;

4.1.2.2.Өөрийн хөрөнгө, хөрвөх чадварын хүрэлцээний мэдэгдлүүд болон бусад дагалдах баримт бичгүүд.

#### **4.1.3.Хамрах хүрээ**

4.1.3.1.өөрийн хөрөнгө, хөрвөх чадварын хүрэлцээний үнэлгээнд хамруулах банкны үйл ажиллагаа, банкны нэгдэл, түүний толгой компанийн цар хүрээ;

4.1.3.2.эрсдэлийг тодорхойлох үйл явц, дотоод эрсдэлийн бүртгэл, ангилал зүйг материаллаг эрсдэлүүдийн хамрах хүрээ болон тэдгээр эрсдэлүүдээс гарах алдагдлыг нөхөхөд шаардлагатай өөрийн хөрөнгө болон хөрвөх чадвартай хөрөнгөтэй уялдуулан тодорхойлох;

#### **4.1.4.Эрсдэлийг тооцоолох арга зүй**

4.1.4.1.Бодитой тоо баримт, найдвартай өгөгдлийн системд үндэслэн тодорхойлсон эрсдэлийг хэмжихэд ашигласан таамаглалууд болон шалгуур үзүүлэлтүүд (хамрах хугацаа, төрөлжүүлсэн таамаглалууд, итгэх түвшин гэх мэт)-ийг хамруулсан эрсдэлийг тооцоолох аргачлалууд.

#### **4.1.5.Өөрийн хөрөнгийн болон хөрвөх чадварын хүрэлцээг үнэлэх аргачлал**

4.1.5.1.өөрийн хөрөнгө болон хөрвөх чадварыг үнэлэх аргачлал;

4.1.5.2.стресс тестийн аргачлал.

### **5.Дотоод хяналт, баталгаажуулалт**

5.1.Банк нь ICAAP, ILAAP-г дотооддоо хянах зохистой бодлого, тогтолцоог бүрдүүлэх бөгөөд хэрэгжилтэд ТУЗ-өөс хяналт тавина.

5.2.ICAAP, ILAAP-н дотоод хяналтыг банкны бие даасан, хараат бус дотоод аудитын нэгж өөрийн үүрэг, хариуцлагын хүрээнд хийж гүйцэтгэнэ.

5.3.Дотоод хяналтын хүрээнд ICAAP, ILAAP-н үр дүн, ашигласан төсөөлөл, таамаглалууд, өөрийн хөрөнгө болон хөрвөх чадварын төлөвлөлт, эрсдэлийг тооцоолох аргачлал, мэдээ, мэдээлэл нь үнэн зөв эсэхийг магадлан шалгаж, баталгаажуулна.

5.4.Дотоод хяналт нь үнэлж байгаа бүрэлдэхүүн хэсгийн онцлогоос хамааран тоон болон чанарын шинж чанартай байж болно.

### **6.Тайлагнал**

#### **6.1.Дотоод тайлагнал**

6.1.1.Банк нь энэ журамтай нийцүүлэн өөрийн хөрөнгийн болон хөрвөх чадварын үнэлгээг хийж, дараах хавсралтуудад заасан агуулгын дагуу ICAAP, ILAAP-н тайланг жил бүр боловсруулж, ТУЗ-өөр баталгаажуулна.

6.1.1.1.Өөрийн хөрөнгийн хүрэлцээний үнэлгээний (ICAAP) тайланг Нэгдүгээр хавсралтын дагуу;

6.1.1.2.Хөрвөх чадварын хүрэлцээний үнэлгээний (ILAAP) тайланг Хоёрдугаар хавсралтын дагуу.

6.1.2.Банк нь өөрийн үйл ажиллагааны онцлог, нарийн төвөгтэй байдал, бизнес загвараас хамааран энэ журмын хавсралтуудад заасан мэдээллийг ICAAP, ILAAP-н тайланд тусгаагүй бол холбогдох тайлбар, үндэслэлийг заавал тодруулна.

## **6.2.Хяналт шалгалтын тайлагнал**

6.2.1.Банк нь жил бүрийн 3 дугаар сарын 31-ний өдөрт багтаан өмнөх оны эцсийн байдлаар бэлтгэсэн ICAAP, ILAAP-н тайланг Монголбанканд бичгээр болон цахим хэлбэрээр ирүүлнэ.

6.2.2.Монголбанк нь ICAAP, ILAAP-н тайлангийн бүрдлийг шалгаж, шаардлага хангаагүй гэж үзвэл 4 дүгээр сарын 30-ны өдрийн дотор банканд мэдэгдэнэ. Банк мэдэгдэл авсан өдрөөс хойш ажлын 20 хоногийн дотор тайланг шинэчлэн ирүүлнэ.

## **7.Хяналт, хариуцлага**

7.1.Монголбанк нь банкнаас ирүүлсэн ICAAP, ILAAP-н тайлан шаардлага хангасан эсэхэд хяналт тавьж ажиллана.

7.2.Монголбанк нь энэ журмын хэрэгжилтэд хяналт тавьж, журмын заалтыг зөрчсөн этгээдэд Банкны тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

## **8.Хугацааны хэрэгжилт, шилжилт**

8.1.Энэ журмын шаардлагуудыг эдийн засгийн нөхцөл байдалтай уялдуулан шат дараатайгаар банкуудад хэрэгжүүлэх зорилгоор энэ журмын 13-т заасан төлбөрийн чадварын стресс тест болон 12-т заасан эдийн засгийн өөрийн хөрөнгийн шаардлагыг тооцоход дараах хугацааны хэрэгжилтийг баримтална:

8.1.1.2024, 2025 оны тайланд ирэх 1 жилийн хувьд,

8.1.2.2026, 2027 оны тайланд ирэх 2 жилийн хувьд,

8.1.3.2027 оноос хойших тайланд ирэх 3-5 жилийн хувьд тус тус тооцно.

## **ХОЁРДУГААР БҮЛЭГ. ИСААР-Н БҮРЭЛДЭХҮҮН ХЭСГҮҮД**

### **9.Банкны үйл ажиллагааны тасралтгүй байдал**

#### **9.1.Богино болон дүнд хугацааны тасралтгүй байдал**

9.1.1.ИСААР-н хүрээнд банк өөрт учирч байгаа эрсдэлүүдийг даах, алдагдал хүлээх, бизнесийн стратегийг тогтвортойгоор хэрэгжүүлэхэд хүрэлцэхүйц хэмжээний өөрийн хөрөнгөтэй эсэхийг үнэлнэ.

9.1.2.ИСААР нь банкны богино (1 жил хүртэл), дунд (3-аас 5 жил), урт хугацаанд болон хүндрэлтэй нөхцөлд үйл ажиллагааны тасралтгүй байдлыг хангахад чиглэнэ.

9.1.3.Банк нь эрсдэлийн хүлээн зөвшөөрөх хэмжээ (risk appetite)-г тогтоохдоо үйл ажиллагааны тасралтгүй байдлыг хангах зорилтыг харгалзан үзнэ.

9.1.4.ИСААР-н хүрээнд банк нь өөрийн эрсдэлийн ерөнхий түвшин, эмзэг байдалд үндэслэн эрсдэлийн хүлээн зөвшөөрөх хэмжээ, эрсдэл даах чадамжийг өөрийн хөрөнгийн хязгаарлалттай уялдуулан дахин үнэлнэ.

#### **9.2.Өөрийн хөрөнгийн хязгаарлалт**

9.2.1.Өөрийн хөрөнгийн хязгаарлалт нь банкны бүрдүүлэх боломжтой өөрийн хөрөнгийн дээд хэмжээ бөгөөд өөрийн хөрөнгийн тайлант хэмжээ, ашигт ажиллагаа, дунд хугацаанд өөрийн хөрөнгийг бүрдүүлэхэд шаардагдах хуримтлагдсан ашиг, хувьцаа эзэмшигчид болон хөрөнгийн зах зээлээс төвлөрүүлэх боломжтой нэмэлт өөрийн хөрөнгөөс бүрдэнэ.

9.2.2.Банк нь өөрийн хөрөнгийн хязгаарлалтад үндэслэн ногдол ашиг хуваарилах дээд хэмжээ (MDA) буюу ашгийг тооцсоны дараа хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг хэлбэрээр хуваарилах боломжтой өөрийн хөрөнгийн хэсгийг тодорхойлно.

9.2.3.Ногдол ашиг хуваарилах дээд хэмжээ нь “Банкны үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тогтоох, түүнд хяналт тавих журам”-ын дагуу тогтоосон өөрийн хөрөнгийн доод хэмжээ, нөөц интервал, Бүлэг 2-ын өөрийн хөрөнгийн шаардлага болон бусад холбогдох өөрийн хөрөнгийн шаардлагыг нийт өөрийн хөрөнгөөс хассан хэмжээтэй тэнцүү байна.

9.2.4.Өөрийн хөрөнгийн хязгаарлалтын хүрээнд банк нь зохицуулалтын болон хяналт шалгалтын өөрийн хөрөнгийн доод шаардлагаас дээгүүр хэмжээнд бүрдүүлж, стратегийг тогтвортой хэрэгжүүлэхэд шаардлагатай өөрийн хөрөнгийн хэмжээг үнэлж, тодорхойлно.

#### **9.3.Норматив болон эдийн засгийн хандлага**

9.3.1.Банк нь ИСААР-г хэрэгжүүлэхдээ норматив болон эдийн засгийн хандлагыг баримтална.

9.3.2.Норматив болон эдийн засгийн хандлага нь харилцан бие биеэ нөхөж, бизнесийн чухал үйл ажиллагаа, шийдвэртэй уялдаатай байна.

9.3.3.Норматив болон эдийн засгийн хандлагын хүрээнд банк нь өөрийн үйл ажиллагааны онцлогт нийцтэй суурь болон сөрөг сценарийн төсөөлөлд үндэслэн өөрийн хөрөнгийн төлөвлөгөөг боловсруулж, банкны ерөнхий төлөвлөгөөний зорилтуудтай нийцүүлнэ.

#### ***Норматив хандлага***

9.3.4.Норматив хандлагын хүрээнд банк нь Монголбанкнаас тогтоосон өөрийн хөрөнгийн доод болон нэмэлт шаардлага, өөрийн хөрөнгийн эрэлт, гадаад орчноос үүдэлтэй санхүүгийн бусад хүндрэлүүдийг даван туулахад шаардлагатай өөрийн хөрөнгийн дунд хугацааны үнэлгээг гүйцэтгэнэ.

9.3.5.Банк нь “Банкны үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тогтоох, түүнд хяналт тавих журам”-ын дагуу тогтоосон өөрийн хөрөнгийн хүрэлцээний зохистой харьцаа, хөшүүргийн харьцаа, төвлөрлийн эрсдэлийн зохистой харьцаа үзүүлэлтүүд болон Бүлэг 2-ын өөрийн хөрөнгийн шаардлагыг дунд хугацаанд тасралтгүй хангана гэж үзнэ.

9.3.6.Бүлэг 2-ын шаардлагын хүрээнд банк нь төвлөрлийн эрсдэл болон хөрөнгө оруулалтын дансан дахь хүүгийн эрсдэл (IRRBB)-д харгалзах өөрийн хөрөнгийн шаардлагыг заавал тооцож, нэмэлтээр ICAAP-н хүрээнд тодорхойлсон бусад эрсдэлүүдэд харгалзах өөрийн хөрөнгийн хэмжээг тооцно.

#### ***Эдийн засгийн хандлага***

9.3.7.Эдийн засгийн хандлагын хүрээнд банк нь эдийн засгийн алдагдлаас шалтгаалан дотоод өөрийн хөрөнгийн дутагдалд хүргэж болзошгүй бүх материаллаг эрсдэлүүдийг тодорхойлж, үнэлнэ.

9.3.8.Банк нь өөрийн хөрөнгийн хүрэлцээг дотооддоо үнэлэх аргачлалын хүрээнд учирч болзошгүй бүх эрсдэлээс гарах алдагдлыг хаахад хүрэлцэхүйц хэмжээний дотоод өөрийн хөрөнгөтэй эсэхийг баталгаажуулна.

#### **9.4.Өөрийн хөрөнгийн төлөвлөгөө**

9.4.1.Банк нь өөрийн стратеги, эрсдэлийн хүлээн зөвшөөрөх хэмжээ, өөрийн хөрөнгийг бүрдүүлэх нөөцтэй уялдаатай, найдвартай, тогтмол шинэчлэгддэг өөрийн хөрөнгийн төлөвлөгөөтэй байна.

9.4.2.Өөрийн хөрөнгийн төлөвлөгөөнд суурь болон сөрөг сценарийн төсөөллийг хамгийн багадаа ирэх гурван жилийн хувьд хийж гүйцэтгэнэ.

9.4.3.‘Өөрийн хөрөнгийн төлөвлөгөөнд хууль эрх зүй, зохицуулалт, нягтлан бодох бүртгэлийн тогтолцоонд гарч болзошгүй өөрчлөлтүүдийн нөлөө, тэдгээрийг шийдвэрлэх хүрээнд авч хэрэгжүүлэх бодитой, үндэслэлтэй арга хэмжээнүүдийг тусгана.



9.4.5.Өөрийн хөрөнгийн төлөвлөгөөнд өөрийн хөрөнгийн хүрэлцээ алдагдсан нөхцөлд авч хэрэгжүүлэх үйл явц, удирдлагаас авч хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхойлон тусгана.

### **9.5.Аргачлал**

9.5.1.Банк нь хүлээгдэж байгаа болон гэнэтийн алдагдлыг хаахад шаардлагатай дотоод өөрийн хөрөнгийн хэмжээг тодорхойлохдоо хувь тэнцүүлэх зарчмыг баримталж, өөрийн дотоод аргачлалыг ашиглана.

9.5.2.Банк нь аливаа нөхцөл байдлын эрсдэлийн үнэлгээг тайлант хугацааны байдлаар хийж гүйцэтгэнэ.

9.5.3.Банк нь тухайн нөхцөл байдлын үнэлгээнд тусгагдаагүй ирээдүйд үүсэж болзошгүй материаллаг өөрчлөлтүүд (удирдлагаас авч хэрэгжүүлэх боломжит арга хэмжээ, эрсдэлийн ерөнхий түвшний өөрчлөлт, гадаад орчны өөрчлөлт гэх зэрэг)-ийн үр нөлөөний дунд хугацааны үнэлгээг нэмэлтээр гүйцэтгэнэ.

### **9.6.ICAAP-н үр дүнг үйл ажиллагааны менежментэд ашиглах**

9.6.1.Банк нь өөрийн стратегийг хэрэгжүүлэх, эдийн засгийн үр ашгийг хадгалах зориулалт бүхий эдийн засгийн өөрийн хөрөнгийн хүрэлцээг тодорхойлох, үнэлэх тогтолцоог бүрдүүлсэн байна.

9.6.2.Банк нь эдийн засгийн өөрийн хөрөнгийн хүрэлцээний үнэлгээний үр дүн, үзүүлэлтүүдийг өөрийн бизнесийн стратеги, үйл ажиллагааны менежмент, эрсдэлийн хүлээн зөвшөөрөх хэмжээг хянахад ашиглана.

9.6.3.Банк нь эдийн засгийн өөрийн хөрөнгийн дутагдлыг арилгах хүрээнд арга хэмжээ авах, өөрийн хөрөнгийг нэмэгдүүлэх, эрсдэлийг бууруулах гэх зэрэг үр дүнтэй арга хэмжээ авах шаардлагыг нэн даруй тодорхойлох удирдлагын тогтолцоотой байна.

## **10.Эрсдэлийг тодорхойлох**

### **10.1.Эрсдэлийг бүртгэх, тодорхойлох үйл явц**

10.1.1.Банк нь өөрт учирч байгаа болон ирээдүйд учирч болзошгүй бүх материаллаг эрсдэлүүдийг эдийн засгийн болон норматив хандлагын хүрээнд тодорхойлох тогтмол үйл явцыг хэрэгжүүлнэ.

10.1.2.Банк нь материаллаг гэж тодорхойлсон бүх эрсдэлийг энэ журамд тодорхойлсон эрсдэлийн ангилал зүй эсхүл дотооддоо тодорхойлсон ангилал зүйн дагуу ICAAP-д тусгана.

10.1.3.Банк нь дотооддоо тодорхойлсон эрсдэлийн ангилал зүйг ашиглах тохиолдолд энэ журмын 10.2-т заасан Монголбанкнаас тодорхойлсон эрсдэлийн ангилал зүйтэй нийцэхгүй байх аливаа тохиолдлыг тайлагнана.

10.1.4.Банк нь эрсдэлийг тодорхойлохдоо холбогдох бүх бизнесийн чиглэл, үйл ажиллагаа, хөрөнгийг хамруулан цогц байдлаар гүйцэтгэнэ.

10.1.5.Банк нь материаллаг байдлын дотоод тодорхойлолтын дагуу материаллаг эрсдэлүүдийг жилд нэгээс доошгүй удаа тодорхойлно.

10.1.6.Материаллаг байдлын тодорхойлолтод эрсдэл биелэх, орхигдох, буруу тайлагнахаас шалтгаалан банкны өөрийн хөрөнгийн хүрэлцээ, ашигт ажиллагаа, үйл ажиллагааны тасралтгүй байдалд ихээхэн хэмжээний өөрчлөлт оруулах буюу нөлөө үзүүлж болзошгүй эсэхийг харгалзан үзнэ.

10.1.7.Стресс тестийн сөрөг сценарийн хүрээнд аливаа эрсдэл учирсан тохиолдолд банкны өөрийн хөрөнгө 5%-аас дээш хэмжээгээр алдагдахад хүргэж болзошгүй тохиолдолд материаллаг гэж үзнэ.

10.1.8.Банк нь эрсдэлийг тодорхойлох үйл явцын үр дүнд цогц дотоод эрсдэлийн бүртгэлийг үүсгэнэ.

10.1.9.Банк нь материаллаг гэж тодорхойлсон бүх эрсдэлийн хувьд тухайн эрсдэлээс гарах алдагдлыг хаахад шаардлагатай өөрийн хөрөнгийн хэмжээг тодорхойлж, өөрийн хөрөнгө хуваарилах шаардлагатай эсвэл шаардлагагүй эсэх үндэслэлийг баталгаажуулна.

10.1.10.Банк нь бүх материаллаг эрсдэлүүдийг тодорхойлох тогтмол үйл явцыг хэрэгжүүлж, тэдгээрийг цогц дотоод эрсдэлийн бүртгэлд тусгана.

10.1.11.Банк нь материаллаг байдлын дотоод тодорхойлолтыг ашигласнаар эрсдэлийн бүртгэлийг жилд нэгээс доошгүй удаа шинэчилдэг байна.

10.1.12.Аливаа эрсдэл нь материаллаг эрсдэлд тооцогдохоо больсон тохиолдолд банк эрсдэлийн бүртгэлд тухай бүр холбогдох өөрчлөлтийг оруулна.

10.1.13.ТУЗ нь материаллаг гэж үзэх эрсдэлүүдийг тодорхойлох, өөрийн хөрөнгө хуваарилах шаардлагатай материаллаг эрсдэлүүдийг тодорхойлох, материаллаг бус гэж үзэх эрсдэлүүдийг тодорхойлох асуудлыг шийдвэрлэх үүрэгтэй.

## **10.2.ИСААР-д хамаарах эрсдэлүүд**

10.2.1.ИСААР-д зээлийн, зах зээлийн, үйл ажиллагааны, төвлөрлийн, хөрөнгө оруулалтын дансан дахь хүүгийн, нэр хүндийн, стратегийн эрсдэлүүдийг заавал тусгана.

10.2.2.Дээр дурдсанаас бусад материаллаг эрсдэлүүдийг банк нэмэлтээр тусгах боломжтой.

10.2.3.Банк нь өөрт учирч байгаа эрсдэлүүдээс гадна банкны стратегийг хэрэгжүүлэх, үйл ажиллагааны орчинд гарах өөрчлөлтөөс шалтгаалан үүсэж болзошгүй аливаа эрсдэл, тухайн эрсдэлийн болон эрсдэл хоорондын төвлөрлийг тооцон ирээдүйд чиглэсэн өөрийн хөрөнгийн хүрэлцээний үнэлгээг гүйцэтгэнэ.

10.2.4.Монголбанк нь өөрийн үнэлгээнд үндэслэн материаллаг гэж үзсэн аливаа эрсдэлийг ИСААР-д оруулах шаардлагыг банканд тавьж болно.

### **10.3.Эрсдэлийн цогц аргачлал**

10.3.1.Банк нь эрсдэлийг тодорхойлохдоо аливаа эрсдэлийг бууруулах арга хэмжээг харгалзахгүй буюу цогц аргачлал (gross approach)-ыг баримтална.

10.3.2.Банк нь эрсдэлийг бууруулах хүрээнд хэрэгжүүлэх эсхүл хэрэгжүүлсэн арга хэмжээний үр нөлөөг үнэлнэ.

## **11.Эрсдэлийг тооцоолох аргачлал**

### **11.1.Эрсдэлийн цогц тооцоолол**

11.1.1.Банк нь эдийн засгийн болон норматив хандлагыг хамарсан, банкны үйл ажиллагааны онцлогт нийцтэй эрсдэлийг тооцоолох аргачлалыг нэвтрүүлнэ.

11.1.2.Банк нь сөрөг сценарийн таамаглалын хүрээнд ирээдүйд өөрийн хөрөнгөд гарч болзошгүй өөрчлөлт болон эрсдэлтэй хөрөнгийн нийт хэмжээг тооцоолоход зохих аргачлалыг ашиглана.

11.1.3.Банк нь ховор тохиолдох үйл явдлыг харгалзаж үзэх зорилгоор өндөр түвшний хатуу шалгуурын зарчмыг баримтална.

11.1.4.Эрсдэлийг тооцоолоход ашигласан голлох үзүүлэлтүүд болон таамаглалууд нь бүлэг, эрсдэлийн төрлүүдийн хооронд тогтвортой байна.

11.1.5.Эрсдэлийг тооцоолоход хүндрэлтэй эсхүл холбогдох тоон мэдээлэл байхгүй тохиолдол нь тухайн эрсдэлийг үнэлэхгүй байх үндэслэл болохгүй.

11.1.6.Дээрх тохиолдолд банк нь эрсдэлийн үзүүлэлтүүдийг хатуу шалгуураар тодорхойлж, эрсдэлийг тооцоолох арга зүйн оновчтой, тогтвортой байдлыг хангах үүднээс холбогдох бүхий л мэдээллийг харгалзан үзнэ.

### **11.2.Хатуу шалгуурын зарчимд нийцтэй таамаглалууд**

11.2.1.Эдийн засгийн болон норматив хандлагын хүрээнд ашиглаж байгаа эрсдэлийг тооцоолох арга зүй, таамаглалууд нь найдвартай, тогтвортой, эрсдэлд мэдрэмтгий байснаар ховор тохиолдох үйл явдлаас үүдэлтэй алдагдлыг тооцоолоход хангалттай хатуу шалгуурын зарчимд нийцтэй байна.

11.2.2.Эрсдэлийг тооцоолох аргачлалын хүрээнд үүссэн тодорхой бус байдлыг хатуу шалгуурын зарчмын түвшнийг нэмэгдүүлэх замаар шийдвэрлэнэ.

11.2.3.Хатуу шалгуурын зарчмын ерөнхий түвшнийг үндсэн таамаглал, үзүүлэлтүүдийн хүрээнд тус тусад нь бус цогцоор нь тодорхойлно.

11.2.4. Сонгогдсон таамаглалууд хатуу шалгуурын зарчимтай бага нийцэж байгаа эсэхээс үл хамааран хатуу шалгуурын зарчмын ерөнхий түвшин өндөр тохиолдолд бодит байдал дээр хангалттай хатуу шалгууртай арга барилтай байх боломжийг бүрдүүлнэ.

11.2.5. Бүлэг 1-т хамаарах зээлийн, зах зээлийн, үйл ажиллагааны эрсдэлүүдийг тооцоолоход ашиглах таамаглалуудын хатуу шалгуурын ерөнхий түвшин нь “Банкны үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тогтоох, түүнд хяналт тавих журам”-д заасан шаардлагаас багагүй байна.

11.2.6. Банк нь хөндлөнгийн зэрэглэл тогтоогч байгууллагын зээлжих зэрэглэл эсхүл гаднын статистик мэдээнд тулгуурлахаас илүүтэйгээр банкны эрсдэлийн хүлээн зөвшөөрөх хэмжээнд үндэслэн зээлийн эрсдэлийг үнэлэх аргачлалыг тодорхойлно.

11.2.7. Банк нь ирээдүйд хүлээж болзошгүй алдагдлыг харгалзан үзнэ.

11.2.8. Банк нь эрсдэлийг тооцоолох аргачлал, стресс сценариудыг үнэлэх аргачлалыг боловсруулан хэрэгжүүлж, ховор тохиолдох хүндрэлт үйл явдлууд, ирээдүйд тохиолдох томоохон хүндрэлт үйл явдлуудаас үүсэж болзошгүй алдагдлыг стратеги болон эрсдэлийн хүлээн зөвшөөрөх хэмжээний хүрээнд хаах боломжтой эсэхийг тодорхойлно.

### **11.3. Эрсдэлийг тооцоолох аргачлалыг тодорхойлох**

11.3.1. Банк нь эрсдэлийн тооцоолол болон таамаглалыг боловсруулахдаа өөрийн тодорхойлсон зохистой аргачлалыг ашиглаж болно.

11.3.2. Энэ журмын 11.1-д тодорхойлсны дагуу банканд учирч байгаа болон учирч болзошгүй эрсдэлүүдийг тооцоолоход тогтоосон аргачлал байхгүй болно.

11.3.3. Банкны ашиглаж байгаа эрсдэлийг тооцоолох аргачлалууд нь хамарч байгаа хэтийн төлөв, өөрийн хөрөнгийн тодорхойлолтын хүрээнд хоорондоо нийцтэй байна.

11.3.4. Эрсдэлийг тооцоолох аргачлалууд нь хувь тэнцүүлэх зарчмын дагуу банканд учирч байгаа эрсдэлүүдийг зохистой бөгөөд хатуу шалгуураар үнэлэхүйц байна.

11.3.5. Хувь тэнцүүлэх зарчмын дагуу банкны системд ач холбогдол бүхий байдал өндөр, үйл ажиллагаа болон эрсдэлүүд нарийн төвөгтэй байхын хэрээр банк нь өөрт учирч байгаа бүх эрсдэлүүдийг зохих байдлаар авч үзэхийн тулд илүү боловсронгуй, дэвшилтэт эрсдэлийг тооцоолох аргачлалтай байна.

11.3.6. Банк нь өөрийн нөхцөл байдал, эрсдэлийн ерөнхий түвшинтэй нийцтэй аргачлалыг ашиглана.

11.3.7. ИСААР-н тайлангийн нийт өөрийн хөрөнгийн шаардлага нь хамгийн багадаа дараах бүрэлдэхүүн хэсгүүдийг агуулсан байна<sup>3</sup>:

11.3.7.1. **Бүлэг 1-ийн өөрийн хөрөнгө:** “Банкны үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тогтоох, түүнд хяналт тавих журам”-д заасан зээлийн, зах зээлийн болон үйл ажиллагааны эрсдэлүүдэд харгалзах өөрийн хөрөнгийн шаардлага.

11.3.7.2. **Бүлэг 2-ын өөрийн хөрөнгө:** Энэ журмын Нэгдүгээр хавсралтын Бүлэг 10-т заасан хөрөнгө оруулалтын дансан дахь хүүгийн эрсдэлээс үүсэх цэвэр хүүгийн орлогын өөрчлөлт (ΔNII)-д харгалзах өөрийн хөрөнгийн шаардлага; Нэгдүгээр хавсралтын Бүлэг 7-д заасан төвлөрлийн эрсдэл болон бусад материаллаг, хэмжигдэхүйц эрсдэлүүдэд харгалзах өөрийн хөрөнгийн шаардлага.

11.3.7.3. **Эдийн засгийн өөрийн хөрөнгө:** Энэ журмын 13-т заасан өөрийн хөрөнгийн стресс тестийн суурь сценарийн таамаглалын хүрээнд гарах алдагдлыг хаахад шаардлагатай нэмэлт өөрийн хөрөнгө, банкны стратегийг 1 жилийн хугацаанд хэрэгжүүлэхэд шаардлагатай өөрийн хөрөнгө; Нэгдүгээр хавсралтын Бүлэг 10-ын хөрөнгө оруулалтын дансан дахь хүүгийн эрсдэлээс үүсэх өөрийн хөрөнгийн эдийн засгийн үнэ цэний өөрчлөлт (ΔEVE)-өөс гарах алдагдлыг хаахад шаардлагатай өөрийн хөрөнгө.

#### **11.4. Мэдээллийн чанар**

11.4.1. Банк нь ИСААР-н мэдээллийн чанар, найдвартай байдлыг хангах зохих үйл явц, хяналтын тогтолцоог бүрдүүлнэ.

11.4.2. Мэдээллийн чанарын тогтолцоо нь бүх эрсдэлтэй холбоотой мэдээллийн чанар, найдвартай байдлыг хангаж, зөв зохистой шийдвэр гаргахад дэмжлэг үзүүлнэ.

#### **11.5. Хараат бус баталгаажуулалт**

11.5.1. Банк нь эрсдэлийн материаллаг байдал болон эрсдэлийг тооцоолох аргачлалын нарийн төвөгтэй байдлыг харгалзан ИСААР-н эрсдэлийг тооцоолох аргачлалд хараат бус баталгаажуулалтыг тогтмол гүйцэтгэнэ.

11.5.2. Банк нь хамгаалалтын шугамын зарчмыг баримтлан эрсдэлийг тооцоолох аргачлалыг боловсруулах, баталгаажуулах үйл явцын хараат бус, бие даасан байдлыг хангана.

11.5.3. Банк нь баталгаажуулалтын үр дүнг Гүйцэтгэх удирдлага болон ТУЗ-д тайлагнаж, эрсдэлийг тооцоолох аргачлалуудад тогтмол хяналт тавих, тэдгээрт өөрчлөлт оруулах болон өөрийн хөрөнгийн хүрэлцээг үнэлэхэд ашиглана.

---

<sup>3</sup> Нийт өөрийн хөрөнгийн шаардлагыг тооцох жишээг Гуравдугаар хавсралтын 4-р бүлгээс харна уу.

## **12.Дотоод өөрийн хөрөнгийн тодорхойлолт болон чанар**

### **12.1.Дотоод өөрийн хөрөнгө**

12.1.1.Банк нь эдийн засгийн хандлагын хүрээнд дотоод өөрийн хөрөнгийг тодорхойлж, үнэлж, бүрдүүлнэ.

12.1.2.Дотоод өөрийн хөрөнгө нь эдийн засгийн хандлагын хүрээнд эрсдэл даах өөрийн хөрөнгийн бүрэлдэхүүн хэсэг болно.

12.1.3.Дотоод өөрийн хөрөнгийн тодорхойлолт нь энэ журмын 9-д заасан эдийн засгийн өөрийн хөрөнгийн хүрэлцээний тодорхойлолт, банкуудын дотоод эрсдэлийн тооцоололтой нийцтэй байна.

12.1.4.Банк нь дотоод өөрийн хөрөнгийг тодорхойлохдоо найдвартай, оновчтой, хатуу шалгуурын зарчимд нийцтэй аргачлалыг ашиглаж, эдийн засгийн өөрийн хөрөнгийн хүрэлцээг урт хугацаанд тогтвортой, бодитой байдлаар үнэлнэ.

12.1.5.Банк нь дотоод өөрийн хөрөнгийн эрсдэл даах чадамжийг үйл ажиллагааны тасралтгүй байдалтай уялдуулан тодорхойлно.

12.1.6.Оновчтой, хатуу шалгуурын зарчмыг баримтлах нь банкуудад эдийн засгийн өөрийн хөрөнгийн хүрэлцээг урт хугацааны турш тогтвортой, бодит байдалд нийцтэйгээр үнэлэх боломжийг олгоно.

### **12.2.Зохицуулагч байгууллагаас тогтоосон өөрийн хөрөнгийн шаардлага болон дотоод өөрийн хөрөнгийн ялгаа**

12.2.1.Эдийн засгийн болон норматив хандлагын хүрээнд тодорхойлсон дотоод өөрийн хөрөнгө нь үнэлгээний аргачлал, таамаглалуудаас шалтгаалан ялгаатай байж болно.

12.2.2.Банк нь дотоод өөрийн хөрөнгийг тодорхойлохдоо өөрийн хөрөнгийн бүрэлдэхүүн хэсгүүдийн үнэлгээг цэвэр өнөөгийн үнэ цэний аргачлал эсхүл өөрийн хөрөнгийн доод шаардлагад үндэслэн гүйцэтгэнэ.

12.2.3.Банк нь өөрийн хөрөнгийн доод шаардлагад үндэслэн дотоод өөрийн хөрөнгийг тодорхойлох тохиолдолд дотоод хөрөнгийн ихэнх хэсгийг нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө бүрдүүлнэ гэж үзнэ.

12.2.4.Банк нь эдийн засгийн хэтийн төлөвийн хүрээнд эдийн засгийн үнэ цэний аргачлалд үндэслэн дотоод өөрийн хөрөнгийг тодорхойлох тохиолдолд нуугдмал алдагдал (hidden losses) болон банкны үйл ажиллагаа зогссон тохиолдолд алдагдлыг шингээх чадвартай өөрийн хөрөнгийн зүйлсэд тохируулга хийнэ.

12.2.5.Нуугдмал алдагдал гэдэгт балансын зүйлсийн тайлангийн үнэ цэн болон эдийн засгийн үнэ цэний хоорондох үнэлгээний зөрүүг ойлгоно.

12.2.6.Банк нь хамгийн багадаа энэ журмын Гуравдугаар хавсралтын Бүлэг 1-т заасан өөрийн хөрөнгийг тодорхойлж, тайлагнана.

### **12.3.Дотоод өөрийн хөрөнгийн ил тод байдал**

12.3.1.Банк нь дотоод өөрийн хөрөнгийн талаарх мэдээллийг ил тод байлгаж, норматив болон эдийн засгийн хандлагын дагуу тодорхойлсон дотоод өөрийн хөрөнгийн ялгаатай, ижил төстэй байдлыг харьцуулна.

12.3.2.Банк нь хамгийн багадаа энэ журмын Гуравдугаар хавсралтын Бүлэг 4 (нийт өөрийн хөрөнгийн шаардлага)-т заасны дагуу дотоод өөрийн хөрөнгийг тодорхойлж, тайлагнана.

## **13.Стресс тест**

### **13.1.Стресс тестийн зарчим**

13.1.1.Банк нь макро эдийн засаг, санхүүгийн хүндрэлт нөхцөл байдлын үед банкны бизнес загвар, үйл ажиллагааны орчноос шалтгаалан банкны хэмжээнд үүсэж болзошгүй бүх материаллаг эрсдэлүүдийг хамруулан эмзэг байдлын нарийвчилсан дүн шинжилгээг хамгийн багадаа жилд 1 удаа, шаардлагатай тохиолдолд 1-ээс олон удаа гүйцэтгэнэ.

13.1.2.Банк нь дээрх үнэлгээнд үндэслэн зохих стресс тестийн аргачлалыг боловсруулна.

### **13.2.Стресс тестийн сценариуд**

13.2.1.Банк нь стресс тестийн хүрээнд сөрөг сценариудыг тодорхойлно.

13.2.2.Банк нь макро эдийн засгийн сөрөг, биелэх боломжтой сценариуд, голлох эмзэг байдалд үндэслэн банкны дотоод өөрийн хөрөнгө, өөрийн хөрөнгийн доод шаардлага, нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгийн хүрэлцээний зохистой харьцааны үзүүлэлтэд үзүүлэх материаллаг хэмжээний нөлөөллийг үнэлнэ.

13.2.3.Банк нь хувь тэнцүүлэх зарчмыг баримтлан урвуу стресс тестийг хийж гүйцэтгэнэ.

13.2.4.Банк нь шинэ аюул, эмзэг байдал, орчны өөрчлөлтийг тогтмол хянаж, тодорхойлох бөгөөд стресс тестийн сценариуд нь зохистой хэвээр байгаа эсэхийг улирал тутам шалгаж, зохисгүй тохиолдолд шинэ нөхцөл байдалд тохируулан сценариудад холбогдох өөрчлөлтийг оруулна.

13.2.5.Банк нь сценариудын нөлөөллийг тогтмол буюу хамгийн багадаа улирал тутам шинэчилж, банкны салбарт материаллаг хэмжээнд нөлөөлж болзошгүй хүндрэлт нөхцөл байдал үүсэх бүрд нэн даруй нөлөөллийг шинээр үнэлнэ.

13.2.6.Банк нь материаллаг өөрчлөлтүүд үүсэх бүрд тэдгээрийн өөрийн хөрөнгийн хүрэлцээнд үзүүлэх боломжит нөлөөллийг үнэлнэ.

13.2.7.Банк нь стресс сценариуд бодон эмзэг байдлаа дотооддоо тодорхойлохдоо түүхэн болон таамагласан стресс үйл явдлуудын талаарх мэдээллийг ашиглахаас гадна хяналт шалгалтын стресс тестийг ашиглаж болно.

13.2.8.Банк нь хяналт шалгалтын стресс тестийг ашигласан тохиолдолд банкны нөхцөл байдалд хамгийн сайн тохирсон сценариудыг тодорхойлж, эрсдэл, алдагдал, өөрийн хөрөнгийн тооцоололд тусгана.

### **13.3.Сценариудын хүндрэлт байдлын түвшин**

13.3.1.Банк нь стресс тест хийхдээ суурь болон сөрөг сценариудыг ашиглана.

13.3.2.Банк нь суурь үнэлгээний хүрээнд бизнесийн стратеги, орлого, зарлага, эрсдэлийн биелэх магадлал зэрэг баталгаатай таамаглалуудыг ашиглан хүлээгдэж байгаа нөхцөл байдлын төсөөллийг хийж гүйцэтгэнэ.

13.3.3.Норматив талаас сөрөг сценариудыг тодорхойлохдоо банк нь өөрийн хөрөнгийн доод шаардлага, тэр дундаа нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгийн хүрэлцээний зохистой харьцаанд нөлөөлөх онцгой, биелэх боломжтой өөрчлөлтүүдийг авч үзнэ.

13.3.4.Сөрөг байдлын түвшин нь банкны биелэх боломжтой гэж үзсэн өөрчлөлтүүд болон хямралын үед ажиглагдаж болох аливаа нөхцөл байдал, банкны өөрийн хөрөнгийн хүрэлцээнд хамгийн ихээр нөлөөлөх хүчин зүйлсэд гарч болзошгүй аливаа өөрчлөлтүүдтэй нийцтэй байна.

13.3.5.Сөрөг сценариуд нь эдийн засгийн ноцтой хямрал, санхүүгийн шок, банкны онцлогтой холбоотой эмзэг байдал, томоохон харилцагчдад учирч болзошгүй эрсдэл, тэдгээрийн хооронд үүсэж болзошгүй хамаарлыг хамарсан байна.

13.3.6.Банк нь стресс тестийг хийж гүйцэтгэхдээ хамгийн багадаа Монголбанкнаас тодорхойлсон стандарт шок сценарийг ашиглана.

13.3.7.Банк нь стандарт шок сценарийн макро эдийн засгийн таамаглалыг дараах 4 хувьсагчид үндэслэн хийж гүйцэтгэнэ:

13.3.7.1.Хувьсагч 1: Дотоодын нийт бүтээгдэхүүн (ДНБ)-ий өөрчлөлт;

13.3.7.2.Хувьсагч 2: Хэрэглээний үнийн индекс (ХҮИ)-ийн өөрчлөлт;

13.3.7.3.Хувьсагч 3: Төгрөгийн ханшийн өөрчлөлт;

13.3.7.4.Хувьсагч 4: Ажилгүйдлийн түвшний өөрчлөлт.

13.3.8.Монголбанкнаас Хувьсагч 1, 2-ын таамаглалыг жил бүр банкуудад хүргүүлнэ.

13.3.9.Хувьсагч 3 болон 4-ийн таамаглалыг банк бие даан тодорхойлно.

13.3.10.Банк нь балансыг динамик гэж үзэн 3-аас доошгүй жилийн хугацааг хамарсан стресс тестийг хийж гүйцэтгэх бөгөөд олон төрлийн эрсдэлүүдэд хамаарах



дүнгийн өсөлтийн таамаглалууд, тэр дундаа зээлийн эрсдэлийн багцын өсөлтийн таамаглалыг оруулна.

### **13.4. Урвуу стресс тест**

13.4.1. Банк нь урвуу стресс тестийг жилд 1-ээс доошгүй удаа хийж гүйцэтгэнэ.

13.4.2. Урвуу стресс тестийн хүрээнд урьдчилан таамаглах боломжтой үр дүн, өөрчлөлтүүдийг тодорхойлно.

13.4.3. Урвуу стресс тестийг ИСААР-н хүрээнд ашиглагдаж байгаа таамаглалуудын зохистой байдал, хатуу шалгуурын зарчимд нийцтэй байдлыг шалгах зорилгоор ашиглана.

## **ГУРАВДУГААР БҮЛЭГ. ИЛААР-Н БҮРЭЛДЭХҮҮН ХЭСГҮҮД**

### **14. ИЛААР-н зорилго**

#### **14.1. ИЛААР-н зарчим**

14.1.1. Банкны хөрвөх чадварыг дотооддоо үнэлэх аргачлал (ИЛААР) гэж банк Монголбанкнаас тогтоосон төлбөр түргэн гүйцэтгэх чадварын шаардлагыг хангах болон банкны хөрвөх чадвар, санхүүжилтийн эрсдэлийг үнэлэх хүрээнд гүйцэтгэж байгаа хөрвөх чадварыг тодорхойлох, хэмжих, удирдах, хянах үйл явцыг хэлнэ.

14.1.2. ИЛААР-н хүрээнд банкны үйл ажиллагааг эрсдэлийн хүлээн зөвшөөрөх хэмжээнд явуулах зорилгоор хөрвөх чадварын болон санхүүжилтийн эрсдэлийг хэмжих, удирдах дотоод тогтолцоотой холбоотой бүх төрлийн мэдээллийг боловсруулж ажиллана.

14.1.3. ИЛААР-н зорилго нь банкны үйл ажиллагааны тасралтгүй, найдвартай байдлыг хангахад дэмжлэг үзүүлэх хүрээнд удаан хугацаанд үргэлжлэх хүндрэлийн турш эрсдэл дааж, тогтвортой стратегийн дагуу харилцагчдад хүлээсэн үүргээ биелүүлэхэд хангалттай хөрвөх чадварыг бий болгоход оршино.

14.1.4. Банк нь үйл ажиллагааны тасралтгүй байдлыг хангах зорилгыг эрсдэл хүлээн зөвшөөрөх тогтолцоондоо тусгаж, эрсдэлийн ерөнхий түвшин болон өөрсдийн эмзэг, сул байдлыг харгалзан эрсдэл хүлээн зөвшөөрөх хэмжээг тохируулахад ИЛААР-н тогтолцоог ашиглана.

14.1.5. Банк нь Монголбанкнаас тавьсан төлбөр түргэн гүйцэтгэх чадварын доод шаардлагыг хангахаас гадна банкны стратегийг тогтвортой хэрэгжүүлэхэд хүрэлцэхүйц хөрвөх чадвартай хөрөнгөтэй эсэхийг үнэлж, тодорхойлно.

14.1.6. Хөрвөх чадвартай хөрөнгийн нөөц нь гадаад хүчин зүйлсээс гадна ирээдүйд учирч болзошгүй тодорхойгүй нөхцөл байдал, хөрвөх чадварын харьцаа үзүүлэлтүүдийн болзошгүй хэлбэлзлийн нөлөөллийг бууруулах, банкны эрсдэл хүлээн

зөвшөөрөх хэмжээг тогтоох, бизнесийн шийдвэр гаргахад уян хатан нөхцөл байдал бүрдүүлэх ач холбогдолтой.

#### **14.2.ИЛААР-н хүрээнд банкны хүлээх үүрэг, хариуцлага**

14.2.1.Банк нь ИЛААР-н тайланг жилд 1-ээс доошгүй удаа боловсруулж, ТУЗ-өөр батлуулна.

14.2.2.Банкны хөрвөх чадварыг дотооддоо үнэлэх аргачлал нь иж бүрэн, хатуу шалгууруудад тулгуурласан байх бөгөөд банкны хөрвөх чадварын үзүүлэлтүүд нь банкны эрсдэлийн төлөвтэй нийцсэн эсэхийг Монголбанканд тайлагнах үүрэгтэй.

14.2.3.Банк нь Монголбанкнаас тавьж байгаа шаардлага, зохицуулалт болон ТУЗ-өөс баталсан стратегийн болон үйл ажиллагааны төлөвлөгөөтэй нийцсэн ИЛААР-тай байна.

#### **14.3.ИЛААР-н үйл ажиллагааны зорилго**

14.3.1.ИЛААР нь дараах зорилготой байна:

14.3.1.1.банкны зохистой засаглал болон эрсдэлийн удирдлагыг сайжруулах;

14.3.1.2.төлбөр түргэн гүйцэтгэх чадварыг хангахад шаардлагатай хөрвөх чадвартай хөрөнгийн хэмжээг тогтоож, хөрвөх чадвартай хөрөнгийн эх үүсвэрийг тодорхойлоход дэмжлэг үзүүлэх;

14.3.1.3.банкны ТУЗ-ийн түвшинд банкны стратеги, бизнес төлөвлөгөө, эрсдэлийн түвшинтэй уялдуулан хөрвөх чадварын шаардлагыг үнэлэх.

14.3.2.ИЛААР-н тайлан нь банкны Гүйцэтгэх удирдлагын зүгээс банкны хөрвөх чадварын эрсдэлийн төлөв, хөрвөх чадварын эрсдэлийн хүлээн зөвшөөрөх хэмжээ, стратеги төлөвлөгөө болон хөрвөх чадварын хүрэлцээний талаарх мэдээллийг банкны ТУЗ болон Монголбанканд тайлагнах үндсэн баримт бичиг байна.

14.3.3.ИЛААР-н тайланд хөрвөх чадварын эрсдэлийн тогтолцоо болон банканд шаардагдах хөрвөх чадвартай хөрөнгийн хэмжээг тусгасан байна.

### **15.Стратегийн болон хөрвөх чадварын төлөвлөгөө**

#### **15.1Стратегийн шийдвэр гаргалт**

15.1.1.ИЛААР нь стратегийн шийдвэр гаргалтыг дэмжихээс гадна банкны өдөр тутмын үйл ажиллагаанд хөрвөх чадвартай хөрөнгийг зохих хэмжээнд байнга төвлөрүүлж байгаа эсэхийг баталгаажуулахад чиглэж, банкны эрсдэлийн түвшин болон хөрвөх чадварын шаардлага хоорондын тэнцвэртэй байдлыг хангахад дэмжлэг үзүүлнэ.

15.1.2.Стратегийн болон үйл ажиллагааны хөрвөх чадварын удирдлагын хүрээнд ашиглаж байгаа арга аргачлалыг зохих түвшинд баталж, хянах бөгөөд ИЛААР тайлан болон холбогдох баримт бичигт тусгана.

15.1.3.ИЛААР-н тоон болон чанарын үзүүлэлтүүд нь хоорондоо болон банкны бизнесийн стратеги, эрсдэлийн хүлээн зөвшөөрөх хэмжээтэй уялдсан байна.

### **15.2.Хөрвөх чадварын төлөвлөлт, хөрвөх чадвартай хөрөнгийн нөөц**

15.2.1.Банк нь банкны хөрвөх чадвартай хөрөнгийн нөөц болон тогтвортой эх үүсвэрийн үнэлгээг эдийн засгийн нөхцөл байдалтай уялдуулан хийж, хөрвөх чадварын төлөвлөлтийг гүйцэтгэнэ.

15.2.2.Банкны хөрвөх чадвартай хөрөнгийн нөөц нь зах зээл дээрх хөрвөх чадвартай хөрөнгийн хүрэлцээ болон банкны эрсдэлийн тоон үзүүлэлтүүдтэй нийцтэй байна.

15.2.3.Хөрвөх чадвартай хөрөнгийн нөөц нь зохистой, хатуу шалгуураар тодорхойлсон сайн чанарын хөрөнгүүдээс бүрдэнэ. Банкны тасралтгүй үйл ажиллагааг хангахын тулд банканд учирч болзошгүй эрсдэлүүдийг хаахад хүрэлцэхүйц хэмжээний хөрвөх чадвартай хөрөнгийн нөөцтэй болохыг Монголбанканд тайлагнана.

15.2.4.Банкны бизнесийн үйл ажиллагааг урт хугацаанд найдвартай хангахын тулд хөрөнгийг тогтвортой эх үүсвэрээс бүрдүүлэх шаардлагатай.

### **15.3.ИЛААР болон санхүүжилтийн нөөц төлөвлөгөө хоорондын уялдаа**

15.3.1.Санхүүжилтийн нөөц төлөвлөгөө нь банкны санхүүгийн нөхцөл байдал хүндэрсний дараа түүнийг сэргээх чиглэлээр авах арга хэмжээнүүдийг тодорхойлно.

15.3.2.Хөрвөх чадварын дутагдал буюу хөрвөх чадвартай хөрөнгийн хомсдол нь бизнесийн тасралтгүй, тогтвортой үйл ажиллагаанд нөлөөлөх голлох эрсдэл болох тул ИЛААР болон санхүүжилтийн нөөц төлөвлөгөө нь эрсдэлийн удирдлагын тогтолцооны бүрэлдэхүүн хэсгүүд байна.

15.3.3.Банк ИЛААР-г санхүүжилтийн нөөц төлөвлөгөөтэй уялдуулах бөгөөд банкнаас тогтоосон урьдчилан дохиологч индикаторууд, удирдлагыг мэдээллээр хангах үйл явц, удирдлагаас авч хэрэгжүүлэх боломжит арга хэмжээнүүдийг тусгана.

15.3.4.Материаллаг нөлөөтэй ИЛААР-н удирдлагын арга хэмжээг цаг алдалгүйгээр дор бүр нь санхүүжилтийн нөөц төлөвлөгөөнд тусгаж (эсрэг тохиолдолд мөн ижил), холбогдох баримт бичгүүдэд тусгасан арга хэмжээнүүдийн хоорондын уялдаа холбоог хангаж, тогтмол шинэчилнэ.

15.3.5.ИЛААР тайлан дахь санхүүжилтийн нөөц төлөвлөгөө нь хамгийн багадаа дараах 3 бүрэлдэхүүн хэсгүүдийг агуулсан байна:

15.3.5.1.**Засаглал:** Санхүүжилтийн нөөц төлөвлөгөөг хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий хороод, эрх бүхий болон хэрэгжүүлэгч албан хаагчид, төлөвлөгөөг хэрэгжүүлж эхлүүлэх нөхцөл болон хэрэгжүүлэх үйл явц.

15.3.5.2.**Хяналтын үзүүлэлтүүд:** Санхүүжилтийн нөөц төлөвлөгөөг хэрэгжүүлэх үндэслэл болох хөрвөх чадварын хүндрэлийн үзүүлэлтүүдийн тухай тайлбар.

15.3.5.1.**Санхүүжилтийн хувилбарууд:** Банкны төлбөр түргэн гүйцэтгэх чадварыг сайжруулах чиглэлээр нэн даруй хэрэгжүүлэх боломжтой арга хэмжээнүүд, тухайлбал, бусад байгууллагатай байгуулсан нээлттэй санхүүжилтийн шугамыг идэвхжүүлэх, хөрөнгө худалдах, банкны хувьцаа эзэмшигч батлан даагчийн үүргээ гүйцэтгэх болон бусад богино хугацаанд эх үүсвэр татах санхүүжилтийн хувилбаруудыг тусгана. Дунд болон урт хугацаанд санхүүжилт татах арга хэмжээнүүд нь хүндрэлийн үед авч хэрэгжүүлэх санхүүжилтийн арга хэрэгсэлд тооцогдохгүй тул санхүүжилтийн нөөц төлөвлөгөөнд оруулахгүй.

## **16.Эрсдэлийг тодорхойлох, тооцоолох, удирдах**

### **16.1.Эрсдэлийг тодорхойлох**

16.1.1.Банк нь эдийн засгийн болон норматив хандлагыг хамарсан, банкны үйл ажиллагааны онцлогт нийцтэй, цогц байдлаар эрсдэлийг тодорхойлно.

16.1.2.Банк нь өөрт учирч байгаа эрсдэлүүдээс гадна банкны стратегийг хэрэгжүүлэх, үйл ажиллагааны орчинд гарах өөрчлөлтөөс шалтгаалан үүсэж болзошгүй аливаа эрсдэл, тухайн эрсдэлийн болон эрсдэл хоорондын төвлөрлийг тооцон ирээдүйд чиглэсэн хөрвөх чадварын хүрэлцээний үнэлгээг гүйцэтгэнэ.

### **16.2.Тооцооллын аргачлалүүд**

16.2.1.Банк одоогийн хүлээж байгаа болон ирээдүйд учирч болзошгүй эрсдэлүүдийг зохистой түвшинд тооцоолно.

16.2.2.Банк нь эрсдэлийг тодорхойлохдоо аливаа эрсдэлийг бууруулах арга хэмжээний нөлөөллийг харгалзахгүйгээр буюу цогц аргачлал (gross approach)-ыг баримтална.

16.2.3.Банк нь эрсдэлийг бууруулах хүрээнд хэрэгжүүлэх эсхүл хэрэгжүүлсэн арга хэмжээний үр нөлөөг үнэлнэ.

16.2.4.Банк нь эрсдэлийг тооцоолох чиглэлээр дараах үүргийг хүлээнэ:

16.2.4.1.банк нь өөрийн эрсдэлийн хүлээн зөвшөөрөх хэмжээ, зах зээлийн хүлээлт, бизнес загвар, эрсдэлийн төлөв, активын хэмжээ болон нарийн төвөгтэй байдал зэрэг банкны онцлогт тохирсон эрсдэлийг тооцоолох арга, аргачлалыг ашиглах;

16.2.4.2.чухал ач холбогдол бүхий бүх мэдээллийг харгалзан эрсдэлийг консерватив байдлаар тодорхойлох;

16.2.4.3.эрсдэлийг тооцоолох арга хэрэгслийг сонгохдоо зохистой, тууштай байдлыг хангах;

16.2.4.4.гол параметрууд болон нөхцөлүүд нь итгэх түвшин болон сценарт ашигласан таамаглалуудыг хангах.

### **16.3.Хөрвөх чадварын эрсдэлийн удирдлага**

16.3.1.Хөрвөх чадварын эрсдэлийн удирдлагын хүрээнд дор дурдсан үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

16.3.1.1.өдөр тутмын хөрвөх чадварын хэрэгцээг хянах, хөрвөх чадвартай хөрөнгө бүрдүүлэх эх үүсвэрүүдийг тодорхойлох, банкны өдөр тутмын төлбөр түргэн гүйцэтгэх чадварыг хангахын тулд тухайн эх үүсвэрээс хөрөнгө татан төвлөрүүлэх боломжийг үнэлэх, төлбөр түргэн гүйцэтгэх чадварт материаллаг нөлөө үзүүлж болзошгүй үйл явдлуудыг таамаглан, хариу арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлэх зэргээр өдөр тутмын хөрвөх чадварын эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх;

16.3.1.2.Монголбанкнаас төлбөр түргэн гүйцэтгэх чадварыг дэмжих зээл авах болон бусад хэлбэрээр зах зээл дээрээс эх үүсвэр татах боломжийг үнэлж, хянах;

16.3.1.3.энгийн нөхцөлд болон хөрвөх чадвартай хөрөнгө хомсодсон үед хөрвөх чадвартай хөрөнгийн зах зээлийн үнэлгээ, тэдгээрийн мөнгөн хөрөнгөд хөрвөх чадварыг харгалзан хөрөнгийн удирдлагыг хэрэгжүүлэх;

16.3.1.4.хугацаагүй хадгаламжийг хамгийн багадаа дунджаар 30 хоног, хугацаатай хадгаламж болон бусад эх үүсвэрийн хувьд банкны дотоод журамд заасан хугацаатай эх үүсвэрийг төвлөрүүлж, эх үүсвэрийн удирдлагыг хэрэгжүүлэх;

16.3.1.5.дараа өдрийн болон тогтсон хугацаа (хамгийн багадаа 1-ээс 5 хоног, долоо хоног, 2 долоо хоног, 1 сар, 3 сар, 6 сар, 1 жил) бүрээр банкны актив, пассивын эргэн төлөгдөх хугацааны тайланг боловсруулж, мөнгөн хөрөнгийн орох болон гарах урсгалын зөрүүг тооцоолсон мөнгөн хөрөнгийн удирдлага хэрэгжүүлэх;

16.3.1.6.үйл ажиллагааны хэвийн нөхцөлд болон хөрвөх чадвартай хөрөнгө хомсодсон үед төлбөр түргэн гүйцэтгэх чадварыг хангахад шаардагдах эх үүсвэрүүдийг үнэлэх замаар хөрвөх чадвартай хөрөнгийн эх үүсвэрийн удирдлагыг хэрэгжүүлэх;

16.3.1.7.урьдчилан дохиологч индикаторууд, тэдгээрт харгалзах хяналтын үзүүлэлтүүд, хариу арга хэмжээ бүхий тогтолцоог бүрдүүлэх.

## **17.Хараат бус баталгаажуулалт**

### **17.1.Дотоод хяналт**

17.1.1.ЦААР-д хамгийн багадаа жилд 1 удаа, дараах хүрээг хамарсан дотоод хяналтыг гүйцэтгэнэ:

17.1.1.1. ILAAP-н үр дүнгийн хэрэгжилт, стресс тестийн аргачлал, эрсдэлийг оновчтой тодорхойлсон байдал, тоон мэдээллийн нэгтгэл зэргийг хамарсан тоон болон чанарын үзүүлэлтүүд;

17.1.1.2. шинэ зах зээлд нэвтрэх, шинэ үйлчилгээ үзүүлэх, шинэ бүтээгдэхүүн гаргах, эсвэл банкны дотоод бүтцэд өөрчлөлт орох зэрэг материаллаг өөрчлөлтүүдийг ILAAP-д тухай бүр тусгаж, тэдгээрийг хянах урьдчилан тодорхойлсон аргачлалыг бүрдүүлэх;

17.1.1.3. буцаан тестлэх (back-testing), ILAAP-н үр дүн болон таамаглал, нөхцөлүүд (тухайлбал, хөрвөх чадварын төлөвлөлт, сценариуд, эрсдэлийн тооцоолд ашиглаж байгаа нөхцөлүүд)-ийн оновчтой байдлыг үнэлэх;

17.1.1.4. банк нь эрсдэлийн материаллаг байдал болон эрсдэлийг тооцоолох аргачлалын нарийн төвөгтэй байдлыг харгалзан ILAAP-н эрсдэлийг тооцоолох аргачлалд хараат бус баталгаажуулалтыг тогтмол гүйцэтгэнэ;

17.1.1.5. банк нь баталгаажуулалтын үр дүнг банкны Гүйцэтгэх удирдлага болон ТУЗ-д тайлагнаж, эрсдэлийг тооцоолох аргачлалуудад тогтмол хяналт тавих, тэдгээрт өөрчлөлт оруулах болон хөрвөх чадварын хүрэлцээг үнэлэхэд ашиглана.

## **18. Стресс тест**

### **18.1. Стресс тестийн аргачлал**

18.1.1. Банк нь Монголбанкнаас тогтоосон стресс тестийн шаардлагатай нийцүүлж, дор дурдсан нөхцөлүүдийг харгалзан бүрэн хэмжээний стресс тестийг гүйцэтгэнэ:

18.1.1.1. банк нь олон төрлийн сөрөг, биелэх боломжтой сценариудыг боловсруулж, тэдгээрийн банкны мөнгөн урсгал, хөрвөх чадвартай хөрөнгийн эх үүсвэрүүд, ашигт ажиллагаа, төлбөрийн чадвар, худалдан борлуулах, өмчлөлийг өөрчлөхийг хориглосон хөрөнгүүд болон банкны тогтвортой байдлыг хангахын тулд эрсдэлийг үр дүнтэй удирдах хугацаа (survival horizon)-нд үзүүлэх нөлөөллийг үнэлэх;

18.1.1.2. банкны эх үүсвэрийн эмзэг байдлыг тодорхойлох сценариудыг сонгох. Банк нь эмзэг байдлын нарийвчилсан дүн шинжилгээ хийх бөгөөд сценариуд нь банкны бизнес загвар болон макро эдийн засаг, санхүүгийн салбарын хүндрэлийн үеийн нөхцөл байдлаас шалтгаалан банканд үүсэж болзошгүй бүх төрлийн материаллаг эрсдэлүүдийг илрүүлэхээр зохиогдсон байна;

18.1.1.3. сценариудын оновчтой байдлыг тогтмол буюу хамгийн багадаа жилд 1 удаа, шаардлагатай тохиолдолд 1-ээс олон удаа үнэлнэ. Банк нь зохих стресс тестийн аргачлалыг норматив болон эдийн засгийн хандлагын хүрээнд боловсруулна;

18.1.1.4. банк стресс тестийн хүрээнд норматив болон эдийн засгийн талаас сөрөг сценариудыг тодорхойлох бөгөөд банкны гүйцэтгэдэг бусад төрлийн стресс тестийг мөн харгалзана;

18.1.1.5.банк нь хувь тэнцүүлэх зарчмыг баримтлан урвуу стресс тестийг хийж гүйцэтгэнэ;

18.1.1.6.банк нь шинэ аюул, эмзэг байдал, орчны өөрчлөлтийг тогтмол хянаж, тодорхойлох бөгөөд стресс тестийн сценариуд нь зохистой хэвээр байгаа эсэхийг шалгаж, зохисгүй тохиолдолд шинэ нөхцөл байдалд тохируулан сценариудад холбогдох өөрчлөлтийг оруулна;

18.1.1.7.банк нь сценариудын нөлөөллийг тогтмол шинэчилж, сценариудтай холбоотой материаллаг өөрчлөлтүүд үүсэх бүрд тэдгээрийн хөрвөх чадварт үзүүлэх боломжит нөлөөллийг үнэлнэ.

18.1.2.Стресс тестэд ашигласан сценариудын хатуу шалгуурын зарчимд нийцтэй байдал буюу хатуу шалгуурууд, банкны ашигласан таамаглал, нөхцөлүүдийг ИЛААР-д дэлгэрэнгүй тусгаж, Монголбанканд тайлагнана.

18.1.3.Банк нь хамгийн багадаа 5 хоног дараалан харилцах, хадгаламж их хэмжээгээр татагдсан тохиолдолд төлбөр түргэн гүйцэтгэх чадвар зохих түвшин хадгалагдах эсэхийг тооцоолох стресс тестийг Монголбанкнаас тогтоосон нөхцөлүүдийн дагуу хийж гүйцэтгэнэ.

18.1.4.Монголбанкнаас хөрвөх чадварын стресс тестийн нөхцөлүүдийг жил бүр банкуудад хүргүүлнэ.

18.1.5.Банк нь тухайн банканд болон зах зээлд үүсэх шокийн үед өдөр бүрийн эцэст нөхцөл байдлыг үнэлж, хөрвөх чадварын дутагдал үүсэхээр байх тохиолдолд төлбөр түргэн гүйцэтгэх чадварыг сайжруулах чиглэлээр авч хэрэгжүүлэх боломжит арга хэмжээнүүдийг тайлбарлах шаардлагатай.

--oOo--

“Банкны өөрийн хөрөнгийн хүрэлцээ болон хөрвөх чадварын хүрэлцээг дотооддоо үнэлэх аргачлалын журам”-ын Нэгдүгээр хавсралт

## ИСААР-Н ТАЙЛАНГ БОЛОВСРУУЛАХ ЗАГВАР

Банкны боловсруулах ИСААР-н тайлан нь дараах бүлгүүдийг багтаасан байна.

### БҮЛЭГ 1. ЗАСАГЛАЛЫН ЕРӨНХИЙ БҮТЭЦ

#### 1-р хэсэг. Бүтэц, зохион байгуулалт

- ТУЗ болон ТУЗ-ийн дэргэдэх хороодын бүрэлдэхүүн, үйл ажиллагааны талаарх мэдээлэл

#### 2-р хэсэг. ТУЗ, ТУЗ-ийн дэргэдэх хороодын үйл ажиллагаа

	Гишүүдийн тоо 31/12//XXXX	Тайлант жилд шинээр нэмэгдсэн гүшүүдийн тоо XXXX	Тайлант жилд хасагдсан гүшүүдийн тоо XXXX	Тайлант жилд хуралдсан тоо XXXX
ТУЗ				
Аудитын хороо				
Эрсдэлийн удирдлагын хороо				
Нэр дэвшүүлэх хороо				
Цалин урамшууллын хороо				

#### 3-р хэсэг. Засаглалын ерөнхий зарчим

- Банкны хэмжээнд хэрэгжүүлж байгаа “эрсдэлийн соёл”-ын бодлогын талаарх мэдээлэл: бизнес загвар болон эрсдэлийн ерөнхий төвшинг мэдээлэх үйл явц, энэ хүрээнд ажилтнуудад зориулсан сургалтын хөтөлбөрийн талаарх хураангуй мэдээлэл.
- Байгууллагаас мөрдүүлдэг ёс зүйн болон мэргэжлийн стандартуудын мэдээлэл (дотооддоо боловсруулсан стандарт эсвэл гадаад холбоо/байгууллагаас гаргасан стандарт эсэхийг тэмдэглэнэ), тэдгээрийн дотоод биелэлтийг хангахын тулд хэрэгжүүлж байгаа арга хэмжээний тайлбар, биелээгүй тохиолдолд авах арга хэмжээ, ТУЗ болон Гүйцэтгэх удирдлагад мэдэгдэх үйл явцын тайлбар.
- Байгууллага дахь ашиг сонирхлын зөрчлийг тодорхойлох, удирдах, урьдчилан сэргийлэх үйл явц, эдгээр асуудлуудыг илрүүлэн баталгаажуулах, хянах аргуудын тайлбар.



#### **4-р хэсэг. Засаглалтай холбоотой журмууд**

- Банкны стратегийг тодорхойлох журам
- Эрсдэлийн хүлээн зөвшөөрөх хэмжээ, эрсдэл даах чадварыг тодорхойлох журам
- Хязгаарыг тогтоох журам
- Ноцтой тохиолдлын талаар дээд шатны удирдлагад (ТУЗ болон Гүйцэтгэх удирдлага) мэдэгдэх журам
- Залруулах арга хэмжээг дагаж мөрдөөгүй талаар тогтмол хяналт шалгалт хийх чиг үүрэг бүхий нэгжээс дээд шатны удирдлагад мэдэгдэх журам
- Дээд шатны удирдлагад танилцуулсан дотоод хяналтын дүгнэлт
- Зохистой засаглалын зарчмын хэрэгжилтийг хянах, үр дүнг тогтмол үнэлэх журам
- Эрсдэлийн стратеги, бодлогыг батлах, тогтмол хянах журам
- Байгууллагын үр дүнтэй, зохистой удирдлагын тогтолцоог бүрдүүлэх үүднээс дотоод хяналтын тогтолцооны чиг хандлагыг тодорхойлох, хэрэгжилтэд хяналт тавих журам
- Цалин урамшууллын бодлого, түүнийг хэрэгжүүлэх ерөнхий зарчмыг батлах, хянах журам
- Зохицуулагч байгууллагаас дотоод хяналтын тогтолцооны үйл ажиллагаа, үр дүнг тайлант жилд хянасан огноо
- Эрсдэлийн удирдлагын хороотой хуралдсаны үндсэн дээр ТУЗ-өөс нийт эрсдэлийн хязгаарыг хянасан огноо.

## БҮЛЭГ 2. БИЗНЕС ЗАГВАРЫН ЗАСАГЛАЛ

	Энэ асуудлыг хэлэлцэх ТУЗ-ийн хурлын тов	Хуралд оролцсон ТУЗ-ийн гишүүдийн тоо
Хурал 1		
Хурал 2		
Хурал ...		

### 1-р хэсэг. Эрхэлж байгаа бизнесийн танилцуулга

- Эрхэлж байгаа бизнес(үүд)-ийн үйл ажиллагааны ерөнхий танилцуулга: үйл ажиллагааны төрөл, онцлог шинж чанарууд (актив, хадгаламж, зээлийн төрөл, харилцагчийн төрөл, төвлөрлөөр нь ангилах, актив болон пассивын хүүгийн бүтэц, зах зээлийн гүйлгээний хэмжээ (гадаад валют, хүү, өмч хөрөнгө, бараа бүтээгдэхүүн) үйл ажиллагааны эрсдэлийн зорилт гэх мэт), зах зээлийн төрөл, хэмжээ, чиг хандлага, ашигт ажиллагааны зорилт, эдийн засгийн өөрийн хөрөнгө болон хөрвөх чадвартай хөрөнгийн зарцуулалтын хүрээнд тавьсан зорилт, онцлог эрсдэлүүд, өнгөрсөн 3 жилийн хугацаан дахь ТУЗ-ийн зорилтын биелэлтийн түвшин. Банк нь хамгийн багадаа доорх хүснэгтэд харуулсан мэдээллийг нөлөө бүхий бизнесийн чиглэл (актив, пассивын 10-аас дээш хувь, эсвэл нийт орлого, ЭЖА-ын 10-аас дээш хувийг эзэлж байгаа бизнесийн чиглэл) тус бүрийн хувьд бөглөнө:

	Голлох чанарын шинжүүд	Үлдэгдэл дүн N	Ашиг (орлогоос хасах нь зардал) N-1	Ашиг (орлогоос хасах нь зардал) N	N-1 жилийн ЭЖА	N жилийн ЭЖА
Бизнесийн чиглэл 1						
Бизнесийн чиглэл 2						
Бизнесийн чиглэл Х...						

	Зорилтот ашиг N+1	Зорилтот ашиг N+3	Зорилтот үлдэгдэл дүн N+1	Зорилтот үлдэгдэл дүн N+3	Зорилтот ЭЖА N+1	Зорилтот ЭЖА N+3
Бизнесийн чиглэл 1						
Бизнесийн чиглэл 2						

Бизнесийн чиглэл Х...						
-----------------------	--	--	--	--	--	--

- ТУЗ-өөс шинээр эхлүүлэхээр шийдвэрлэсэн үйл ажиллагааны хувьд:
  - тайлант онд шинээр эхлүүлэхээр шийдвэрлэсэн үйл ажиллагааны талаарх дэлгэрэнгүй тайлбар (аж ахуйн нэгж, газар зүйн бүс, охин компаниар)
  - тэдгээр шинэ үйл ажиллагаанд зориулан тогтоосон журмуудын тойм
  - шинэ үйл ажиллагаанд тавигдах дотоод хяналтын тухай тайлбар
- ТУЗ-өөс баталсан бүтэц зохион байгуулалт, хүний нөөцийн томоохон өөрчлөлтүүд болон тайлант онд шинээр эхлүүлсэн болон хэрэгжүүлсэн томоохон төслүүдийн танилцуулга.

## **2-р хэсэг. Банкны эрхэлж байгаа бизнест үүсэх голлох эрсдэлүүдийн танилцуулга**

- Банкны эрсдэлийн зураглалыг батлах, шинэчлэх үйл явцын тухай тайлбар
- ТУЗ-өөс эрсдэлийн зураглалыг хянан баталгаажуулсан огноо
- ТУЗ-өөс баталсан эрсдэлийн стратегийн хүрээнд тодорхойлсон эрсдэлүүдийн жишгийг тогтоох, ТУЗ-өөс тогтоосон эрсдэлийн хүлээн зөвшөөрөх хэмжээнээс давсан эрсдэлийг бууруулах чиглэлээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тухай тайлбар.

## **3-р хэсэг. Эрсдэлийн стратеги болон эрсдэлийн бодлогын танилцуулга**

- Өндөр ач холбогдол бүхий эрсдэлүүдийг тодорхойлох, удирдах, хянах, бууруулах чиглэлээр ТУЗ-өөс баталсан үйл явцын тухай тайлбар (үүний оронд ТУЗ-ийн хурлын тэмдэглэлийн хуулбарыг ирүүлж болно)
- Гадаад бизнес, аутсорсинг гэх зэрэг байгууллагын түвшинд учирч байгаа олон түвшний эрсдэлүүдийн тухай мэдээллийг цуглуулах, хадгалах, нэгтгэх хүрээнд ТУЗ-өөс баталсан тогтолцоо, үйл явцын талаарх танилцуулга.

## **4-р хэсэг. ТУЗ-ийн зорилтууд**

- ТУЗ-өөс ойрын жилүүдэд (3-5 жилийн хэтийн төлөв) бизнесийн чиглэл тус бүрээр тодорхойлсон зорилтуудын танилцуулга: актив; хадгаламж татах; зээлийг төрөл, харилцагч болон төвлөрлөөр нь хуваарилах; актив, пассивын хүүгийн бүтэц; зах зээлийн гүйлгээний хэмжээ (валютын ханш, хүү, өөрийн хөрөнгө, бараа бүтээгдэхүүн), үйл ажиллагааны эрсдэлийн зорилт гэх мэт.

### БҮЛЭГ 3. ТУЗ-ӨӨС ТОГТООСОН ДОТООД ХЯНАЛТЫН ТОГТОЛЦООНЫ БҮТЭЭ

	Энэ асуудлыг хэлэлцэх ТУЗ-ийн хурлын тов	Хуралд оролцсон ТУЗ- ийн гишүүдийн тоо
Хурал 1		
Хурал 2		
Хурал ...		

#### 1-р хэсэг. Дотоод хяналтын тогтолцоо

- Дотоод хяналтын тогтолцооны үндсэн бүрэлдэхүүн хэсгүүдийн танилцуулга (тогтмол болон давтагддаг): хамгаалалтын 3 шугамын зохион байгуулалт, тайлагнах шугам, нөөц (хүний нөөц, мэдээллийн технологи гэх мэт), эрсдэлийг хянах аргачлал, сургалтын хөтөлбөр
- Дотоод аудит, дотоод хяналт, комплаенсийн чиг үүрэг бүхий нэгжүүдийн удирдлагуудын намтар
- Хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа дотоод хяналтын дүрмийн хуулбар
- Банкны эрсдэлийг тодорхойлох, нэгтгэх, бууруулах, хянах чадамж нь банкны хэмжээ, нарийн төвөгтэй байдал, эрсдэлийн ерөнхий түвшинтэй нийцэж байгаа эсэхийг баталгаажуулах зорилго бүхий бодлого, журам, үйл явц зэрэг банкны эрсдэлийн удирдлагын тогтолцооны тухай танилцуулга
- Аудитын дүрмийн хуулбар
- ТУЗ-өөс нөлөө бүхий өөрчлөлт оруулахаар шийдвэрлэсэн тохиолдолд:
  - Тусгайлсан болон байнгын хяналтыг зохион байгуулах хүрээнд гарсан томоохон өөрчлөлтүүдийн тухай танилцуулга. Үүнд дотоод хяналттай холбоотойгоор хэрэгжүүлэхээр төлөвлөж байгаа үндсэн арга хэмжээнүүд хамаарна.
  - Аудитын хороо болон Эрсдэлийн удирдлагын хорооны зохион байгуулалтад гарсан томоохон өөрчлөлтүүдийн тухай танилцуулга.
  - Үйл ажиллагааны хяналтын чиг үүрэг бүхий нэгжийн зохион байгуулалтад гарсан томоохон өөрчлөлтүүдийн тухай танилцуулга.
  - Эрсдэлийн удирдлагын чиг үүрэг бүхий нэгжийн зохион байгуулалтад гарсан томоохон өөрчлөлтүүдийн тухай танилцуулга.
  - Дотоод аудитын чиг үүрэг бүхий нэгжийн зохион байгуулалтад гарсан томоохон өөрчлөлтүүдийн тухай танилцуулга.

#### 2-р хэсэг. Комплаенсийн бодлого

	Энэ асуудлыг хэлэлцэх ТУЗ-ийн хурлын тов	Хуралд оролцсон ТУЗ- ийн гишүүдийн тоо
Хурал 1		

Хурал 2		
Хурал ...		

- Комплаенсийн чиг үүргийн хүрээнд ТУЗ-өөс баримталж байгаа стратеги
- Комплаенсийн нэгжийн зохион байгуулалтын тухай танилцуулга
- Комплаенсийн чиг үүрэгтэй хамаарал бүхий шинэ бүтээгдэхүүн гаргах /шинэ зах зээлд гарах/ үйл явцыг тодорхойлсон журмын танилцуулга
- Комплаенсийн нэгжид тохиолдлуудыг мэдээлэх үйл явцын тухай тайлбар (үүнд шүгэл үлээх үйл явц орно)
- Комплаенсийн нэгжээс байнгын болон тусгайлсан хяналт хийхтэй холбоотой журмын танилцуулга.

Комплаенсийн үйл ажиллагаанд хийсэн байнгын хяналтын үр дүн:

- Ажиглагдсан гол дутагдлууд
- Дутагдлуудыг арилгах хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, эдгээр арга хэмжээг хэрэгжүүлэхээр хүлээгдэж байгаа хугацаа, энэхүү тайлангийн төслийг боловсруулах өдрийн байдлаарх хэрэгжилтийн явцын байдал
- Байгууллагаас өгсөн үүрэг даалгаврыг хариуцсан этгээд нь зохих хугацаанд биелүүлсэн эсэхэд хяналт тавьсан байдал.

#### **БҮЛЭГ 4. ТУЗ-ӨӨС АУДИТЫН ҮР ДҮНД ТАВИХ ХЯНАЛТ**

	<b>Энэ асуудлыг хэлэлцэх ТУЗ-ийн хурлын тов</b>	<b>Хуралд оролцсон ТУЗ- ийн гишүүдийн тоо</b>
<b>Хурал 1</b>		
<b>Хурал 2</b>		
<b>Хурал ...</b>		

- Аудитын шалгалтын хуваарь (эрсдэл ба/эсвэл тухайн жилийн хугацаанд тусгайлсан хяналтад хамрагдсан нэгжүүд), гүйцэтгэлийн үе шат, хүн-хоногоор хуваарилсан нөөц, хөндлөнгийн гүйцэтгэгч этгээдийг ашиглаж байгаа тохиолдолд: хөндлөнгийн оролцооны давтамж, багийн хэмжээ.
- Сүүлийн 3 жилийн хугацаанд хийсэн аудитын шалгалтын жагсаалт.
- Илэрсэн гол дутагдлууд.
- Дутагдлуудыг арилгах хүрээнд ТУЗ-өөс хэрэгжүүлэхээр шийдвэрлэсэн арга хэмжээ, тэдгээрийг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн хугацаа, энэхүү тайлангийн төслийг боловсруулах өдрийн байдлаарх хэрэгжилт.
- Аудитын зөвлөмжүүдийг хэрэгжүүлсэн байдал (ашигласан арга хэрэгслүүд, хариуцсан албан тушаалтнууд) болон гарсан үр дүн.
- Урт хугацааны аудитын төлөвлөгөөний хэрэгжилтийн байдал.
- Урт хугацааны аудитын төлөвлөгөөнд хамгийн сүүлд хяналт хийж, засвар оруулсан байдал.

**БҮЛЭГ 5. ТУЗ-ӨӨС ГҮЙЦЭТГЭХ УДИРДЛАГА, ТУЗ-ИЙН ГИШҮҮД, НӨЛӨӨ БҮХИЙ ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИД, ХОЛБОГДОХ ЭТГЭЭДҮҮДТЭЙ ХИЙСЭН ХЭЛЦЭЛД ТАВИХ ХЯНАЛТ**

	Энэ асуудлыг хэлэлцсэн ТУЗ-ийн хурлын тов	Хуралд оролцсон ТУЗ-ийн гишүүдийн тоо
Хурал 1		
Хурал 2		
Хурал ...		

- Нөлөө бүхий хувьцаа эзэмшигчид, гүйцэтгэх удирдлага болон ТУЗ-ийн гишүүдтэй хийсэн хэлцлийн танилцуулга: зээлдэгчийн мэдээлэл, зээлдэгчийн төрөл (хувь хүн, хуулийн этгээд, хувьцаа эзэмшигч, гүйцэтгэх удирдлага эсвэл ТУЗ-ийн гишүүн эсэх), активын төрөл, олгосон дүн, эрсдэлээр жигнэсэн хувь, олгосон огноо, төлөгдөх огноо.
- Банк нь холбогдох этгээдтэй хийсэн хэлцлийн дүн, үлдэгдэл дүн, хугацаа, хүү зэргийг нарийвчлан тусгана. Холбогдох этгээдтэй хийсэн томоохон хэлцэлтэй холбоотойгоор банкны дунд хугацааны стратегийг хэрэгжүүлэхэд нэмэлт эдийн засгийн өөрийн хөрөнгө шаардлагатай болох тул тус хэлцлийг өөрийн хөрөнгийн төлөвлөлтөд харгалзан үзнэ (хувьцаа эзэмшигчийн оруулсан хөрөнгийг буцаад хувьцаа эзэмшигчид зээл олгосноор тухайн өөрийн хөрөнгийг хасагдсанд тооцож, банкны стратегийг хэрэгжүүлэхэд ашиглах боломжгүй гэж үзнэ). Банк нь холбогдох этгээдтэй хийсэн хэлцэл нь томоохон эсэхийг эрсдэлд суурилсан зарчимд үндэслэн тодорхойлно. Холбогдох этгээдтэй хийсэн хэлцэл нь тухайн банкны зохистой харьцаа болон эдийн засгийн нөхцөл байдалд материаллаг хэмжээний нөлөө үзүүлэхүйц бол “томоохон” гэж үзнэ. Тодруулбал:
  - Эдгээр хэлцлүүд нь чанаргүй ангилалд шилжсэн тохиолдолд банкны төлбөрийн чадвар эсвэл хөрвөх чадварт сөргөөр нөлөөлж болзошгүй<sup>4</sup>,
  - Банкны эх үүсвэрийн томоохон хэсгийг холбогдох этгээдэд зээл олгоход зориулснаас шалтгаалан банкны стратегийг хэрэгжүүлэх, эдийн засгийн өөрийн хөрөнгийг бүрдүүлэхэд саад учруулж болзошгүй.<sup>5</sup>

<sup>4</sup> Жишээлбэл, банкны төлбөрийн чадварын харьцаа 12.5% гэж үзвэл 0.5% -ийг төлөөлөх хэлцэл томоохонд тооцогдох бол төлбөрийн чадварын харьцаа 20% бол томоохонд тооцогдохгүй.

<sup>5</sup> Жишээлбэл, нийт өөрийн хөрөнгө 1000, ирэх 1 жилд шаардагдах эдийн засгийн өөрийн хөрөнгө 900 гэж үзвэл холбогдох этгээдэд олгосон аливаа хэлцэл эсвэл хэлцлүүдийн нийлбэр нь 100-тай тэнцүү эсвэл дээш бол томоохон гэж үзнэ.

## БҮЛЭГ 6. ЗЭЭЛИЙН ЭРСДЭЛИЙН БОДЛОГО

	Энэ асуудлыг хэлэлцэх ТУЗ-ийн хурлын тов	Хуралд оролцсон ТУЗ-ийн гишүүдийн тоо
Хурал 1		
Хурал 2		
Хурал ...		

### 1-р хэсэг. Эрсдэлийн хүлээн зөвшөөрөх хэмжээ болон эрсдэл даах чадвар

- Эрсдэлийн стратеги
- Эрсдэлийн хүлээн зөвшөөрөх хэмжээ болон эрсдэл даах хэмжээг өөрийн хөрөнгийн түвшинтэй уялдуулан тодорхойлсон байдал. ТУЗ-өөс баталсан Хүлээн зөвшөөрөх эрсдэлийн мэдэгдэл (RAS)-д банкны хүлээн зөвшөөрөх эрсдэлийн хэмжээг тусгасан байх шаардлагатай. Үүнийг эрсдэлийн хязгааруудаар илэрхийлж болох хэдий ч ICAAP-н хүрээнд эрсдэлийн хязгааруудыг өөрийн хөрөнгөтэй уялдуулан тооцно. Үүнийг мөн орлогын хэлбэлзэл (орлогын хэтийн төлөв)-ээр илэрхийлж болно.
- Хүлээн зөвшөөрөх эрсдэлийн мэдэгдэл (RAS)-ийг хамгийн багадаа жилд 1 удаа шинэчилнэ.

### 2-р хэсэг. Зээл олгох журам

- Урьдчилан тодорхойлсон зээл олгох шалгуур
- Зээл олгох журмын тайлбар (ангилал болон зээлийн хязгааруудын тухай мэдээллийг оруулна)
- Холбогдох этгээд болон ажилтнуудад зээл олгох бодлого

### 3-р хэсэг. Зээлийн эрсдэлийг хэмжих, хянах тогтолцоо

- Зээлийн чанарын шинжилгээ хийх журам, шинжилгээний давтамж, энэ талаар хамгийн сүүлд ТУЗ-д танилцуулсан тайлан
- Зээлийн эрсдэлийг хэмжихэд ашигласан стресс сценариуд, сонгосон таамаглал, үр дүн, тэдгээрийн уялдаа холбоо, хэрхэн үйл ажиллагаанд ашигласан тухай тайлбар
- Зээлийн эрсдэлийн хязгааруудын тухай ерөнхий тайлбар – зээлдэгчийн төрөл, олгосон зээлийн хэмжээ, бизнесийн чиглэлээр гэх мэт
- Зээлийн эрсдэлийн хязгааруудыг шалгах аргачлал болон давтамж (хамгийн сүүлд шалгасан огноог тусгана)
- Тайлант жилд зээлийн эрсдэлийн хязгаарууд зөрчигдсөн тохиолдол (зөрчигдсөн шалтгаан, холбогдсон талууд, нийт зээлийн хэмжээ, зөрчигдсөн тоо, дүн хэмжээ)
- Зээлийн эрсдэлийн хязгаарыг зөрчих зөвшөөрлийг олгосон үйл явц
- Зээлийн эрсдэлийн хязгаарын зөрчлийг арилгах хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ
- Зээлийн эрсдэлийг хянах, удирдах чиг үүрэг бүхий нэгжийн тодорхойлолт, боловсон хүчин, шаталсан бүтэц зохион байгуулалт болон чиг үүргийн хуваарилалтын тухай танилцуулга.

Зээлийн үйл ажиллагааны дотоод хяналт (тусгайлсан болон байнгын)-ын үр дүн:



- Илрүүлсэн гол дутагдлууд
- Дутагдлуудыг арилгах хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, тэдгээрийг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн хугацаа, энэхүү тайлангийн төслийг боловсруулах өдрийн байдлаарх хэрэгжилт.
- Тусгайлсан хяналтын үр дүнд гарсан зөвлөмжүүдийг хэрэгжүүлсэн байдал (ашигласан арга хэрэгслүүд, хариуцах албан тушаалтнууд гэх мэт).

## БҮЛЭГ 7. ТӨВЛӨРЛИЙН ЭРСДЭЛИЙН БОДЛОГО

	Энэ асуудлыг хэлэлцэх ТУЗ-ийн хурлын тов	Хуралд оролцсон ТУЗ-ийн гишүүдийн тоо
Хурал 1		
Хурал 2		
Хурал ...		

### 1-р хэсэг. Эрсдэлийн хүлээн зөвшөөрөх хэмжээ болон эрсдэл даах чадвар

- Эрсдэлийн стратеги
- Эрсдэлийн хүлээн зөвшөөрөх хэмжээ болон эрсдэл даах хэмжээг өөрийн хөрөнгийн түвшинтэй уялдуулан тодорхойлсон байдал. ТУЗ-өөс баталсан Хүлээн зөвшөөрөх эрсдэлийн мэдэгдэл (RAS)-д банкны хүлээн зөвшөөрөх эрсдэлийн хэмжээг тусгасан байх шаардлагатай. Үүнийг эрсдэлийн хязгааруудаар илэрхийлж болох хэдий ч ICAAP-н хүрээнд эрсдэлийн хязгааруудыг өөрийн хөрөнгөтэй уялдуулан тооцно. Үүнийг мөн орлогын хэлбэлзэл (орлогын хэтийн төлөв)-ээр илэрхийлж болно.
- Хүлээн зөвшөөрөх эрсдэлийн мэдэгдэл (RAS)-ийг хамгийн багадаа жилд 1 удаа шинэчилнэ.

### 2-р хэсэг. Төвлөрлийн эрсдэлийн хяналт

- Харгалзах талууд, эдийн засгийн салбар эсвэл улсаар нь төвлөрлийн эрсдэлийг хянах хүрээнд ТУЗ-д танилцуулсан байдал
- ТУЗ-өөс тогтоосон төвлөрлийн эрсдэлийн хязгаарууд
- Төвлөрлийн эрсдэлийн хязгааруудыг хянах үйл явц болон хянах давтамж
- Тайлант жилд хязгаарууд зөрчигдсэн тохиолдлууд
- Төвлөрлийн эрсдэлд өртөж байгаа активын хэмжээ

Төвлөрлийн эрсдэлийн тусгайлсан болон байнгын хяналтын үр дүн:

- Илрүүлсэн гол дутагдлууд
- Дутагдлуудыг арилгах хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, тэдгээрийг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн хугацаа, энэхүү тайлангийн төслийг боловсруулах өдрийн байдлаарх хэрэгжилт.
- Тусгайлсан хяналтын үр дүнд гарсан зөвлөмжүүдийг хэрэгжүүлсэн байдал (ашигласан арга хэрэгслүүд, хариуцах албан тушаалтнууд гэх мэт).
- Өгсөн үүрэг даалгаврыг хариуцсан этгээдүүд нь зохих хугацаанд биелүүлсэн эсэхэд хяналт тавьсан байдал.

Банк нь Базелын стандартын Бүлэг 2-ын төвлөрлийн эрсдэлийн өөрийн хөрөнгийн шаардлагыг хамгийн багадаа дараах аргачлалын дагуу тооцно. Бүлэг 2-ын төвлөрлийн эрсдэлийн өөрийн хөрөнгийн шаардлага нь хамгийн багадаа Салбарын төвлөрлийн индекс (SCI)-ээр хэмжигдэх салбарын төвлөрөлд шаардагдах өөрийн хөрөнгө байх бөгөөд нэмэлтээр банкнаас авч үзсэн бусад төвлөрлийн эрсдэлүүдэд харгалзах өөрийн хөрөнгийн шаардлага байж болно.

## Салбарын төвлөрлийн индекс (SCI)

Банк нь салбарын төвлөрлийн эрсдэлийг хэмжих болон энэ төрлийн эрсдэлд харгалзах өөрийн хөрөнгийн шаардлагыг тооцохдоо Салбарын төвлөрлийн индексийг (SCI) ашиглаж болно. SCI-г тооцоолохдоо банкны зээлийн багцын хэмжээгээр эхний 5 салбарт хамаарах байгууллагуудад олгосон зээлийн нийт дүнг авч үзнэ. SCI-г дараах томъёоны дагуу тооцоолно:

$$SCI = \frac{\sum x^2}{(\sum x)^2} \times 100$$

Үүнээс: x нь салбар тус бүрд харгалзах активын нийт үлдэгдэл дүнг илэрхийлэх (үнэт цаасыг оруулахгүй) ба эрсдэлийг бууруулах аливаа арга хэрэгслийг ашиглан бууруулаагүй дүн байна.

Энэхүү үлдэгдэл дүнд байгууллагуудад олгосон бүх актив, тухайлбал хямдруулсан худалдааны өрийн бичиг, зээлийн хөтөлбөр, зээл, өрийн хэрэгсэл, хувьцаа, балансын гадуурх зүйлс болон бусад бүх төрлийн зээлтэй адилтган тооцох актив орно.

Дээрх тэгшитгэлийн үр дүнд үндэслэн салбарын төвлөрлийн эрсдэлд харгалзах нэмэлт өөрийн хөрөнгийн шаардлагыг (МБЕ-ийн 2019 оны А-38 дугаар тушаалд заасан Бүлэг 1-ийн байгууллагын зээлийн эрсдэлээр жигнэх хувиар) SCI болон нэмэлт ЭЖА-д үндэслэн дараах хүснэгтийн дагуу тодорхойлно:

SCI (%)	Шаардлагатай нэмэлт ЭЖА (%)
$0 < SCI \leq 12$	0
$12 < SCI \leq 15$	2
$15 < SCI \leq 20$	4
$20 < SCI \leq 25$	6
$25 < SCI \leq 100$	8

### Тооцооллын жишээ:

Салбарууд (5 салбар)	Үлдэгдэл дүн	Үлдэгдэл дүнгийн квадрат зэрэг
1	130	16.900
2	200	40.000
3	340	115.600
4	200	40.000
5	100	10.000
Нийт үлдэгдэл дүн	1.000	
Үлдэгдэл дүнгийн квадрат зэргийн нийлбэр		222.500 (A)
Нийт үлдэгдэл дүнгийн квадрат зэрэг	1.000.000(B)	

$$(SCI) = A / B \times 100 = 22.50\%$$

Дээрх хүснэгтээс харахад SCI нь 22.50%- байгаа тул төвлөрлийн эрсдэлд шаардлагатай нэмэлт ЭЖА нь 6% байна (МБЕ-ийн 2019 оны А-138 дугаар тушаалд заасан Бүлэг 1-ийн байгууллагын зээлийн эрсдэлээр жигнэх хувиас тооцно).

### Нэг зээлдэгчийн төвлөрлийн индекс (ICI)

Банкнаас нэг зээлдэгчид олгосон зээл нь нийт зээлийн багцын 5 хувиас хэтэрсэн бөгөөд тэрхүү зээл нь SCI-г тооцоход авч үзсэн 5 том эдийн засгийн салбарт харьяалагдахгүй байгаа тохиолдолд нэг зээлдэгчийн төвлөрлийн эрсдэлд харгалзах нэмэлт өөрийн хөрөнгийн шаардлагыг тооцоолно. Дээр дурдсанаас бусад тохиолдолд ICI-г тооцох шаардлагагүй.

Энэхүү өөрийн хөрөнгийн шаардлагыг нийт зээлийн багцын 5 хувиас хэтэрсэн зээлүүдийн ICI-д үндэслэн тооцох ба SCI-н 5 том эдийн засгийн салбарт орсон зээлүүд үүнд хамаарахгүй.

ICI-г Херфиндалийн индексийг ашиглан дараах томъёоны дагуу тооцно:

$$ICI = \frac{\sum x^2}{(\sum \text{байгууллагын зээл})^2} \times 100$$

Үүнээс: x нь нийт зээлийн багцын 5 хувиас хэтэрсэн, SCI-д тооцсон 5 том эдийн засгийн салбарт харьяалагдаагүй байгууллагын зээлийн үлдэгдэл дүнг илэрхийлнэ (үнэт цаасыг оруулахгүй).

X-д хямдруулсан худалдааны өрийн бичиг, зээлийн хөтөлбөр, зээл, өрийн хэрэгсэл, хувьцаа, балансын гадуурх зүйлс болон бусад бүх төрлийн зээлтэй адилтган тооцох актив хамаарна.

Байгууллагын зээлд бүх харилцагч байгууллагуудад олгосон хямдруулсан худалдааны өрийн бичиг, зээлийн хөтөлбөр, зээл, өрийн хэрэгсэл, хувьцаа, балансын гадуурх зүйлс болон бусад бүх төрлийн зээлтэй адилтган тооцох активын нийлбэр орно.

Дээрх тэгшитгэлийн үр дүнд үндэслэн нэг зээлдэгчийн төвлөрлийн эрсдэлд харгалзах нэмэлт өөрийн хөрөнгийн шаардлагыг (МБЕ-ийн 2019 оны А-38 дугаар тушаалд заасан Бүлэг 1-ийн байгууллагын зээлийн эрсдэлд харгалзах өөрийн хөрөнгийн хувиар) дараах хүснэгтийн дагуу тодорхойлно:

ICI (%)	Өөрийн хөрөнгийн шаардлага (%)
0.0 < ICI ≤ 0.1	0
0.1 < ICI ≤ 0.2	2
0.2 < ICI ≤ 0.4	4
0.4 < ICI ≤ 1.0	6

## БҮЛЭГ 8. ЗАХ ЗЭЭЛИЙН ЭРСДЭЛИЙН БОДЛОГО

	Энэ асуудлыг хэлэлцэх ТУЗ-ийн хурлын тов	Хуралд оролцсон ТУЗ-ийн гишүүдийн тоо
Хурал 1		
Хурал 2		
Хурал ...		

### 1-р хэсэг. Эрсдэлийн хүлээн зөвшөөрөх хэмжээ болон эрсдэл даах чадвар

- Эрсдэлийн стратеги
- Эрсдэлийн хүлээн зөвшөөрөх хэмжээ болон эрсдэл даах хэмжээг өөрийн хөрөнгийн түвшинтэй уялдуулан тодорхойлсон байдал. ТУЗ-өөс баталсан Хүлээн зөвшөөрөх эрсдэлийн мэдэгдэл (RAS)-д банкны хүлээн зөвшөөрөх эрсдэлийн хэмжээг тусгасан байх шаардлагатай. Үүнийг эрсдэлийн хязгааруудаар илэрхийлж болох хэдий ч ICAAP-н хүрээнд эрсдэлийн хязгааруудыг өөрийн хөрөнгөтэй уялдуулан тооцно. Үүнийг мөн орлогын хэлбэлзэл (орлогын хэтийн төлөв)-ээр илэрхийлж болно.
- Хүлээн зөвшөөрөх эрсдэлийн мэдэгдэл (RAS)-ийг хамгийн багадаа жилд 1 удаа шинэчилнэ.

### 2-р хэсэг. Зах зээлийн эрсдэлийн хяналт

ТУЗ-өөс арилжааны хүрээнд тодорхойлсон бодлогын тухай танилцуулга:

- Олон төрлийн эрсдэлүүдийг хамруулах үйл явц: Гадаад валютын ханшийн эрсдэл, хувьцааны эрсдэл, түүхий эдийн эрсдэл, хүүгийн эрсдэл (үүнийг 10-р бүлэгт заасан IRRBB эрсдэл гэж ойлгоно).
- Эрсдэлийн хамрах хүрээ (бизнесийн чиглэлээр, бүтээгдэхүүний төрлөөр, газарзүйн байршлаар гэх мэт).
- Зах зээлийн эрсдэлийн хүрээнд баримтлах одоогийн болон ирээдүйн стратегийг тодорхойлох хүрээнд удирдлага, ТУЗ, Эрсдэлийн удирдлагын хорооны гүйцэтгэх чиг үүрэг.
- Зах зээлийн эрсдэлийг хянах, удирдах чиг үүрэг бүхий нэгжийн тодорхойлолт, боловсон хүчин, шаталсан бүтэц зохион байгуулалт болон чиг үүргийн хуваарилалт.
- Тухайн нэгжээс гүйцэтгэж байгаа хяналт, нийт эрсдэлийг хэмжихэд ашиглагдаж байгаа арга хэрэгслийн үндэслэлтэй байдалд тогтмол хяналт тавих үйл явц (буцаан шалгах шинжилгээ)
- Стресс тестийн үр дүн
- Зах зээлийн эрсдэлийн хүрээнд тогтоосон хязгааруудын тайлбар (хязгаарын төрөл болон түвшнийг эрсдэлийн төрөл тус бүрээр, өөрийн хөрөнгө болон орлоготой уялдуулан тодорхойлно)
- Зах зээлийн эрсдэлийн хязгаарыг хянах давтамж (тайлант жилд хамгийн сүүлд хянасан огноог заана уу)
- Тайлант жилд аливаа хязгаарууд зөрчигдсөн тохиолдол (зөрчигдсөн шалтгаан, зөрчлийн тоо, дүн хэмжээ)

Зах зээлийн эрсдэлийн тусгайлсан болон байнгын хяналтын үр дүн:

- Илрүүлсэн гол дутагдлууд
- Дутагдлуудыг арилгах хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, тэдгээрийг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн хугацаа, энэхүү тайлангийн төслийг боловсруулах өдрийн байдлаарх хэрэгжилт.
- Тусгайлсан хяналтын үр дүнд гарсан зөвлөмжүүдийг хэрэгжүүлсэн байдал (ашигласан арга хэрэгслүүд, хариуцах албан тушаалтнууд гэх мэт).
- Байгууллагаас өгсөн үүрэг даалгаврыг хариуцсан этгээдүүд нь зохих хугацаанд биелүүлсэн эсэхэд хяналт тавьсан байдал.

Одоо мөрдөгдөж байгаа МБЕ-ийн 2019 оны А-138 дугаар тушаалд зааснаар зах зээлийн эрсдэлд тавигдах өөрийн хөрөнгийн шаардлага нь нийт нээлттэй позицийн дүнгээр тодорхойлох гадаад валютын ханшийн эрсдэлийн өөрийн хөрөнгийн шаардлагаар хязгаарлагддаг. ИСААР-н хүрээнд банк нь хүлээж болзошгүй алдагдал болон түүнээс үүдэлтэй өөрийн хөрөнгийн хэмжээг илүү нарийвчлалтай тооцоолохын тулд дараах 3 нөхцөлийг хангасан дотоод VaR загварыг ашиглаж болно: (1) VaR-н итгэх түвшин 99% байна, (2) өнгөрсөн нэг жилийн хугацаанд хүлээж болзошгүй алдагдлын хэмжээ 3 хоногоос дээш хугацаанд VaR-н лимитээс хэтэрсэн бол нарийвчилсан тайлбарыг тайлагнана, (3) VaR-н тооцоололд зах зээлийн эрсдэлд өртөх санхүүгийн бүх хөрөнгийг оруулна.

Энэ тохиолдолд өөрийн хөрөнгийн шаардлага нь сүүлийн арван хоёр сарын VaR-н дундажтай тэнцүү байна.

## БҮЛЭГ 9. ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЭРСДЭЛИЙН БОДЛОГО

	Энэ асуудлыг хэлэлцэх ТУЗ-ийн хурлын тов	Хуралд оролцсон ТУЗ-ийн гишүүдийн тоо
Хурал 1		
Хурал 2		
Хурал ...		

### 1-р хэсэг. Эрсдэлийн хүлээн зөвшөөрөх хэмжээ болон эрсдэл даах чадвар

- Эрсдэлийн стратеги
- Эрсдэлийн хүлээн зөвшөөрөх хэмжээ болон эрсдэл даах хэмжээг өөрийн хөрөнгийн түвшинтэй уялдуулан тодорхойлсон байдал. ТУЗ-өөс баталсан Хүлээн зөвшөөрөх эрсдэлийн мэдэгдэл (RAS)-д банкны хүлээн зөвшөөрөх эрсдэлийн хэмжээг тусгасан байх шаардлагатай. Үүнийг эрсдэлийн хязгааруудаар илэрхийлж болох хэдий ч ИСААР-н хүрээнд эрсдэлийн хязгааруудыг өөрийн хөрөнгөтэй уялдуулан тооцно. Үүнийг мөн орлогын хэлбэлзэл (орлогын хэтийн төлөв)-ээр илэрхийлж болно.
- Хүлээн зөвшөөрөх эрсдэлийн мэдэгдэл (RAS)-ийг хамгийн багадаа жилд 1 удаа шинэчилнэ.

### 2-р хэсэг. Үйл ажиллагааны эрсдэлийн хяналт

- ТУЗ-өөс үйл ажиллагааны эрсдэлийг тодорхойлох, удирдах, хянах, тайлагнах хүрээнд үйл ажиллагааны нарийн төвөгтэй байдал, эрсдэл даах чадварт нийцүүлэн баталсан тогтолцооны ерөнхий танилцуулга.
- Засаглал: үйл ажиллагааны эрсдэлийг удирдахад чиглэсэн засаглалын тогтолцоо, холбогдох хороодын үүрэг болон зорилго, үйл ажиллагааны эрсдэлийн удирдлагын хүрээнд бүтэц, зохион байгуулалттай холбоотойгоор тайлант жилд гаргасан шийдвэрүүдийн тухай танилцуулга.
- Санхүүгийн жилийн эцэст бизнес/эрсдэлийн хүрээнд нарийвчлан тодорхойлсон эрсдэлийн зураглалын танилцуулга.
- Үйл ажиллагааны эрсдэлийг хэмжих, удирдах хүрээнд гаргадаг тайлангуудын ерөнхий танилцуулга (ТУЗ-д тайлагнадаг давтамж, эрсдэлийн төрлүүд, ирээдүйд учирч болзошгүй алдагдлыг илрүүлэх урьдчилан дохиологч индикаторууд).
- Тайлант жилд хүлээсэн болон хүлээх дөхсөн алдагдлын жагсаалт (дүн хэмжээ, шалтгаан). Эдгээр алдагдал болон хүлээсэн алдагдал нь дотоод үйл явц, ажилтнууд, системийн хангалтгүй байдал эсвэл саатал, гадаад үйл явдлуудаас үүдэлтэй байж болно. Үүнд: дотоод болон гадаад залилан, мэдээллийн технологийн эрсдэл, кибер аюулгүй байдлын эрсдэл, гуравдагч этгээдийн эрсдэл, бизнесийн тасалдал, системийн доголдол; хугацаа хэтэрсэн тохиолдлууд; нягтлан бодох бүртгэл эсвэл өгөгдлийн алдаа; харилцагч талуудын санал зөрөлдөөн; үйлчлүүлэгчийн бүртгэлийн алдаа; болгоомжгүй байдлаас шалтгаалан үйлчлүүлэгчийн хөрөнгийг алдах зэргээс үүдэлтэй алдагдлууд орно. Эдгээр алдагдал болон хүлээх дөхсөн алдагдлыг үнэлэх боломжийг бүрдүүлэх зорилгоор алдагдлын хэмжээ, алдагдлыг бууруулах арга хэмжээ, үйл ажиллагааны эрсдэлийн давтамж болон хэмжээ, эрсдэлийг бууруулах арга хэмжээний тухай мэдээллийн санд бүртгэсэн байх шаардлагатай.

- Онцгой байдлын болон бизнесийн тасралтгүй байдлын төлөвлөгөөний зорилго, ТУЗ-ийн гүйцэтгэх үүрэг, тэдгээрт тусгасан тодорхойлолтууд болон нөхцөлүүд, ерөнхий бүтэц (ерөнхий төлөвлөгөө, бизнесийн чиглэл тус бүрээрх төлөвлөгөө, олон төлөвлөгөөтэй тохиолдолд тэдгээрийн ерөнхий уялдаа холбоог тусгана), үүрэг хариуцлага (онцгой байдлын болон бизнесийн тасралтгүй байдлын төлөвлөгөөг удирдах, зохицуулах үүрэг бүхий албан тушаалтнуудын нэр, албан тушаал), төлөвлөгөөнд тусгагдсан үйл ажиллагааны хамрах хүрээ, онцгой тохиолдлын үед тэргүүлэх ач холбогдол бүхий бизнесийн чиглэл, төлөвлөгөөнд тусгагдаагүй үлдэгдэл эрсдэл, төлөвлөгөөг хэрэгжүүлэх хуваарь, туршилтууд, төлөвлөгөөг дахин хэрэгжүүлэх туршилтууд.

Үйл ажиллагааны эрсдэлийн дотоод хяналтын (тусгайлсан болон байнгын) үр дүн:

- Илрүүлсэн гол дутагдлууд
- Дутагдлуудыг арилгах хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, тэдгээрийг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн хугацаа, энэхүү тайлангийн төслийг боловсруулах өдрийн байдлаарх хэрэгжилт.
- Байгууллагаас өгсөн үүрэг даалгаврыг хариуцсан этгээдүүд нь зохих хугацаанд биелүүлсэн эсэхэд хяналт тавьсан байдал.



## **БҮЛЭГ 10. ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ДАНСАН ДАХЬ ХҮҮГИЙН ЭРСДЭЛИЙН БОДЛОГО**

	<b>Энэ асуудлыг хэлэлцэх ТУЗ-ийн хурлын тов</b>	<b>Хуралд оролцсон ТУЗ-ийн гишүүдийн тоо</b>
<b>Хурал 1</b>		
<b>Хурал 2</b>		
<b>Хурал ...</b>		

### **1-р хэсэг. Эрсдэлийн хүлээн зөвшөөрөх хэмжээ болон эрсдэл даах чадвар**

- Арга хэрэгслүүд, хеджинг, EVE, НИИ-н хүрээнд баримтлах эрсдэлийн стратеги.
- Эрсдэлийн хүлээн зөвшөөрөх хэмжээ болон эрсдэл даах хэмжээг өөрийн хөрөнгийн түвшинтэй уялдуулан тодорхойлсон байдал. ТУЗ-өөс баталсан Хүлээн зөвшөөрөх эрсдэлийн мэдэгдэл (RAS)-д банкны хүлээн зөвшөөрөх эрсдэлийн хэмжээг тусгасан байх шаардлагатай. Үүнийг эрсдэлийн хязгааруудаар илэрхийлж болох хэдий ч ИСААР-н хүрээнд эрсдэлийн хязгааруудыг өөрийн хөрөнгөтэй уялдуулан тооцно. Үүнийг мөн орлогын хэлбэлзэл (орлогын хэтийн төлөв)-ээр илэрхийлж болно.
- Хүлээн зөвшөөрөх эрсдэлийн мэдэгдэл (RAS)-ийг хамгийн багадаа жилд 1 удаа шинэчилнэ.

### **2-р хэсэг. Хөрөнгө оруулалтын дансан дахь хүүгийн эрсдэлийн хяналт**

- ТУЗ-өөс хөрөнгө оруулалтын дансан дахь хүүгийн эрсдэлийг удирдах буюу олон улс дахь хүүгийн эрсдэлийг тодорхойлох, үнэлэх, удирдах хүрээнд баталсан тогтолцооны ерөнхий танилцуулга (олон улс дахь хүүгийн эрсдэлийг хянахад харгалзсан үзсэн байгууллагууд болон гүйлгээний мэдээлэл, дунд болон дээд шатны удирдлагуудын үүрэг, олон улс дахь хүүгийн эрсдэлийг хянах нэгжийн чиг үүргийн хуваарилалт).
- ТУЗ-өөс баталсан хөрөнгө оруулалтын дансан дахь хүүгийн эрсдэлийг удирдах арга хэрэгсэл, аргачлалуудын танилцуулга.
- Стресс тестийн үр дүн
- Цэвэр хүүгийн орлого (НИИ) болон өөрийн хөрөнгийн эдийн засгийн үнэ цэн (EVE)-ийн хүрээнд тогтоосон хөрөнгө оруулалтын дансан дахь хүүгийн эрсдэлийн хязгааруудын тухай ерөнхий танилцуулга.
- Хүүгийн эрсдэл болон хөрөнгө оруулалтын дансан дахь хүүгийн эрсдэлтэй холбоотой голлох өөрчлөлтүүдийг ТУЗ-д тайлагнасан байдал (давтамжийг тусгана).
- 200 суурь нэгжийн стандарт шокийн нөлөөгөөр банкны хүүд мэдрэмтгий актив, пассив, ΔEVE ба ΔНИИ-д гарах үр дүн.

Хөрөнгө оруулалтын дансан дахь хүүгийн эрсдэлийн дотоод хяналтын (тусгайлсан болон байнгын) үр дүн:

- Илэрсэн гол дутагдлууд
- Дутагдлуудыг арилгах хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, тэдгээрийг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн хугацаа, энэхүү тайлангийн төслийг боловсруулах өдрийн байдлаарх хэрэгжилт.

- Тусгайлсан хяналтын үр дүнд гарсан зөвлөмжүүдийг хэрэгжүүлсэн байдал (ашигласан арга хэрэгслүүд, хариуцах албан тушаалтнууд гэх мэт).
- Байгууллагаас өгсөн үүрэг даалгаврыг хариуцсан этгээдүүд нь зохих хугацаанд биелүүлсэн эсэхэд хяналт тавьсан байдал.

Банк нь хамгийн багадаа IRRBB эрсдэлд шаардагдах өөрийн хөрөнгийн хэмжээг доорх аргачлалын дагуу тооцоолно.

Эхний шатанд банк нь хөрөнгө оруулалтын данс (IRRBB-г тооцох) болон арилжааны дансанд (зах зээлийн эрсдэлд хамаарах хүүгийн өөрчлөлтийн эрсдэлийг банкны VaR аргачлалын дагуу тооцох) хамаарах актив, пассивыг ялгана.

Арилжааны данс нь арилжааны хэрэгслийн тодорхойлолтыг хангаж байгаа бүх хэрэгслүүдээс бүрдэнэ: санхүүгийн хэрэгсэл, гадаад валют (FX), түүхий эд. Санхүүгийн хэрэгсэл гэдэг нь нэг банкны хувьд санхүүгийн хөрөнгийг, нөгөө банкны хувьд санхүүгийн өр төлбөр, эсвэл өмчийн хэрэгслийг үүсгэж байгаа аливаа гэрээ байна. Санхүүгийн хөрөнгөд бэлэн мөнгө болон бэлэн мөнгө, санхүүгийн хөрөнгө, түүхий эд эсхүл хувьцаа авах гэрээний эрх багтана. Санхүүгийн өр төлбөрт бэлэн мөнгө болон бусад санхүүгийн хөрөнгө, түүхий эдийг нийлүүлэх гэрээгээр хүлээсэн үүрэг багтана. Банк нь арилжааны дансанд хамаарах хэрэгслийн бодит үнэ цэнийг өдөр бүр үнэлж, аливаа үнэлгээний өөрчлөлтийг ашиг, алдагдлын дансанд хүлээн зөвшөөрч, бүртгэнэ.

Хөрөнгө оруулалтын дансанд дээр дурдсанаас бусад бүх хэрэгслүүд багтана. Энэ нь гэрээнд заасан шимтгэл, хураамж, хүүгийн дагуу хугацаа дуусах хүртэл эзэмшиж, ашиг олох зорилготой банкны үйл ажиллагаа (зээл олгох, зээл авах, үнэт цаас эзэмших, гаргах, хадгаламж татах)-тай холбоотой хөрөнгө, өр төлбөр бөгөөд үүнд өндөр эргэлтэй бус хөрөнгийг борлуулах болон ховор тохиолдлоос бусад тохиолдолд хөрөнгө борлуулах замаар бий болгосон мөнгөн гүйлгээ хамаарахгүй.

IRRBB-н өөрийн хөрөнгийн шаардлагыг тооцоолохдоо зөвхөн хүүгийн түвшинд мэдрэмтгий хөрөнгө, өр төлбөрийг харгалзан үзнэ. Энэ нь тогтмол эсвэл хувьсах хүүтэй бөгөөд индекс нь хүүгээр илэрхийлэгдээгүй хөрөнгө, өр төлбөр байна (жишээ нь: индекс нь түүхий эдийн ханш).

Хоёрдугаар шатанд хөрөнгө оруулалтын дансан дахь хөрөнгө, өр төлбөрийн хувьд Базел стандартын дагуух аргачлалыг ашиглана.

Өөрөөр хэлбэл, IRRBB-н өөрийн хөрөнгийн шаардлагыг үнэлэх Базел стандартын цогц аргачлал нь хүүгийн эрсдэлд мэдрэмтгий бүх хөрөнгө, өр төлбөрийн хувьд EVE (хөрөнгийн эдийн засгийн үнэ цэнэ) ба NII (цэвэр хүүгийн орлого)-ын өөрчлөлтийг үнэлэхэд оршино.

ΔEVE үзүүлэлтийг тооцоолохдоо Базел стандартад заасны дагуу 19 хугацааны интервал дахь, 6 шок сценарийн дагуу хөрөнгө, өр төлбөрийн өнөөгийн үнэ цэнийг үнэлнэ. ΔNII-г тооцоолохдоо энэ аргачлалыг 12 сар хүртэлх хугацааны интервалд ашиглана.

Гэсэн хэдий ч банкууд дээр дурдсанаас хялбаршуулсан аргачлалыг ашиглах боломжтой. Энэхүү аргачлалын дагуу банкууд банкны хөрөнгө оруулалтын дансан дахь бүх зүйлсийн нийт жигнэсэн дунжийг хугацааны интервал тус бүрээр тооцож, өөрчлөлтийг (хөрөнгийн эдийн засгийн үнэ цэн болон цэвэр хүүгийн орлогын бууралт) зөвхөн 2 сценарийн дагуу

хэмжинэ: бүх хугацааны интервалын хувьд зээлийн хүү нь 200 суурь нэгжээр зэрэгцэн өсөх болон буурах.

Үүнийг дараах алхмуудын дагуу гүйцэтгэнэ:

А. Эдийн засгийн өөрийн хөрөнгийн шаардлагад нэмж тусгагдах  $\Delta EVE$ -г тооцоолох

- Банкны санхүүгийн тайлан дахь зээлийн хүүгийн өөрчлөлтөд мэдрэмтгий хөрөнгө оруулалтын дансан дахь бүх зүйлсийг 10 хугацааны интервалын хүснэгтэд (төгрөг болон гадаад валютаар) оруулах<sup>6</sup>.
- Цэвэр позицыг тооцоолохын тулд дуусах хугацаа тус бүрээр нь хөрөнгө, өр төлбөрийг харьцуулна.
- Хугацааны интервал тус бүрийн цэвэр позицийн өөрчлөлтийг зээлийн хүү 200 суурь нэгжээр зэрэгцэн өсөх болон буурах стандарт шокийн сценариудын хувьд тооцоолно. Жишээ:

	1 өдөр	2 өдөр...	+24 сар
Актив 1	10%-тай 1000		
Актив 2...	12%-тай 1300		
Пассив 1	7%-тай 800		
Пассив 2...	6%-тай 600		
Цэвэр позиц (актив/пассив)	Актив 900		
Жигнэсэн дундаж хүү	11,13%		
Шокууд	13,13% болон 9,13%		
$\Delta EVE$ = Дпозицийн шокийн дараах өнөөгийн үнэ цэн	13,13%-ийн шокийн хувьд -0,05 9,13%-ийн шокийн хувьд +0,05		

- Нийт позицийн цэвэр  $\Delta EVE$  (илүүдэл эсвэл алдагдал) -г тооцоолохын тулд өөр өөр хугацааны интервал дахь бүх  $\Delta EVE$ -ийн нийлбэрийг тооцоолно. Үүнийг төгрөг болон материаллаг гадаад валют тус бүрийн хувьд хийнэ.
- IRRBB-н өөрийн хөрөнгийн шаардлагыг тооцоход авч үзэх нийт  $\Delta EVE$  нь 2 хувилбарын хамгийн өндөр дүнтэй сөрөг  $\Delta EVE$  байна. Дээрх жишээнд -0,05-г эдийн засгийн өөрийн хөрөнгөд нэмэхээр байна. Гэсэн хэдий ч дээр дурдсанчлан, бүх  $\Delta EVE$ -ийн нийлбэрийн хамгийн өндөр (2 хувилбарыг тусад нь авч үзэх бөгөөд бүх  $\Delta EVE$ -ийн нийлбэрийг хувилбар тус бүрийн хувьд тооцоолно) нь эдийн засгийн өөрийн хөрөнгө дээр нэмэгдэнэ.

В. Бүлэг 2-ын өөрийн хөрөнгийн шаардлагад нэмж тусгагдах  $\Delta NII$ -г тооцоолох

<sup>6</sup> 1 өдөр, 2 өдөр, 3-5 өдөр, 5-10 өдөр, 10-30 өдөр, 1-3 сар, 3-6 сар, 6-12 сар, 2-24 сар, +24 сар

НИИ-н өөрчлөлтийг тооцоолоход дээр дурдсантай ижил аргачлалыг ашиглана. Гэвч зөвхөн 8 хугацааны интервалыг харгалзан үзнэ<sup>7</sup>.

2 тооцооллын үр дүнг ялгаатай байдлаар харгалзан үзнэ: НИИ-н өөрчлөлт нь Бүлэг 2-ын өөрийн хөрөнгийн нэмэлт шаардлагад хамаарах бол EVE-н өөрчлөлт нь эдийн засгийн өөрийн хөрөнгөд хамаарна (нийт өөрийн хөрөнгийн шаардлагыг тооцоолох Хавсралт 3-ын 4-р бүлгээс харна уу).

Тооцооллыг дараах алхмуудын дагуу гүйцэтгэнэ:

А. Эдийн засгийн өөрийн хөрөнгийн шаардлагад нэмж тусгагдах  $\Delta EVE$ -г тооцоолох

- Банкны санхүүгийн тайлан дахь зээлийн хүүгийн өөрчлөлтөд мэдрэмтгий хөрөнгө оруулалтын дансан дахь бүх зүйлсийг 12 сар хүртэлх хугацааны интервалын хүснэгтэд (төгрөг болон гадаад валютаар) оруулах.
- Цэвэр позицыг тооцоолохын тулд дуусах хугацаа тус бүрээр нь хөрөнгө, өр төлбөрийг харьцуулна.
- Хугацааны интервал тус бүрийн цэвэр позицийн өөрчлөлтийг зээлийн хүү 200 суурь нэгжээр зэрэгцэн өсөх болон буурах стандарт шок нөхцөлүүдийн хувьд тооцоолно. Жишээ:

	1 өдөр	2 өдөр...	+12 сар
Актив 1	10%-тай 1000		
Актив 2...	12%-тай 1300		
Нийт актив	11,13%-тай 2300		
A=Шокгүй хүүгийн түвшин	0,71		
B=Хүү зэрэгцэн өсөх (13,13%)	0,84		
C= Хүү зэрэгцэн буурах (9,13%)	0,58		
Пассив 1	7%-тай 800		
Пассив 2...	6%-тай 600		
Нийт пассив	6,57%-тай 1400		
D= Шокгүй хүүгийн түвшин	0,25		
E= Хүү зэрэгцэн өсөх (8,57%)	0,33		
F= Хүү зэрэгцэн буурах (4,57%)	0,18		
Шокгүй НИИ = A-D	0,46		
$\Delta$ НИИ хүү өсөх шок= (A-D)-(B-E)	-0,05		

<sup>7</sup> 1 өдөр, 2 өдөр, 3-5 өдөр, 5-10 өдөр, 10-30 өдөр, 1-3 сар, 3-6 сар, 6-12 сар

ΔNII хүү буурах шок= (A-D)-(C-F)	0,05		
-------------------------------------	------	--	--

- Дээрх жишээний Бүлэг 2-ын хөрөнгийн шаардлагад 0,05 (абсолют дүн нь -0,05)-г нэмэхээр байна. Гэсэн хэдий ч эцэст нь бүх ΔNII-ийн нийлбэрийн хамгийн өндөр (2 хувилбарыг тусад нь авч үзэх бөгөөд бүх ΔNII-ийн нийлбэрийг хувилбар тус бүрийн хувьд тооцоолно хийсэн гэсэн үг) дүнг авч үзэх нь зүйтэй.

## БҮЛЭГ 11. БУСАД ЭРСДЭЛИЙН БОДЛОГО

ИСААР-н хүрээнд нэр хүндийн, стратегийн, даатгалын, бизнесийн, тэтгэврийн, оролцооны, санхүүжилтийн зардлын болон бусад эрсдэлүүдийг авч үзэж болно. Бусад эрсдэлүүдийг тайланд тусгахдаа ТУЗ-өөс баталсан стратеги, эрсдэлийн хүлээн зөвшөөрөх хэмжээ, эрсдэл даах хэмжээ, эрсдэлийг хянах арга хэмжээ зэрэг хэсгүүдийг тусгах шаардлагатай.

	Энэ асуудлыг хэлэлцэх ТУЗ-ийн хурлын тов	Хуралд оролцсон ТУЗ- ийн гишүүдийн тоо
Хурал 1		
Хурал 2		
Хурал ...		

- ТУЗ-өөс баримталж байгаа стратегийн танилцуулга
- Хүлээн зөвшөөрөх эрсдэлийн мэдэгдэл
- Эрсдэлийг үүсгэж байгаа эх шалтгаануудын танилцуулга
- Эрсдэлд тусгайлсан болон байнгын хяналт тавих үйл явц, журмын танилцуулга

Тусгайлсан болон байнгын хяналтын үр дүн:

- Илэрсэн гол дутагдлууд
- Дутагдлуудыг арилгах хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, тэдгээрийг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн хугацаа, энэхүү тайлангийн төслийг боловсруулах өдрийн байдлаарх хэрэгжилт.
- Тусгайлсан хяналтын үр дүнд гарсан зөвлөмжүүдийг хэрэгжүүлсэн байдал (ашигласан арга хэрэгслүүд, хариуцах албан тушаалтнууд гэх мэт).
- Байгууллагаас өгсөн үүрэг даалгаврыг хариуцсан этгээдүүд нь зохих хугацаанд биелүүлсэн эсэхэд хяналт тавьсан байдал.

## **БҮЛЭГ 12. МЭДРЭМТГИЙ БАЙДЛЫН ШИНЖИЛГЭЭ (СТРЕСС ТЕСТ)**

### **1-р хэсэг. Стресс тест хийхэд баримтлах үндсэн зарчмууд**

Энэ хэсэгт банк аливаа стресс тестийг хийж гүйцэтгэхдээ баримтлах үндсэн зарчмуудыг тодорхойлсон болно. Эдгээр зарчмуудын зорилго нь стресс тест нь банкны эрсдэлийн удирдлагын ерөнхий тогтолцооны салшгүй хэсэг гэдгийг илэрхийлэхэд оршино. Банк нь стресс тесттэй холбоотой мэдээллийг дараах байдлаар тайланд тусгана:

#### **1. Харьцангуй байдал:**

Стресс тестийн цар хүрээ нь банкны хэмжээ, нарийн төвөгтэй байдал, үйл ажиллагааны төрлөөс хамаарна.

#### **2. Хамрах хүрээ:**

Банк нь стресс тест хийхдээ ач холбогдол бүхий бүх эрсдэлүүдийг тодорхойлон хамруулна.

#### **3. Нийцүүлэлт:**

Банк нь өөрийн үйл ажиллаганы нарийн төвөгтэй байдал, учирч байгаа эрсдэлүүдийн төрөлтэй холбоотойгоор илэрсэн эрсдэлт хүчин зүйлсийн тоог харгалзан үзэж, стресс тестийн хүрээнд авч үзэх ач холбогдол бүхий эрсдэлүүдийг тодорхойлно.

#### **4. Өгөгдлийн чанар ба мэдээллийн систем:**

Банк нь стресс тест хийхдээ тухайн стресс тестийн хамрах хүрээний дагуу үнэн зөв, нэгдсэн өгөгдлийг ашиглана.

### **2-р хэсэг. Стресс тестийг эрсдэлийн засаглалын тогтолцоонд нэгтгэн хамруулах**

Банкны ТУЗ болон дээд шатны удирдлага нь Эрсдэлийн удирдлагын хороонд энэхүү үүрэг хариуцлагыг хүлээлгэснээс бусад тохиолдолд стресс тестийн бүх үе шатанд хяналт тавих үүрэгтэй. Банк нь эрсдэлийн удирдлага болон өөрийн хөрөнгийн төлөвлөлтийн үйл явцад стресс тестийн үр дүнг зохих байдлаар ашиглаж байгаа эсэхэд хяналт тавина. Үүнтэй холбоотойгоор хийсэн ТУЗ-ийн хурлын үр дүнг энэ хэсэгт танилцуулна.

### **3-р хэсэг. Стресс тестийн аргачлалуудыг тодорхойлох**

Стресс тестийн олон төрлийн аргачлалууд байдаг бөгөөд эдийн засгийн сөрөг үйл явдлаас шалтгаалан банкны ашиг, өөрийн хөрөнгөд үзүүлэх нөлөөг үнэлэх хүрээнд энгийн мэдрэмтгий байдлын шинжилгээнээс эхлээд илүү нарийн төвөгтэй аргачлалыг ашиглаж болно. Банк нь ямар төрлийн стресс тест ашигласан талаар дараах байдлаар тайланд тусгах шаардлагатай:

#### **А-Мэдрэмтгийн байдлын шинжилгээ:**

Энэхүү шинжилгээ нь нэг хүчин зүйлд нэг шок өгөх замаар банкны санхүүгийн байдалд үзүүлэх нөлөөг үнэлдэг бөгөөд бусад хүчин зүйлс өөрчлөгдөхгүй хэвээр байна гэж үздэг тул хялбар аргачлалд тооцогддог. Мөн энэхүү шинжилгээ нь аль нэг эрсдэлт хүчин зүйлд хэр мэдрэмтгий байгааг илэрхийлэх анхан шатны үнэлгээ болдог.

## **В- Сценар шинжилгээ:**

Энэхүү шинжилгээ нь илүү дэвшилтэт аргачлал бөгөөд түүхэн мэдээлэл эсвэл төсөөлөлд үндэслэн хэд хэдэн хүчин зүйлд нэгэн зэрэг хэд хэдэн шокуудыг өгдөг. Тухайлбал:

### **• Түүхэн сценар шинжилгээ:**

Энэхүү шинжилгээ нь өнгөрсөн хугацаанд зах зээл дээр болсон ноцтой үйл явдлуудад үндэслэдэг бөгөөд аливаа шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээтэй холбоотойгоор ирээдүйд учирч болзошгүй эрсдэлүүдийг харгалзан үздэггүй.

### **• Эксперт сценар шинжилгээ:**

Банкны эрсдэлийн удирдлага хариуцсан албан тушаалтан нь банкны эрсдэлийн ерөнхий түвшинтэй хамааруулан ирээдүйд тохиолдож болзошгүй сөрөг сценариудыг зохионо. Энэхүү шинжилгээ нь аливаа шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээтэй холбоотойгоор ирээдүйд учирч болзошгүй эрсдэлүүдийг харгалзан үздэг.

## **4-р хэсэг. Стресс тестийн үр дүнг тайлагнах**

Банк нь стресс тест хийхэд ашигласан аргачлал, нөхцөлүүд, үр дүнг Монголбанканд тайлагнана. Банк нь хамгийн багадаа энэ журмын 13-т заасны дагуу стресс тестийг хийж гүйцэтгэнэ.

Банк нь хамгийн багадаа стресс тестийн дараах үр дүнг тайландаа тусгана:

	N+1 жил	N+2 жил	N+3 жил
Таамаглалууд: ДНБ ХҮИ Гадаад валютын ханш Ажилгүйдлийн түвшин Бусад			
Чанаргүй зээлийн харьцаанд үзүүлэх нөлөө			
Өөрийн хөрөнгөд үзүүлэх нөлөө			
Нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгөд үзүүлэх нөлөө			
Өөрийн хөрөнгө, ЭЖА-ын харьцаанд үзүүлэх нөлөө			

Банкууд стресс тестийн үр дүнгийн нарийвчилсан тооцооллыг Excel файлаар ирүүлэх шаардлагатай.



## **БҮЛЭГ 13. ӨӨРИЙН ХӨРӨНГИЙН ТӨЛӨВЛӨЛТ**

ИСААР нь ирээдүйд чиглэсэн шинж чанартай тул өөрийн хөрөнгийн төлөвлөлтийг багтаасан байх шаардлагатай. Өөрийн хөрөнгийн бүрэн цогц таамаглал нь төлөвлөлт болон төсвийн үйл явцтай уялдаж, дараах таамаглалуудыг багтаасан байна: Боломжит биет (тайлан дахь) өөрийн хөрөнгө – ашиг, ногдол ашиг болон өөрийн хөрөнгийн удирдлагын үр дүнгээс хамааралтай байх; шаардлагатай эдийн засгийн өөрийн хөрөнгө – зээлийн эрсдэл, зах зээлийн эрсдэлийн хязгаарын таамаглал гэх зэргээс хамааралтай байх; өөрийн хөрөнгийн шаардлага – эрсдэлээр жигнэсэн активын таамаглалаас хамааралтай байх.

### **1-р хэсэг. Санхүүгийн үзүүлэлтүүд, өөрийн хөрөнгийн тайлант үеийн болон ирэх жилүүдийн төсөөллийг багтаасан стратегийн ерөнхий танилцуулга**

Энэ хэсэг нь банкны стратеги болон үйл ажиллагааны төлөвлөгөөний гол бүрэлдэхүүн хэсэг болно. Энэ хүрээнд банкны тайлант үеийн санхүүгийн байдал, бизнесийн төлөвт гарах өөрчлөлт, бизнесийн үйл ажиллагааны орчин, бизнес төлөвлөгөөний төсөөлөл (бизнесийн чиглэлээр), санхүүгийн үзүүлэлтүүдийн төсөөлөл, ирээдүйд татахаар төлөвлөсөн өөрийн хөрөнгийн эх үүсвэрт гарах өөрчлөлт зэрэг мэдээллийг хамруулна.

Банк нь бизнес төлөвлөгөө, стратегийг боловсруулахдаа улс төр, эдийн засаг, хууль эрх зүй, гадаад орчинд гарч болзошгүй өөрчлөлтүүдийг харгалзан үзэж, тэдгээрийн төлөвлөгөөт хугацаанд үзүүлэх нөлөөг анхаарах шаардлагатай. Энэ хүрээнд газрын тосны үнэ, банктай холбоотой хууль тогтоомж, тухайлбал, гадаадын хөрөнгө оруулалт, хэрэглээний зээл, хөрөнгийн зах зээл, ипотекийн зээл, банк бус байгууллагуудтай холбоотой асуудлуудыг авч үзэх боломжтой.

Банк нь үнэлгээг хийж гүйцэтгэсэн тайлан болон огноог ИСААР, ИЛААР-н тайландаа тодорхой тусгах шаардлагатай. Тайлангийн төсөөлөл нь банкны стратеги төлөвлөгөө, гадаад орчны өөрчлөлт, төлөвлөгөөт хугацааны хүрээнд ашигласан таамаглалууд, бизнесийн голлох чиглэлүүдийг хэрэгжүүлэхэд шаардлагатай өөрийн хөрөнгийн хэмжээ зэргийг тусгасан байна.

Түүнчлэн санхүүгийн тайлан, өөрийн хөрөнгө, өөрийн хөрөнгийн эх үүсвэрийн төсөөллүүдийг ирээдүйн төлөвлөгөөнд үндэслэн тодорхойлно. Энэхүү төсөөлөл нь сөрөг сценариудтай харьцуулах суурь сценар болох боломжтой.

### **2-р хэсэг. Өөрийн хөрөнгийн хүрэлцээ**

ИСААР нь эдийн засаг, хууль эрх зүй, зохицуулалт, санхүүгийн тайлагналын хүрээнд шаардагдах өөрийн хөрөнгийн зорилтыг тодорхойлж, эдгээр шаардлагыг хангах өөрийн хөрөнгийн эх үүсвэрийг төлөвлөхөд дэмжлэг үзүүлэх зорилготой. Иймд энэ хэсэгт банк нь өөрийн хөрөнгийн зорилт, доод шаардлага болон бусад шинж чанаруудаас хамааран өөрийн хөрөнгийн ангиллыг тодорхойлох шаардлагатай.

1. Өөрийн хөрөнгийн шаардлага
2. Тайлант өөрийн хөрөнгө
3. Хувь нийлүүлсэн хөрөнгө

#### 4. Эдийн засгийн өөрийн хөрөнгө

Үүнээс гадна банк нь эрсдэл болон гүйцэтгэлийн үнэлгээндээ үндэслэн өөрийн хөрөнгийн ангилал, бүтцийн өөрчлөлт, зарцуулалтыг тодорхойлох шаардлагатай.

Иймд энэ хэсэгт Монголбанк болон олон улсын санхүүгийн тайлагналын стандартын дагуу тогтоосон өөрийн хөрөнгийн хүрэлцээг хангахад шаардлагатай өөрийн хөрөнгийн хэмжээ болон банкны бизнесийн стратеги, хараат бус зэрэглэл тогтоогч байгууллагын үнэлгээ, хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг хуваарилах бодлого гэх зэргийг хэрэгжүүлэхэд шаардлагатай өөрийн хөрөнгийн хэмжээний талаарх банкны тооцооллыг нарийвчлан тусгана. Жишээлбэл, шаардлагатай өөрийн хөрөнгийн хэмжээ нь банкны зээлжих зэрэглэлийн хүрээнд тогтоосон зорилттой уялдсан эсэх, стратегиа хэрэгжүүлснээр өөрийн хөрөнгийн доод шаардлага хангагдахгүй байхаас сэргийлэх нөөц өөрийн хөрөнгийн хэмжээг тодорхойлсон эсэхийг харгалзан үзнэ. Эдийн засгийн өөрийн хөрөнгийг тооцоолохдоо загвар ашигласан тохиолдолд хамрах хугацаа, эдийн засгийн нөхцөл байдал, сценар шинжилгээ болон сөрөг сценариудыг хэрхэн тодорхойлсон тухай тайлбарыг тусгана.

Банк нь хамгийн багадаа доор дурдсан мэдээллийг тайландаа тусгах бөгөөд шаардлагатай тохиолдолд холбогдох дүн хэмжээг тодорхойлж, хүснэгтэн хэлбэрээр тайланд тусгана. Үүнд:

##### 1. Өөрийн хөрөнгийн шаардлага

- Бүлэг 1-ийн өөрийн хөрөнгийн шаардлага
- Бүлэг 2-ын өөрийн хөрөнгийн шаардлага (IRRBB болон төвлөрлийн эрсдэлийн өөрийн хөрөнгийн шаардлага)
- Бизнес төлөвлөгөөний үр дүн (хураангуй)
- Бизнесийн чиглэл тус бүрийн өсөлт болон дүн хэмжээ
- Бизнесийн чиглэл тус бүрээрх өөрийн хөрөнгийн шаардлага
- Стратегийн зорилт
- Өөрийн хөрөнгийн зарлага
- Өөрийн хөрөнгийн нэмэлт шаардлагыг тодорхойлох стресс тест
- Өөрийн хөрөнгийн бусад шаардлага
- **Нийт өөрийн хөрөнгийн шаардлага**

##### 2. Боломжит өөрийн хөрөнгө

- Биет өөрийн хөрөнгө
- Ашгийн төсөөлөл
- Хувьцаанд хөрвөх өрийн хэрэгсэл
- Хувьцаа
- Бусад өөрийн хөрөнгийн эх үүсвэр
- Нийт өөрийн хөрөнгийн эх үүсвэр

##### 3. Боломжит нөөц өөрийн хөрөнгө (1-2)

##### 4. Хуваарилахаар хүлээгдэж байгаа ногдол ашиг

##### 5. Тайлант хугацаан дахь санхүүжилтийн төлөвлөгөө

## **6. Охин компаниудын өөрийн хөрөнгийн шаардлага**

Банк нь хамгийн багадаа Хавсралт 3-ын 4-р бүлэгт заасны дагуу өөрийн хөрөнгийн шаардлагын тооцооллыг тайлагнах шаардлагатай.

“Банкны өөрийн хөрөнгийн хүрэлцээ болон хөрвөх чадварын хүрэлцээг дотооддоо үнэлэх аргачлалын журам”-ын 2 дугаар хавсралт

## ЦААР-Н ТАЙЛАНГ БОЛОВСРУУЛАХ ЗАГВАР

ЦААР-н тайлан нь дараах бүлгүүдээс бүрдэнэ.

### БҮЛЭГ 1. ХӨРВӨХ ЧАДВАРЫН ЭРСДЭЛИЙН БОДЛОГО

	Энэ асуудлыг хэлэлцэх ТУЗ-ын хурлын тов	Оролцох ТУЗ-ын гишүүдийн тоо
Хурал 1		
Хурал 2		
Хурал ...		

#### 1-р хэсэг. Эрсдэлийн хүлээн зөвшөөрөх хэмжээ болон эрсдэл даах чадвар

- Эрсдэлийн стратеги.
- Эрсдэлийн хүлээн зөвшөөрөх хэмжээ болон эрсдэл даах чадварыг эх үүсвэрийн хэмжээ болон бүтэцтэй уялдуулан тодорхойлох.
- Энэ хэсэгт банкны хөрвөх чадварын хүрээнд тодорхойлсон тодорхой зорилтуудыг тусгана. Тухайлбал, хувьцаа эзэмшигчдийн ашигт ажиллагааны зорилт, банкны өөрийн болон үнэт цаас гаргахад тогтоолгохоор зорьж байгаа зээлжих зэрэглэл, зохицуулагч байгууллагын урьдчилан сэргийлэх, албадлагын арга хэмжээнээс зайлсхийх, тодорхойгүй нөхцөл байдлаас сэргийлэх болон хадгаламж эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалах зорилтууд, түүнчлэн богино хугацааны хөрвөх чадварын хэрэгцээг хангах болон стратегийн худалдан авалт хийх, банкны хүлээж байгаа болон хүлээж болзошгүй хөрвөх чадварын эрсдэлийн төрөл, хэмжээ, төлбөрийн шаардлагыг биелүүлж чадахгүй болох эрсдэл, хөрвөх чадвартай хөрөнгийн нөөц нь зохих хэмжээнээс буурах эсхүл Монголбанкнаас тогтоосон хөрвөх чадвартай хөрөнгийн чанар, эх үүсвэрийн төрөлтэй холбоотой шаардлагыг хангахгүй байх зэрэг эрсдэлүүдийг хаахад хүрэлцэхүйц өндөр чанартай хөрвөх чадвартай хөрөнгө бүрдүүлэх зэрэг багтана.

#### 2-р хэсэг. Хөрвөх чадварын эрсдэлийн хяналт

- Хөрвөх чадварын эрсдэлийг тодорхойлох, хэмжих, удирдах болон хянах хүрээнд ТУЗ-өөс шийдвэрлэсэн бодлогын талаарх ерөнхий танилцуулга;
- Хөрвөх чадварын эрсдэлийн хязгаарлалтууд болон хөрвөх чадварын эрсдэл даах чадварын түвшнүүдийн ерөнхий тайлбар (эрсдэл даах чадварыг бизнесийн чиглэл, валют, харгалзах талын төрөл тус бүрээр, мөн аливаа этгээдтэй хийж байгаа хэлцлийн хэмжээ, өөрийн хөрөнгөд эзлэх хэмжээ зэргийг харгалзан тодорхойлж, үндэслэлтэйгээр тайлбарлана);
- Хөрвөх чадварын хязгаарлалтуудыг хянах аргачлал болон хяналтын давтамж. (Хамгийн сүүлд хянасан огноо, эрх бүхий албан тушаалтнууд, ашигласан арга, аргачлал);

- Санхүүжилтийн бүтэц болон эх үүсвэрийн төрөлжилттэй холбоотой мэдээлэл: Банкны санхүүжилтийн бүтэц болон санхүүжилтийн эх үүсвэрүүдийн тайлбар;
- Голлох санхүүжилтийн эх үүсвэрүүдтэй холбоотой санхүүжүүлэгч талаас тавьсан шаардлагууд (ковенантууд)
- Хөрвөх чадварын эрсдэлийг удирдахад ашигладаг арга, аргачлалуудын тайлбар;
- Харилцах, хадгаламж болон тэдгээрийн төрөлжилт (харилцах, хадгаламж эзэмшигчдийн тооны хувьд);
- Хөрвөх чадварын эрсдэлийг хязгаарлах тогтолцоотой холбоотойгоор хөрвөх чадвартай хөрөнгийн нөөцийг бүрдүүлэхэд ашигласан таамаглал, нөхцөлүүдийн тайлбар;
- Хөрвөх чадвартай хөрөнгийн нөөцийн зохих түвшнийг тогтмол мэдээлэх арга хэрэгслүүдийн тайлбар, мөн хөрвөх чадвартай хөрөнгийн нөөцийн түвшнийг цаг хугацааны өөр өөр үе шатанд тохируулахад ашигласан таамаглалууд;
- Хөрвөх чадвартай хөрөнгийн зардал тооцох аргачлалууд болон тайлант жилийн хөрвөх чадвартай хөрөнгийн зардлын үзүүлэлтүүдийн өөрчлөлт, хөдөлгөөн;
- Санхүүжилтийн төлөвлөгөөний тайлбар (ердийн нөхцөлд болон хүндрэлийн үед санхүүжилтийн эх үүсвэрүүдээс бүх төрлийн хугацаатай болон валютаар хөрөнгө бүрдүүлэх чадварыг үнэлэхэд ашигласан арга аргачлал (таамаглал, нөхцөлүүд, тестийн үр дүн г.м), нэр хүндийн эрсдэлийг тооцоолохтой холбоотой арга аргачлал);
- Зах зээлийн хөрвөх чадвартай холбоотой үзүүлэлтүүдэд их хэмжээний өөрчлөлт гарах тохиолдолд үүсэх эрсдэлийг хэмжихэд ашигласан сөрөг сценариудын тайлбар (ашигласан таамаглалууд, үнэлгээ хийсэн давтамж, баталгаажуулах үйл явц, аргачлал, стресс тестийн үр дүнгийн хяналт, зохицуулагч байгууллагад үр дүнг тайлагнасан байдал) болон тухайн үзүүлэлтүүдэд их хэмжээний өөрчлөлт гарах үед үүсэх эрсдэлийн шинжилгээний үр дүн;
- Хөрвөх чадварын хүндрэл үүсэх үед хэрэгжүүлсэн тасралтгүй үйл ажиллагааг хангах төлөвлөгөө: хэрэгжүүлсэн арга хэмжээнүүд (шийдвэр гаргалтын үйл явц, түүнд оролцсон албан тушаалтнууд, шаардлагатай хөрвөх чадвартай хөрөнгийг татан төвлөрүүлэхэд ашигласан арга шийдэл, тасралтгүй үйл ажиллагааг хангах төлөвлөгөөний тогтмол хяналтууд, ТУЗ-ийн оролцоо г.м);
- Тайлант жилд зөрчигдсэн хязгаарлалтуудын талаарх мэдээлэл (хязгаарлалт зөрчигдсэн шалтгаан, зөрчигдсэн тоо, хэмжээ);
- Зөрчигдсэн хязгаарлалтуудтай холбоотой үйл явц, тэдгээрийг хэвийн байдалд оруулах чиглэлээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээ;
- Тайлант жилд тохиолдсон үйл явдлуудын (incidents) тайлбар.

Хөрвөх чадварын эрсдэлийн хяналтын үр дүн (тодорхой давтамжтай хэрэгжүүлэх хяналт болон байнгын хяналт):

- Ажиглагдсан гол дутагдлууд;
- Дутагдлуудыг арилгах хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, тэдгээрийн хүлээгдэж байгаа хугацаа, ILAAP тайланг боловсруулах үеийн хэрэгжилтийн явц байдал;
- Байнгын хяналтын хүрээнд гарсан зөвлөмжийг хэрэгжүүлсэн байдал (оролцсон албан тушаалтнууд, ашигласан арга хэрэгсэл г.м)

- Зохицуулагч байгууллагуудаас өгсөн үүрэг даалгавар, тухайн банканд авч хэрэгжүүлсэн арга хэмжээнүүдийн хэрэгжилтэд хяналт тавьсан байдал.

## **БҮЛЭГ 2. ИЛААР-ын тусгайлсан үйл явц**

### **1-р хэсэг. Засаглал**

Энэ хэсэгт ИЛААР тогтолцооны засаглал, удирдлага, тухайлбал банкны ТУЗ-ийн оролцоо, эрсдэлийн удирдлагын аргачлалын талаар тайлагнах бөгөөд дараах бүрэлдэхүүн хэсгээс бүрдэнэ:

- ИЛААР-ыг боловсруулах, шинэчлэх үйл явцын талаарх ерөнхий мэдээлэл
- ИЛААР-ын үнэлгээг хийх үйл явцын дэлгэрэнгүй тайлбар
- ИЛААР-ын хүрээнд банкны ТУЗ-ийн гишүүд болон гүйцэтгэх удирдлагын хүлээж байгаа үүрэг, хариуцлага
- ИЛААР-ын хүрээнд банкны нэгжүүдийн хүлээж байгаа үүрэг, хариуцлага (тухайлбал дотоод аудит, комплайнс, санхүү, эрсдэлийн удирдлага, салбарууд болон бусад нэгжүүд).
- ИЛААР-тай холбогдох дотоод журмууд
- Банкны ерөнхий эрсдэлийн удирдлагын тогтолцоо, түүнд хөрвөх чадварын болон санхүүжилтийн эрсдэлийн эзлэх байр суурь
- Банкны дотоод хязгаарлалтууд, хяналтын тогтолцоо, тухайлбал хөрвөх чадвартай хөрөнгийн нөөцтэй холбоотой хязгаарлалт, хяналт, эрсдэлийн хүлээн зөвшөөрөх хэмжээний хязгаарлалтуудын зохистой байдал

Хөрвөх чадварын эрсдэлийн удирдлагын чухал хэсэг нь урьдчилан дохиологч индикаторууд бөгөөд тэдгээрийг ИЛААР-н тайланд тусган дараах үзүүлэлтүүдийг хамруулна:

- Актив, пассивын төвлөрлийн өсөлт
- Гадаад валютын нээлттэй позицйн өсөлт
- Банкны дотоод болон зохицуулагч байгууллагаас тавьсан хязгаарлалтуудыг зөрчсөн, зөрчих дөхсөн давтагдсан тохиолдлууд
- Пассивын жигнэсэн дундаж хугацааны бууралт
- Банкны ашиг, активын чанар болон бусад санхүүгийн үзүүлэлтүүдийн суларсан байдалд
- Зээлжих зэрэглэлийн бууралт
- Өрийн, эсхүл зээлийн дефолтын своп /credit default swap/-ын хүүгийн зөрүү нэмэгдэх байдал
- Бусад банкуудтай харьцуулахад эх үүсвэрийн өндөр зардал;
- Санхүүжилт олгогчдын зүгээс барьцаа хөрөнгө шаардах, эсхүл барьцаа хөрөнгийг нэмэгдүүлэхийг шаардах, эсхүл шинэ хэлцэл байгуулахаас татгалзах үйл явдлууд
- Иргэд, ЖДҮ эрхлэгчдийн харилцах, хадгаламжийн гадагшлах урсгалын өсөлт
- Урт хугацаат эх үүсвэр бүрдүүлэх хүндрэл
- Балансын гадуурх активтай холбоотойгоор үүсэх хөрөнгийн шаардлага

## 2-р хэсэг. Санхүүжилтийн стратеги

Санхүүжилтийн стратеги нь банкны ерөнхий стратеги болон үйл ажиллагааны төлөвлөгөөний чухал хэсэг байх бөгөөд дараах зүйлсийг хамарсан байна:

- Банкны одоогийн санхүүгийн байдал, одоогийн бизнесийн төлөвт орох өөрчлөлтүүд, үйл ажиллагаа эрхлэх орчин нөхцөл, бизнес төлөвлөгөө (бизнесийн чиглэл тус бүрээр), санхүүгийн байдлын болон мөнгөн урсгалын төсөөлөл, хөрвөх чадвартай хөрөнгийн нөөцийн төсөөлөл, ирээдүйн төлөвлөгөөний хүрээнд шаардлагатай хөрвөх чадвартай хөрөнгийн хэмжээ
- Үнэлгээ хийж байгаа онуудын санхүүгийн байдлын болон мөнгөн урсгалын тайлан, үнэлгээг хамруулан хийсэн хугацаа, огноо
- Банкны стратеги, бизнесийн орчны өөрчлөлт, таамаглал, нөхцөлүүд нь төлөвлөсөн хугацаанд бизнесийн гол чиглэлүүд болон банкны хөрвөх чадварын шаардлагад хэрхэн нөлөөлөхийг тусгасан санхүүгийн байдлын болон мөнгөн урсгалын тайлангийн төсөөлөл (хамгийн багадаа нэг жилийн хугацааны)
- Банкны гурван жилийн санхүүжилтийн стратегийн талаарх бүрэн хэмжээний мэдээлэл, тэр дундаа ирэх 12-18 сарын дэлгэрэнгүй мэдээлэл. Стратегийг банкны ТУЗ эсвэл түүнээс олгосон эрх бүхий этгээд батална. Стратеги нь төлөвлөсөн бизнесийн үйл ажиллагааг ердийн нөхцөлд болон хүндрэлийн үед хэрхэн дэмжих, санхүүжилтийн төлөвийг сайжруулснаар эрсдэлийн хүлээн зөвшөөрөх хэмжээ болон хөрвөх чадварын гол үзүүлэлтүүд хэрхэн хангагдахыг нотолж тайлагнана. Төлөвлөгөөнд учирч болзошгүй эрсдэлүүдийг тусгаж, тэдгээрийг үнэлнэ. Санхүүжилтийн стратеги нь батлагдаад удаагүй байгаа тохиолдолд түүнийг хэрэгжүүлэх үйл явц, арга аргачлалыг нарийвчлан тусгана.
- Санхүүжилтийн эрсдэлийн стратеги, эрсдэлийн хүлээн зөвшөөрөх хэмжээ, эрсдэлийн төлөв, эх үүсвэрүүд болон тэдгээрийн зориулалтыг тусгана. Банк нь эх үүсвэрийн санхүүжилтийн төлөвийн хүрээнд эх үүсвэрийн тогтвортой байдалд эерэг болон сөрөг нөлөө үүсгэж болзошгүй хүчин зүйлсэд дүн шинжилгээ хийнэ. Үүнд барьцаа хөрөнгийн үнэлгээний өөрчлөлт, актив, пассивын эргэн төлөгдөх хугацааны их хэмжээний зөрүү, банкны барьцаанд тавьсан хөрөнгийн зохисгүй түвшин, эх үүсвэрийн төвлөрөл (нэг болон харилцан хамаарал бүхий этгээдүүдийн хувьд, нэг болон нийт гадаад валютын хувьд) зэрэг зах зээлийн өөрчлөлтүүд багтана. Түүнчлэн зах зээл дээрээс эх үүсвэр татах боломжоос гадна богино хугацаанд эх үүсвэр татах боломжийг сулруулж байгаа одоогийн болон ирээдүйд үүсэж болзошгүй хүндрэлтэй нөхцөл байдал, сөрөг мэдээллийн нөлөө зэрэг аюулыг үнэлж дүгнэнэ.
- Санхүүжилтийг олон төрлийн эх үүсвэрээс бүрдүүлэх, ялангуяа харилцах, хадгаламж татахтай холбоотой зах зээл дээрх өрсөлдөөн, цөөн тооны хадгаламж эзэмшигч, санхүүжүүлэгчээс хараат болох эрсдэлийн удирдлага, харилцах, хадгаламж болон бусад санхүүжилтийн эх үүсвэрийн тогтвортой байдлыг хангах стратегийг тусгана. Банкны сүүлийн нэг жилийн хугацааны хадгаламжийн гадагшлах урсгал (нэг өдрийн доторх нийт хадгаламжийн 5 хувиас дээш, нэг долоо хоногт нийт хадгаламжийн 10 хувиас дээш гадагшлах тохиолдлууд) болон хадгаламжийн үлдэгдэл нэмэгдсэн (нэг өдөрт нийт хадгаламжийн 5 хувиас дээш, нэг долоо хоногт нийт хадгаламжийн 10 хувиас дээш хадгаламжийн дүн нэмэгдсэн)



тохиолдлуудыг жагсааж бичнэ.

### 3-р хэсэг. IЛААР-н хүрээнд үнэлэх эрсдэлүүд

Энэ хэсэгт банканд хамгийн өндөр ач холбогдол бүхий хөрвөх чадварын эрсдэлүүдийг тодорхойлж, үнэлэх бөгөөд эдгээр эрсдэлүүдийг бууруулах стратегийг тусгана. IЛААР-н хүрээнд Базел стандартын Бүлэг 2-т тусгасан доорх эрсдэлүүдийг хамгийн багадаа тодорхойлон үнэлж, шинжилнэ. Үүнд:

- i. Санхүүгийн байгууллагын барьцаатай болон барьцаагүй эх үүсвэрийн санхүүжилтийн эрсдэл
  - a. Тухайн эрсдэлийн тодорхойлолт болон эрсдэлийн төвшин өөрчлөгдсөн байдал (ердийн нөхцөлд болон хүндрэлийн үед)
  - b. Хадгаламжийн төвлөрлийн эрсдэл (цөөн тооны хадгаламж эзэмшигчид, эдийн засгийн салбар, дэд салбар, газар зүйн байршлын хувьд)
- ii. Иргэд, ЖДҮ эрхлэгчдийн эх үүсвэрийн санхүүжилтийн эрсдэл
  - a. Хөрвөх чадварын хүндрэлийн үед гадагшлах эх үүсвэрийн хэмжээ
  - b. Эх үүсвэр татагдах магадлал
- iii. Өдөр тутмын (өдөр хоорондын) хөрвөх чадварын эрсдэл
  - c. Хүндрэлийн үед шаардагдах барьцаа хөрөнгө болон мөнгөн хөрөнгийн дүн
- iv. Компанийн нэгдлийн хөрвөх чадварын эрсдэл
  - d. Толгой компани, бусад компанийн нэгдэл, Монголбанкнаас эх үүсвэр бүрдүүлэх боломж
- v. Гадаад валютын хөрвөх чадварын эрсдэл
  - e. Хүндрэлтэй үеийн гадаад валютын гарах болон орох урсгал

Гадаад валютын нээлттэй позицын эрсдэл – Ердийн үетэй харьцуулахад хүндрэлийн үед валютын захад арилжаа хийхэд хүндрэл үүсдэгийг харгалзах.
- vi. Балансын гадуурх хөрвөх чадварын эрсдэл
  - f. Үүсмэл санхүүгийн хэрэгсэл болон хүлээж болзошгүй өр төлбөр, үүрэг, эх үүсвэрийн хэрэгслүүд
- vii. Нэр хүндтэй холбоотой хөрвөх чадварын эрсдэл
  - g. Банк үндсэн бизнесийн үйл ажиллагаагаа үргэлжлүүлэх болон нэр хүндээ хадгалахад хөрвөх чадвартай хөрөнгийн дутагдалд орох нөхцөлүүд
- viii. Хөрөнгө худалдахтай холбоотой эрсдэл (хэвийн нөхцөл болон хүндрэлийн үед хөрөнгийг албадан худалдан нөхцөлүүд)
  - a. Өндөр чанартай хөрвөх чадвартай хөрөнгийг (HQLA) мөнгөжүүлэхтэй холбоотой үүсэх эрсдэл – банк нь хүндрэлийн үед репо хэлцэл болон бусад арга хэрэгслээр богино хугацаанд эх үүсвэр татахад хугацааны хувьд

хязгаарлалт үүсдэг тул өндөр чанартай хөрвөх чадвартай хөрөнгийг худалдах эсвэл барьцаалах замаар өдрийн гадагшлах цэвэр мөнгөн урсгалыг нөхөх боломж хязгаарлагдмал байдаг.

ix. Худалдах зориулалтгүй хөрөнгийн эрсдэл (хэвийн нөхцөл болон хүндрэлийн үед хөрөнгийг албадан борлуулах нөхцөлүүд)

x. Эх үүсвэрийн төвлөрлийн эрсдэл (эх үүсвэрийн төрөл, валют, эх үүсвэр бүрдүүлэгчийн төрөл, хугацаа болон зах зээл тус бүрд харгалзах эх үүсвэрийг бүрдүүлэх уян хатан стратеги)

xi. Бусад эрсдэл

- a. Хөрвөх чадвар болон бусад эрсдэлүүд хоорондын корреляци буюу хамаарал. Тухайлбал, нэр хүндийн эрсдэл, активын төвлөрлийн эрсдэл, банкны ашгийн түвшний эрсдэл (Profit Rate Risk in the Banking Book), стратегийн эрсдэл зэрэг банкны хөрвөх чадварт нөлөөлөх бусад эрсдэлүүд.
- b. Актив, пассивын зөрүүний эрсдэл – Тодорхойлсон сөрөг сценарийн үед банк өдөр тутмын гарах мөнгөн урсгалыг хөрвөх чадвартай хөрөнгийг худалдах болон бусад орох мөнгөн урсгалаар нөхөхөд хүрэлцэхүйц мөнгөн хөрөнгө үүсэх эсэхийг үнэлэх.
- c. Макро эдийн засгийн болон бизнесийн мөчлөгийн эрсдэл - макро эдийн засгийн үзүүлэлтүүд болон тэдгээрт хамааралтай бусад хүчин зүйлийн өөрчлөлтөөс үүсэх эрсдэл (газрын тосны үнэ, Засгийн газрын зардал, ДНБ).
- d. Санхүүгийн үүсмэл хэрэгслийн гэрээ байгуулсан харгалзах тал хүндрэлийн үед анхны маржин шаардлагыг нэмэгдүүлэх эрсдэл.
- e. Үнэт цаасны маржин /барьцаа/-ыг санхүүжүүлэхтэй холбоотой үүсэх хөрвөх чадварын эрсдэл.

Хөрвөх чадварын эрсдэлийн тооцоолол нь дараах хэсгүүдээс бүрдэнэ:

- i. Бүтээгдэхүүн үнэлэх стратеги - бизнесийн ач холбогдол бүхий үйл ажиллагаанууд, балансын болон балансын гадуурх бүтээгдэхүүнүүдийг хамруулна.
- ii. Гүйцэтгэлийн үзүүлэлтүүд болон харилцагч татах борлуулалтын нөхцөлүүд
- iii. Бизнесийн чиглэл тус бүрийн санхүүгийн үзүүлэлтүүд
- iv. Барьцаа хөрөнгийн удирдлага - барьцаанд тавьсан болон тавиагүй хөрөнгүүдийг хооронд нь ялгасан байдал
- v. Өдөр тутмын болон овернайт хөрвөх чадварын эрсдэлийн удирдлага /тодорхойгүй болон үүсэж болзошгүй сөрөг үйл явдлуудыг харгалзах/
- vi. Бизнесийн нэгж, чиглэл болон валют тус бүрийн хөрвөх чадварын эрсдэлийн удирдлага
- vii. Эх үүсвэрийн төрөлжилт болон зах зээлээс хөрөнгө татан төвлөрүүлэх чадвар:
  - Бизнес төлөвлөлтийн үйл явц
  - Зах зээлийн нөхцөл байдал болон зах зээлээс эх үүсвэр бүрдүүлэх чадвар хоорондын хамаарал буюу корреляци
  - Эх үүсвэрийн хугацаа, эх үүсвэр олгогчийн төрөл, барьцаа хөрөнгийн хэмжээ, санхүүгийн хэрэгсэл, валют болон газарзүйн байршил зэргээс хамаарсан хязгаарлалтуудын хүрээнд эх үүсвэрийг төрөлжүүлсэн байдал
- viii. Банк богино, дунд, урт хугацаат эх үүсвэрийг түргэн хугацаанд бүрдүүлэх чадварыг

- тогтмол үнэлж, шалгасан байдал
- ix. Дээр дурдсан бүх эрсдэлүүдийг тодорхойлох, үнэлэх, хэмжихэд ашигласан арга аргачлал болон ирээдүйд ашиглах арга аргачлалын тайлбар, үнэлгээний тоон үр дүн
  - x. Дээрх үнэлгээний холбогдох үр дүн болон хөрвөх чадварын хүрэлцээ (LCR), цэвэр тогтвортой санхүүжилтийн харьцаа (NSFR)-ны тооцоолол хоорондын харьцуулалт
  - xi. Эрсдэлийн төрөл тус бүрийн банкны эрсдэлийн хүлээн зөвшөөрөх хэмжээ
  - xii. Эдгээр эрсдэлээс урьдчилан сэргийлэхэд авч хэрэгжүүлсэн зохих арга хэмжээ

#### **4-р хэсэг. Аргачлал**

Энэ хэсэгт банкууд хөрвөх чадвар, санхүүжилтийн эрсдэлийг тодорхойлох, хэмжих, удирдах, хянах, дотоод, гадаад тайлан гаргах банкны тогтолцоо болон мэдээллийн технологийн системийг тайлагнана (хэрэв хамааралтай бол өдөр тутмын (өдөр хоорондын) эрсдэл үүнд хамаарна). Банкны ашиглаж байгаа таамаглал, нөхцөлүүд, аргачлал, дотоод мэдээллийн урсгалыг тайлбарлаж, гол үзүүлэлтүүдийг баримтаар баталгаажуулсан байна.

Хэрэв банк нь Монголбанкнаас тогтоосон төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцааг тооцоолохдоо дотоод загвар ашигладаг ба тус загварын тооцоолол нь Монголбанкны тооцооллын аргачлалаас ялгаатай байх тохиолдолд аргачлал болон параметруудийн зөрүүг нарийн харьцуулсан тайлбарыг энэ хэсэгт оруулж, энэхүү зөрүүтэй байдал нь IЛААР-н хөрвөх чадварын үзүүлэлтүүдэд хэрхэн нөлөөлж байгааг тусгана.

Банк нь IЛААР-ыг боловсруулахдаа ашигласан загваруудын жагсаалт, тэдгээрийн дэлгэрэнгүй тайлбарыг дараах байдлаар тусгана:

- i. Хөрвөх чадварын үнэлгээний загварчлалд ашиглаж байгаа үндсэн таамаглал, нөхцөлүүд, параметрууд болон тэдгээрийг хэрхэн гаргаж ирсэн талаарх тайлбар
- ii. Сонгосон өгөгдлүүдийн тайлбар, хамарсан хугацаа, өгөгдөл тохируулах үйл явц
- iii. Загварын сул талууд
- iv. Үндсэн таамаглал, нөхцөлүүд эсвэл параметрийн өөрчлөлтөөс хамаарах загварын мэдрэмтгий байдал
- v. Загварын тогтвортой, зохистой байдлыг хангах хүрээнд хийсэн баталгаажуулалт
- vi. Загварыг дотооддоо хөгжүүлсэн эсвэл бэлэн загвар авч нэвтрүүлсэн эсэх. Хэрэв бэлэн загвар нэвтрүүлсэн бол загварын нэр болон загвар хөгжүүлэгчийн дэлгэрэнгүй мэдээлэл
- vii. Загварыг бусад зохицуулагч байгууллагууд, нөөцийн удирдлага хэрэгжүүлэгч олон улсын байгууллагуудаас хүлээн зөвшөөрсөн байдал, загварын нэр хүнд, зах зээлд хүлээн зөвшөөрөгдсөн байдал
- viii. Банк доторх загварын хэрэглээний дэлгэрэнгүй мэдээлэл.
- ix. Сонгосон загваруудын гол давуу болон сул талууд.

#### **5-р хэсэг. Стресс тест**

Стресс тест нь санхүүгийн байгууллага, санхүүгийн системийн дотоод болон гадаад шоконд мэдрэмтгий байдлыг үнэлэх аргачлалын ерөнхий нэр томъёо юм. Стресс тест нь томоохон сөрөг гэхдээ биелэх боломжтой сценариудыг авч үзэж, шокоос үүсэх хүлээгдэж байгаа алдагдлыг тооцоолох зорилготой. Стресс тестийн аргачлал нь түүхэн үйл явдал болон болзошгүй ирээдүйн үйл явдлын талаарх таамаглал дээр суурилсан сценарийн

шинжилгээнүүдийг агуулдаг. Стресс тест нь мэдрэмтгий байдлын шинжилгээг агуулах боломжтой. Үр нөлөөтэй стресс тест нь ашигласан сценариуд нь биелэх боломжтой, аргачлал нь тогтвортой байхаас гадна тайлагналын хувьд удирдлагын шийдвэр гаргахад хялбар байх шаардлагатай.

## **1-р дэд хэсэг. Базел стандартын Бүлэг 1-ийн хөрвөх чадварын стресс тест**

Банк нь дараах зорилгоор зохих стресс тестийг тогтмол гүйцэтгэнэ:

а) Хөрвөх чадварын хүндрэлийн шалтгааныг тодорхойлох:

- Итгэл алдах - үндэслэлтэй/үндэслэлгүй.

- Хямралын халдвар /contagion/ – санхүүгийн салбарын эмзэг сул байдал, бусад байгууллагуудын хүндрэл г.м.

- Гадаад хүчин зүйлс – зах зээлийн хямрал, эрсдэлээс зайлсхийх, эрсдэл багатай хөрөнгөд хөрөнгө оруулах үйл явдлууд г.м.

- Хамааралгүй үйл явдлууд - үйл ажиллагааны тасалдал, байгалийн гамшиг, террорист халдлага г.м.

б) Банкны хөрвөх чадварын үзүүлэлтүүд нь банкны ТУЗ-өөс тогтоосон хөрвөх чадварын эрсдэл хүлээн зөвшөөрөх хэмжээнд байгааг тодорхойлох

в) Банкны бүтээгдэхүүн үнэлэх стратегийн нөлөөг тодорхойлох

г) Хөрвөх чадварын болзошгүй хүндрэлүүдийн бие даасан болон дараах хүчин зүйлээс хамааран хосолсон нөлөөллийг шинжлэх:

о Мөнгөн урсгал.

о Хөрвөх чадварын үзүүлэлтүүд.

о Ашигт ажиллагаа.

о Төлбөрийн чадвар.

Банк нь зөвхөн тухайн банкныг хамарсан, нийт зах зээлийг бүхэлд нь хамарсан болон хосолсон сценарийн хувилбаруудын боломжит нөлөөллийг авч үзнэ. Зөвхөн түүхэн өгөгдөлд үндэслэсэн эсвэл түүхэн өгөгдлүүдэд симуляци хийсэн зэрэг төрөл бүрийн сценариудыг ашиглана. (Зөвхөн тухайн банканд хамааралтай нөхцөлүүд, тухайлбал, банкны харилцах, хадгаламжийн хэмжээ тухайн банкны хамгийн том 3 харилцагчаас өндөр хамааралтай байх, тус харилцагчдын нэг нь байршуулсан хадгаламжаа бүхэлд нь эсвэл хэсэгчлэн хугацаанаас өмнө татахад түүхэн өгөгдөлд тулгуурласан симуляц шинжилгээнд хэрхэн нөлөөлөх, эсхүл банкны активын бүтэцтэй холбоотой сөрөг үйл явдлууд үүсэх нь банканд хэрхэн нөлөөлөх зэрэг таамаглалуудыг ашиглана).

Стресс тестийн хүрээнд сонгосон хүндрэлтэй нөхцөл байдал нь стресс тестэд ашиглаж байгаа дараах таамаглал, нөхцөлүүдийн зохистой байдалд хэрхэн нөлөөлж байгааг харгалзан үзэх шаардлагатай:

- Эх үүсвэр татаж байгаа зах зээл хоорондын хамаарал.
- Эх үүсвэр төрөлжүүлэлтийн үр дүнтэй байдал.
- Нэмэлт барьцаа хөрөнгийн шаардлага (margin call).
- Гуравдагч этгээд эсвэл тухайн банкны нэгдлийн оролцогчид олгосон зээлийн эрхийн ашиглалт болон бусад хүлээж болзошгүй үүргүүд
- Балансын гадуурх үүрэг хүлээхэд зарцуулагдсан хөрвөх чадвартай хөрөнгө

- Хөрвөх чадвартай хөрөнгийн шилжих чадвар
- Монголбанкнаас санхүүжилт татах боломж
- Балансын ирээдүйн өсөлтийн тооцоолол
- Хөрвөх чадвартай санхүүгийн зах зээлүүдээс хөрөнгө татах боломж
- Барьцаатай болон барьцаагүй санхүүжилт (иргэд, ЖДҮ эрхлэгчдийн хадгаламжийг оролцуулна) татах боломж
- Гадаад валютаар илэрхийлсэн хөрөнгийн хөрвөх чадвар
- Банкны үйл ажиллагаанд чухал ач холбогдолтой төлбөр тооцооны системд хандах боломж

Стресс тестийн үр дүнг банкны удирдлагаас тогтоодог бодлого, хязгаарлалтуудад тусгана.

## **2-р дэд хэсэг. Базел стандартын Бүлэг 2-ын хөрвөх чадварын стресс тест**

Монголбанк нь хяналт шалгалтын үнэлгээний аргачлалаар Базел стандартын Бүлэг 1-ийн хүрээнд тогтоосон хөрвөх чадварын харьцааны стресс тестийн шаардлагыг үнэлсний дараа Базел стандартын Бүлэг 2-ын стресс тестийг үнэлэх бөгөөд ингэхдээ Санхүүжилтийн нөөц төлөвлөгөөнд онцгой анхаарал хандуулна.

Зарим сценариудын жишээ:

### **Нэгдүгээр шатны хөрвөх чадварын стресс тестийн жишээ:**

Урьдчилан таамаглаагүй хөрвөх чадварын хүндрэлүүд:

- Санхүүгийн зах зээлд оролцогчид болон хадгаламж эзэмшигчид банкныг богино хугацаанд өр төлбөрөө барагдуулах боломжгүй болсон эсвэл болох магадлалтай гэж үзэх;
- Банкны эх үүсвэр олгогчдоос банканд олгох өдрийн санхүүжилтийн хэмжээг бууруулах;
- Банк нь гадаад валютын спот болон своп зах зээл дээрээс эх үүсвэр татах боломжгүй болох.

Банкны зээлжих зэрэглэл буурснаар урт хугацаандаа банкны зээлжих зэрэглэлээс хамааралтай эх үүсвэрийн хэмжээ буурдаг тул банк эхний шатны, богино хугацааны хүндрэлийн үеийн үргэлжлэх хугацааг хамгийн багадаа хоёр долоо хоног байхаар тооцох шаардлагатай.

### **Хоёрдугаар шатны хөрвөх чадварын стресс тестийн жишээ:**

Урьдчилан таамаглаагүй гурван сарын хугацаанд үргэлжлэх хүндрэл зах зээлийн хэмжээнд үүсэх. Хоёрдугаар шатны хөрвөх чадварын стресс тестийн хүрээнд банк дараах таамаглалуудыг авч үзнэ:

- Тухайн банкны болон түүний харилцагч талуудын активын үнэлгээ эргэлзээтэй болох;
- Банк зарим төрлийн активыг худалдах, авлага цуглуулах боломжгүй болох эсвэл их хэмжээний алдагдалтайгаар активыг худалдах, авлага цуглуулах нөхцөл байдал үүсэх;

- Бусад банкуудын мөнгөн хөрөнгийг харилцагчийн анхны шаардлагаар гарган өгөх чадварт эргэлзээтэй байдал үүсэх;
- Банкны эх үүсвэр татдаг зах зээлийн оролцогчид эрсдэлээс болгоомжлох хандлага гаргах.

Банк нь хамгийн багадаа энэхүү баримт бичгийн 4-р зүйлийн 5 дахь хэсэгт заасан түвшинд хөрвөх чадварын стресс тестийг хийж гүйцэтгэнэ.

### **6-р хэсэг. Санхүүжилтийн нөөц төлөвлөгөө**

Банк нь өөрийгөө санхүүжүүлэх чадварт ноцтой хүндрэл үүсэх тохиолдолд авах арга хэмжээний бодлого, журам, үйл ажиллагааны төлөвлөгөөтэй байна. Банк нь энэхүү санхүүжилтийн нөөц төлөвлөгөө (CFP)-г IЛААР-н тайланд хавсаргана.

Банкны санхүүжилтийн нөөц төлөвлөгөө нь хамгийн багадаа дараах шаардлагыг хангасан байна:

- Олон төрлийн хүндрэлт нөхцөл байдлыг удирдах стратеги, бодлого, төлөвлөгөөг тодорхойлох
- Удирдлагын үүргийн хуваарилалт, хариуцлагын тогтолцоог бүрдүүлэх
- Дээрх удирдлага, зохион байгуулалтын асуудлуудыг зохих түвшинд батлах
- Урьдчилан тодорхойлсон хүндрэлт нөхцөл байдал үүсэх үед авах үе шаттай арга хэмжээ болон тухайн асуудлыг удирдлагад мэдээлэх үйл явцыг тусгах
- Тус төлөвлөгөө хэрэгжих боломжтой эсэхийг тогтмол туршиж, шинэчлэх. Санхүүжилтийн нөөц төлөвлөгөөг туршиж, шинэчлэх үйл явц нь банкны хөрвөх чадварын зохистой засаглалд хяналт тавихад чиглэж, дараах хэсгийг агуулсан:
  - Хөрвөх чадварын хүндрэлийн удирдлагын багийн бүрэлдэхүүн
  - Хөрвөх чадварын хүндрэлийн удирдлагын багийн үүрэг, хариуцлага.
- Тодорхой шалгуур үзүүлэлтүүдийг ашиглан урьдчилан дохиологч индикаторуудыг тодорхойлох (Зээлийн шугамыг идэвхжүүлэх боломж, зээл төлөлтийн үр ашигтай байдал, хуримтлагдсан орох цэвэр мөнгөн урсгал зэрэг шалгуур үзүүлэлтүүдийг ашиглах боломжтой. Тухайлбал, эдгээр дохиологч үзүүлэлтүүд нь гурван сарын турш тасралтгүй 30 хувь эсвэл 50 хувиар буурахад үндэслэсэн хяналтын үзүүлэлтүүд (triggers)-тэй байна. Хөрвөх чадварын стресс тестийн үр дүн болон урьдчилан дохиологч индикаторт үндэслэн санхүүжилтийн нөөц төлөвлөгөөг хэрэгжүүлэх боломжтой
- Яаралтай үед холбоо барих болон бусад логистикийн асуудлууд
- Монголбанктай харилцах стратеги
- Хөрвөх чадвартай хөрөнгө хомсдох үед банкны чухал ач холбогдолтой төлбөрүүдийг өдөр тутамдаа гүйцэтгэхтэй холбоотой асуудлууд
- Иргэд, ЖДҮ бизнес эрхлэгчид хадгаламжаа татах нөхцөл байдал үүсэхэд банкны авч хэрэгжүүлэх үйл ажиллагаа
- Онцгой байдлын үед ашиглахаар тодорхойлсон санхүүжилтийн эх үүсвэр бүрээс татах боломжтой санхүүжилтийн хэмжээ, тэдгээрт шаардагдах хугацаа
- Төлбөр тооцооны системүүдэд доголдол үүсэхэд тухайн эрсдэлийг удирдах үйл ажиллагаа
- Хүндрэлийн үед банкны дотроо болон гаднын холбогдох талуудтай харилцах стратеги

- Банкны ТУЗ болон гүйцэтгэх удирдлагад чухал мэдээллийг цаг алдалгүй мэдээлэх тогтолцоо
- Төлөвлөгөөнд тусгасан арга хэмжээ бүрийг хэзээ, хэрхэн хэрэгжүүлэхийг нарийвчлан тодорхойлсон үйл явц
- Онцгой байдлын үед татах эх үүсвэрийн төрөл бүрээс нэмэлт санхүүжилт авахад шаардагдах хугацаа.

Санхүүжилтийн нөөц төлөвлөгөөг боловсруулахдаа дараах зүйлсийг анхаарна:

- Хүндрэлийн үед банкны хөрөнгө худалдах чадварт үзүүлэх зах зээлийн нөхцөл байдлын нөлөө
- Эх үүсвэр татах боломж бүрмөсөн эсвэл хэсэгчлэн алдагдахад банканд үзүүлэх нөлөө
- Санхүүжилтийн нөөц төлөвлөгөөг хэрэгжүүлснээр тухайн банканд үүсэх санхүүгийн, нэр хүндийн болон бусад үр дагаврууд
- Хууль эрх зүй, зохицуулалтын болон үйл ажиллагааны аливаа хязгаарлалтыг харгалзан хөрвөх чадвартай хөрөнгийг шилжүүлэх чадвар
- Монголбанкнаас нэмэлт эх үүсвэр татах боломж

ЦААР тайлан дахь санхүүжилтийн нөөц төлөвлөгөө нь хамгийн багадаа дараах 3 бүрэлдэхүүн хэсгийг агуулсан байна. Үүнд:

- a. Засаглал: Санхүүжилтийн нөөц төлөвлөгөөг хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий хороод, эрх бүхий болон хэрэгжүүлэгч албан хаагчид, төлөвлөгөөг хэрэгжүүлж эхлүүлэх нөхцөл болон хэрэгжүүлэх үйл явц.
- b. Хяналтын үзүүлэлтүүд: Санхүүжилтийн нөөц төлөвлөгөөг хэрэгжүүлэх үндэслэл болох хөрвөх чадварын хүндрэлийн үзүүлэлтүүдийн тухай тайлбар.
- c. Санхүүжилтийн хувилбарууд: Банкны төлбөр түргэн гүйцэтгэх чадварыг сайжруулах чиглэлээр нэн даруй хэрэгжүүлэх боломжтой арга хэмжээнүүд, тухайлбал, бусад байгууллагатай байгуулсан нээлттэй санхүүжилтийн шугамыг идэвхжүүлэх, хөрөнгө худалдах, банкны хувьцаа эзэмшигч батлан даагчийн үүргээ гүйцэтгэх болон бусад богино хугацаанд эх үүсвэр татах санхүүжилтийн хувилбаруудыг тусгана. Дунд болон урт хугацаанд санхүүжилт татах арга хэмжээнүүд нь хүндрэлийн үед авч хэрэгжүүлэх санхүүжилтийн арга хэрэгсэлд тооцогдохгүй тул санхүүжилтийн нөөц төлөвлөгөөнд оруулахгүй.

“Банкны өөрийн хөрөнгийн хүрэлцээ болон хөрвөх чадварын хүрэлцээг дотооддоо үнэлэх аргачлалын журам”-ын 3 дугаар хавсралт

## ПРАКТИКТ НЭВТРҮҮЛЭХ ЗӨВЛӨМЖ

### Бүлэг 1. Өөрийн хөрөнгийг дотооддоо тодорхойлох


#### 1-р хэсэг. Өөрийн хөрөнгийн ерөнхий бүтэц

Энэхүү журмын Хавсралт 2-ын Бүлэг 13-т заасны дагуу ИСААР нь ирээдүйд чиглэсэн шинж чанартай тул өөрийн хөрөнгийн төлөвлөлттэй уялдсан байх шаардлагатай. Бүрэн хэмжээний өөрийн хөрөнгийн төсөөлөл нь банкны төлөвлөлт, төсөвлөлтийн үйл явцтай уялдаж, дараах үзүүлэлтүүдийн төсөөллийг багтаасан байна. Үүнд:

1. **Биет өөрийн хөрөнгө.** Ашиг, ногдол ашиг болон өөрийн хөрөнгийн удирдлагын үйл ажиллагаанаас хамаарах өөрийн хөрөнгийн балансын дүн.
2. **Эдийн засгийн өөрийн хөрөнгийн шаардлага.** Эрсдэл даах нийт өөрийн хөрөнгийн шаардлага буюу зээлийн эрсдэл, зах зээлийн эрсдэлийн хязгаар болон бусад таамаглалын үр дүн.
3. **Өөрийн хөрөнгийн доод шаардлага.** Зохицуулагч байгууллагаас тогтоосон өөрийн хөрөнгийн доод шаардлага бөгөөд эрсдэлээр жигнэсэн активын таамаглалын үр дүн.

Иймд банк нь өөрийн хөрөнгийн ирээдүйн 3-5 жилийн төсөөллийг доорх зурагт харуулсны дагуу тооцоолно.





## 2-р хэсэг. Өөрийн хөрөнгийн тодорхойлолтууд

Энэхүү журмын хүрээнд банк нь доорх өөрийн хөрөнгийн тодорхойлолтуудыг үйл ажиллагаандаа нэвтрүүлж, мөрдөнө.

**Өөрийн хөрөнгийн эрэлт:** Нийт өөрийн хөрөнгийн шаардлага. Өөрийн хөрөнгийн хэрэгцээний эрэлтийн бүрэлдэхүүн хэсэг тус бүрийг Монголбанкнаас тогтоосон журмын дагуу тооцоолох бөгөөд энэ нь банкны эрсдэлийн бодит түвшний тооцооллын үр дүн байна.

**Өөрийн хөрөнгийн нийлүүлэлт:** Хувьцаа эзэмшигчдийн оруулсан мөнгөн хөрөнгө, үйл ажиллагааны хуримтлагдсан ашиг, хувьцаа эзэмшигчдээс эсвэл бусад эх үүсвэрээс бий болсон 1-р зэрэглэлийн болон 2-р зэрэглэлийн өөрийн хөрөнгийн дүн. Өөрийн хөрөнгийн нийлүүлэлтийг хоёр аргаар тооцоолно.

- Статик буюу банкны тайлан тэнцэл дэх төрөл бүрийн өр төлбөрийг нийт өөрийн хөрөнгийн шаардлага (OCR)-ын түвшинтэй харьцуулах зорилгоор нягтлан бодох бүртгэлийн тодорхой хугацааг авч үзэх.
- Динамик буюу стратегийн үр дүнд бий болох ирээдүйн үйл ажиллагааны ашгийг харгалзах зорилгоор нягтлан бодох бүртгэлийн тайланг үндэслэлтэйгээр төсөөлөх. Ингэхдээ ирээдүйн ашгийн тооцоололд хангалттай хэмжээний стрессийг өгсөн байна.

**OCR: Нийт өөрийн хөрөнгийн шаардлага.** Базел стандартын Бүлэг 1-ийн өөрийн хөрөнгийн шаардлага (МБЕ-н 2019 оны А-138-р тушаалын хүрээнд шаардах зээлийн, зах зээлийн болон үйл ажиллагааны эрсдэлд харгалзах өөрийн хөрөнгийн хэмжээ), + Базел

стандартын Бүлэг 2-ын өөрийн хөрөнгийн шаардлага (хамгийн багадаа төвлөрлийн эрсдэл, IRRBB болон ICAAP-с үүдэлтэй бусад голлох эрсдэлүүдэд харгалзах өөрийн хөрөнгийн шаардлага), + МБЕ-н 2019 оны А-138-р тушаалаар батлагдсан журмын хүрээнд тогтоосон нөөц өөрийн хөрөнгө.

**TSCR: Хяналт шалгалтын үнэлгээний өөрийн хөрөнгийн нийт шаардлага.** Базел стандартын Бүлэг 1-ийн өөрийн хөрөнгийн шаардлага (МБЕ-н 2019 оны А-138-р тушаалын хүрээнд шаардах зээлийн, зах зээлийн болон үйл ажиллагааны эрсдэлд харгалзах өөрийн хөрөнгийн хэмжээ), + Базел стандартын Бүлэг 2-ын өөрийн хөрөнгийн шаардлага (хамгийн багадаа төвлөрлийн эрсдэл, IRRBB болон ICAAP-с үүдэлтэй бусад голлох эрсдэлүүдэд харгалзах өөрийн хөрөнгийн шаардлага).

**MDA trigger: Ногдол ашиг тараахыг хориглох тохиолдол:** Ногдол ашиг тараахыг хориглох өөрийн хөрөнгийн хязгаар.

**Эдийн засгийн өөрийн хөрөнгө (Эрсдэл даах нийт өөрийн хөрөнгийн шаардлага):** Банкны 1-3 жилийн эсхүл 5 хүртэлх жилийн хугацааны (стратеги бодитоор хэрэгжих магадлалаас хамаарч хугацааг тогтооно) стратегийг хэрэгжүүлж, стресст нөхцөлд банкны хэвийн тогтвортой үйл ажиллагааг хангахад шаардлагатай TSCR-с дээш өөрийн хөрөнгийн нийт шаардлага. Эдийн засгийн өөрийн хөрөнгийг тооцоолохдоо стресс тестийн үр дүнг тусгах бөгөөд банкууд эцсийн тооцоололд сонгосон сценариуд нь биелэх боломжтой бөгөөд хангалттай хүндрэлт нөхцөл гэдгийг баталгаажуулна. Банк нь хамгийн багадаа энэ журмын 13-т заасны дагуу Монголбанкнаас санал болгосон суурь сценарийн дагуу эдийн засгийн өөрийн хөрөнгийн тооцооллыг хийх шаардлагатай. Банк нь илүү хүндрэлт нөхцөлтэй сөрөг сценар ашиглан нэмэлт стресс тест хийвэл зохистой. Эдийн засгийн өөрийн хөрөнгийг дор хаяж N+1 жилийн хугацаанд тооцоолно. Хэрэв банк нь банкны системийн ерөнхий төлөв байдлаас давсан өсөлттэй байх стратегитай эсвэл бизнес загвараа мэдэгдэхүйц өөрчлөх стратегитай бол илүү урт хугацааг авч үзнэ.

**3-р хэсэг. “Банкны үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тогтоох, түүнд хяналт тавих журам” болон ICAAP-н журмын дагуу өөрийн хөрөнгийн бүтцэд тавигдах зохицуулалтын доод шаардлага**


Нийт өөрийн хөрөнгийн шаардлага (OCR)-ын хувьд банк нь хамгийн багадаа дараах шаардлагыг дагаж мөрдөнө:

- TSCR-н доод хэмжээ 12 хувь, үүнээс 1-р зэрэглэлийн өөрийн хөрөнгөөр 9-өөс доошгүй хувийг бүрдүүлнэ (А-138-р тогтоолын 2.5-р заалт).
- Нөөц өөрийн хөрөнгийн шаардлагын суурь хэсэг бүх банканд 2 хувь (2.23-р заалт), системийн нөлөө бүхий банкуудад хамаарах тусгай хэсэг (2.25-р заалт) нь хамгийн ихдээ 2 хувь байх бөгөөд эдгээр нь 1-р зэрэглэлийн өөрийн хөрөнгө, ЭЖА-ын доод хэмжээн дээр нэмэгдэнэ.

Үүний үр дүнд:


- 1-р зэрэглэлийн өөрийн хөрөнгө нь системийн бус банкуудын хувьд хамгийн багадаа нийт ЭЖА-ын 11 хувийг (Бүлэг 1+ Бүлэг 2), системийн банкуудын хувьд хамгийн ихдээ нийт ЭЖА-ын 13 хувийг бүрдүүлнэ.

Өөрийн хөрөнгийн нийлүүлэлтийг дараах байдлаар илэрхийлнэ:



## Бүлэг 2. Хөрвөх чадвартай хөрөнгийн нөөцийг тогтоох

### 1-р хэсэг. Хөрвөх чадвартай хөрөнгийн болон эх үүсвэрийн санхүүжилтийн нөөцийн ерөнхий зураглал



## **2-р хэсэг. Тодорхойлодтууд**

Хөрвөх чадвартай хөрөнгийн ба санхүүжилтийн нөөц: Банк нь хөрвөх чадварын нөөцийн хувьд 1 жил, санхүүжилтийн нөөцийн хувьд 3 жилийн хугацаанд харилцагчийн өмнө хүлээсэн үүргээ гүйцэтгэхэд шаардагдах хөрвөх чадвартай хөрөнгийн хэмжээг үнэлж, тодорхойлно. Хөрвөх чадварын нөөцийн хувьд богино хугацаатай, санхүүжилтийн нөөцийн хувьд дунд хугацаатай хөрвөх чадвартай хөрөнгийг төлөвлөж бүрдүүлнэ. Хөрвөх чадварын үзүүлэлтүүд нь ИСААР-н хүрээнд тодорхойлж тооцоолсон, стресс тестээр хэмжсэн эрсдэлүүдтэй нийцтэй байна.

Дээр дурдсан хөрвөх чадвартай хөрөнгийн болон санхүүжилтийн нөөцөөс гадна банк нь хүндрэлийн үед үйл ажиллагааны тасралтгүй байдлыг хангах зорилгоор өр төлбөр барагдуулах үүргээ биелүүлэхтэй холбоотойгоор аливаа таамаглаагүй нөхцөл байдал үүсэхэд хэрэгжүүлэх үйл ажиллагааны тодорхой, нарийн төлөвлөгөөтэй байна. Хөрвөх чадвартай хөрөнгийн болон санхүүжилтийн нөөцийг тооцоолох үйл явц нь хүндрэлийн үед шаардагдах хөрвөх чадварын үнэлгээ, холбогдох арга хэмжээ авахад зарцуулах цаг хугацаа, банкны ашигт ажиллагаа, нэр хүнд, бизнес загварын тогтвортой байдалд үзүүлж болзошгүй сөрөг нөлөө, хүндрэлийн үед авч хэрэгжүүлэх арга хэмжээний үр дүнтэй байдал зэргийг үнэлэхэд чиглэсэн арга хэмжээнүүдтэй уялдсан байна.

### Бүлэг 3. Тайланг боловсруулах дарааллын зөвлөмж


Энэ хэсэгт дурдсан ажлын төлөвлөгөө нь зөвлөмж тул заавал мөрдөх шаардлагагүй бөгөөд ICAAP, ILAAP-н тайланг журамд нийцүүлэн логик дарааллын дагуу боловсруулах боломжит хувилбар болно. Уг зөвлөмжийг боловсруулахдаа банк нь зохистой засаглалын хүрээнд Монголбанкнаас тогтоосон шаардлагуудыг хангасан, хараат бус Эрсдэлийн удирдлагын нэгжтэй (2 дугаар түвшний хамгаалалт), хараат бус дотоод аудитын нэгжтэй (3 дугаар түвшний хамгаалалт), Актив пассивын удирдлагатай байна гэж үзсэн болно.

#### 1-р үе шат. Стратеги болон эрсдэлийн хүлээн зөвшөөрөх хэмжээг тодорхойлох

ТУЗ нь Гүйцэтгэх удирдлагын оролцоотойгоор, Эрсдэлийн удирдлагын нэгж болон Актив пассивын удирдлагын нэгжтэй хамтран банкны өөрийн хөрөнгийн одоогийн түвшнийг харгалзан дараагийн жилүүдийн эрсдэлийн хүлээн зөвшөөрөх хэм хэмжээг тодорхойлно.

Төлөөлөн удирдах зөвлөл нь өөрийн хөрөнгө, хөрвөх чадварыг харгалзан эрсдэлийн хүлээн зөвшөөрөх хэм хэмжээ, эрсдэл даах чадамжийг тогтоож, албан ёсны мэдэгдэл гаргана.

Эрсдэлийн хязгаарууд, эрсдэл тус бүрийн хэм хэмжээг Гүйцэтгэх удирдлагын удирдлага дор Эрсдэлийн удирдлагын нэгжээс тодорхойлж, ТУЗ батална.



#### 2-р үе шат. Эрсдэлийн зураглал болон эх үүсвэр, хөрвөх чадвартай хөрөнгийн хэмжээ



Бизнесийн нэгжүүд (байгууллагын зээлийн, иргэдийн зээлийн, зах зээлийн болон арилжааны үйл ажиллагаа гэх мэт) нь ТУЗ-өөс баталсан стратегийн хүрээнд өөрийн нэгжийн хувьд эрсдэлийн мэдээллийг Эрсдэлийн удирдлагын нэгжид, хөрвөх чадвар, санхүүжилтийн шаардлагын мэдээллийг Актив пассивын удирдлагын нэгжид мэдээлнэ. Үүнд Базел стандартын Бүлэг 1,2-ын эрсдэлүүд багтсан байна.

Эрсдэлийн удирдлагын нэгж нь банкны Актив пассивын удирдлагын нэгж болон Гүйцэтгэх удирдлага, түүнчлэн эдийн засгийн судалгааны нэгжүүд болон бизнесийн нэгжүүдтэй хамтран ажиллаж, суурь сценар, дунд зэргийн хүндрэлийн үеийн болон хүндрэлийг нэмэгдүүлсэн сөрөг сценариудыг боловсруулна. Эдгээр таамаглал болон стресс тестүүд нь өөрийн хөрөнгийн шаардлага (ЭЖА-г тооцоолж, тооцоолсон ЭЖА-аасаа OCR, TSCR, эдийн засгийн өөрийн хөрөнгийг тооцоолно), богино эсвэл дунд хугацааны нөөцийн шаардлагыг тооцоолно.

Стресс тестийг банкны дотоод аудитын нэгжээр эсхүл хөндлөнгийн аудитаар баталгаажуулсан байна. Энэхүү баталгаажуулалт нь мэдээллийн бүрэн бүтэн байдал, загварчлалын зөв зохистой байдал, үр дүнг зөв тайлбарласан эсэхийг баталгаажуулна.

### 3-р үе шат. Нэгтгэл

Стресс тестийг ихэнхдээ бизнесийн нэгжүүд гүйцэтгэх нь хялбар бөгөөд зөв зохистой загварчлах хүрээнд үр дүнтэй байдаг. Үүний дараа Эрсдэлийн удирдлагын нэгж болон Актив пассивын удирдлагын нэгж нь стресс тестийн үр дүнг өөрийн хөрөнгийн шаардлага, богино болон дунд хугацааны хөрвөх чадварын шаардлагын хүрээнд банкны түвшинд нэгтгэх ажлыг гүйцэтгэдэг.


Актив пассивын удирдлагын нэгж нь нь өөрийн хөрөнгийн төлөвлөгөө, хөрвөх чадварын төлөвлөгөө, мөн CFP-г хийж гүйцэтгэнэ.

Түүнчлэн энэхүү баримт бичгийн Хавсралт 1, 2-т заасны дагуу ICAAP, ILAAP-тай холбоотой баримт бичгүүдийг бэлтгэх чиг үүргийг Эрсдэлийн удирдлагын нэгж хариуцна. Эдгээр баримт бичгүүд нь Монголбанкнаас тус хоёр тайлангийн зохистой байдлыг үнэлэхэд шаардлагатай бүхий л чанарын болон тоон мэдээллийг агуулсан байна.

### 4-р үе шат. Баталгаажуулалт болон тайланг хүргүүлэх

ICAAP болон ILAAP-тай холбоотой бүх баримт бичгийг банкны дотоод аудит хариуцсан нэгж баталгаажуулах шаардлагатай бөгөөд баримт бичиг, тайлан, үр дүнгийн бүрэн гүйцэд, үнэн зөв, үндэслэлтэй байдлыг хангана.

Гүйцэтгэх удирдлагаас тайлан болон холбогдох баримт бичгүүдийг урьдчилан баталсны дараа ТУЗ-д танилцуулж ТУЗ-ийн хурлаар батална. Үүний дараа ICAAP болон ILAAP-н тайланг Монголбанканд хянуулахаар хүргүүлнэ.





#### Бүлэг 4. Нийт өөрийн хөрөнгийн шаардлагыг тооцох жишээ

ИСААР-с өмнө А банк нь Монголбанканд дараах үзүүлэлтүүдийг тайлагнасан гэж үзье.

Актив		Пассив	
Зээл	700	280	Банк хоорондын зээл
Төгрөгийн бонд	300	1000	Хадгаламж
Бусад актив	200	100	Компанийн бонд
Үндсэн хөрөнгө	300	120	Өөрийн хөрөнгө (1 болон 2-р зэрэглэлийн)
<b>НИЙТ АКТИВ</b>	<b>1500</b>	<b>1500</b>	<b>НИЙТ ПАССИВ</b>

МБЕ-ийн 2019 оны А-138-р тушаалын Бүлэг 1-ийн өөрийн хөрөнгийн шаардлага:

**Зээлийн эрсдэл:** тэнцлийн актив, тэнцлийн гадуурх хүлээж болзошгүй үүргийн дүнг А-138-р тушаалд заасан эрсдэлийн хувиар үржүүлж тооцоход зээлийн эрсдэлээр жигнэсэн активын дүн 600 байна.

**Зах зээлийн эрсдэл:** Нийт нээлттэй позицитай дүнг авч үзвэл гадаад валютын ханшийн эрсдэлээр жигнэсэн активын дүн нь 30 байна.

**Үйл ажиллагааны эрсдэл:** Банкны өнгөрсөн үеийн нийт орлогын дунджийг авч үзвэл үйл ажиллагааны эрсдэлээр жигнэсэн актив нь 70 байна.

Банк нь бусад эрсдэл (нэр хүндийн, стратегийн, бизнесийн загварын болон бусад)-үүдийг материаллаг бус гэж үзсэн тул Бүлэг 2-ын өөрийн хөрөнгийн шаардлагыг зөвхөн IRRBB болон төвлөрлийн эрсдэлийн хувьд тооцсон.

Банк нь энэхүү баримт бичгийн 3-р бүлгийн, 6-р хэсэгт заасан хэмжүүрүүдийг ашиглан дараах бүрэлдэхүүн хэсгүүдийг тооцоолно:

IRRBB-н хувьд зээлийн хүү нь 200 суурь нэгжээр зэрэгцэн өсөх болон буурах шокийн сценариуд хувьд хамгийн өндөр дүнтэй сөрөг  $\Delta NII$  болон  $\Delta EVE$  нь:  $\Delta NII = -10$  болон  $\Delta EVE = -20$  байна.

Төвлөрлийн эрсдэлийн хувьд ICI нь 0.15, SCI нь 22 байна.

Банкны стратеги төлөвлөгөөнд зээлийн үйл ажиллагааг өргөжүүлснээр зээлийн ЭЖА ирэх 3 жилд дараах байдлаар нэмэгдэнэ гэж тусгасан.

N+1	N+2	N+3
800	900	1000

Банкны стратеги төлөвлөгөөнөөс шалтгаалан зах зээлийн болон үйл ажиллагааны эрсдэл их хэмжээгээр нэмэгдэхгүй. Стратеги төлөвлөгөөнд тусгагдсан өсөлтийн хүлээлт нь тогтвортой бизнес загварын тусламжтайгаар биелэгдэх боломжтой гэж үзэхээр байна. Иймд эдийн засгийн өөрийн хөрөнгийг 1 жилийн хугацаанд тооцоох нь тохиромжтой байна.

Энэхүү баримт бичгийн 13-т заасан Монголбанкнаас тодорхойлсон стресс тестийн сценариуд дээр банк өөрийн стресс тестийн параметруудийг тусгаснаар нэмж байгуулах эрсдэлийн санд дараах нөлөөг үзүүлэхээр байна.

N+1	N+2	N+3
30	25	0

Банк нь нийт өөрийн хөрөнгийн шаардлагыг дараах байдлаар тайлагнана:

	ЭЖА	Өөрийн хөрөнгө
Бүлэг 1-ийн зээлийн эрсдэл	600	72
Бүлэг 1-ийн зах зээлийн эрсдэл	30	3,6
Бүлэг 1-ийн үйл ажиллагааны эрсдэл	70	8,4
<b>Бүлэг 1-ийн нийт өөрийн хөрөнгийн шаардлага</b>	<b>700</b>	<b>84</b>
Бүлэг 2-ын IRRBB эрсдэлийн $\Delta$ NIИ-н нөлөө		10
Бүлэг 2-ын салбарын төвлөрлийн эрсдэл		$6\% \times 72^8=4,3$
<b>Бүлэг 2-ын нийт өөрийн хөрөнгийн шаардлага</b>		<b>14,3</b>
<b>TSCR = Хяналт шалгалтын нийт өөрийн хөрөнгийн шаардлага</b>		<b>84+14,3=98,3</b>
МБЕ-ийн 2019 оны А-138-р тушаалаар тогтоосон нөөц интервал (2%-ийн суурь хэсэг+ X тусгай хэсэг)	X=0 гэж үзсэн (системийн бус банк)	$2\% \times 700=14$
<b>OCR = Нийт өөрийн хөрөнгийн шаардлага</b>		<b>84+14,3+14=112,3</b>
N+1 жилд банкны стратегийг хэрэгжүүлэхэд шаардлагатай өөрийн хөрөнгө	N+1 жилд зээлийн ЭЖА-ын нэмэгдэх дүн (800-600)=200	24
Өөрийн хөрөнгийн стресс тестийн нөлөө		30
IRRBB эрсдэлийн $\Delta$ EVE-н нөлөө		20

<sup>8</sup> Банкны зээлийн багц нь зөвхөн байгууллагын зээлээс бүрддэг гэж үзсэн. Иймд 6%-ийн нэмэгдэл нь бүх зээлийн ЭЖА-д хамаарна. Хэрэв банк нь төрөлжсөн зээлийн багцтай бол 6%-ийн нэмэгдэл нь зөвхөн байгууллагын зээлийн ЭЖА-д хамаарах бөгөөд бусад зээлийн (иргэдийн, улсын гэх мэт) ЭЖА-д хамаарахгүй.

<b>Ирээдүйн эрсдэлүүдэд харгалзах эдийн засгийн өөрийн хөрөнгө</b>	<b>74</b>
--	-----------

Улмаар банк нөхцөл байдлаа дараах байдлаар тайлагнана:

1. Банкны нийт өөрийн хөрөнгө нь 120 бөгөөд үүнийг Бүлэг 1-ийн эрсдэлээр жигнэсэн активын дүн болох 700-д харьцуулахад өөрийн хөрөнгийн хүрэлцээний харьцаа 17,1% байна. Энэ нь Бүлэг 1-ийн өөрийн хөрөнгийн шаардлага болох 84-ийг хангаж байна.
2. Нийт өөрийн хөрөнгө буюу 120 нь Бүлэг 1, 2-ын өөрийн хөрөнгийн шаардлага (TSCR) болох 98,3-г мөн хангаж байна.
3. Банк нь системийн нөлөө бүхий банк биш тохиолдолд нийт өөрийн хөрөнгө нь Бүлэг 1, 2-ын өөрийн хөрөнгийн шаардлага + нөөц интервал (OCR) буюу 112,3-ийг хангахаар байгаа тул MDA (Ногдол ашиг тарааж болох өөрийн хөрөнгийн доод хэмжээний хязгаар)-ийн хязгаарт хүрээгүй тул банк хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг хуваарилах боломжтой байна.
4. Харин нийт өөрийн хөрөнгө нь Бүлэг 1, 2-ын өөрийн хөрөнгийн шаардлага + нөөц интервал + эдийн засгийн өөрийн хөрөнгийн шаардлага болох 186,3 хангахааргүй байна. Иймд банк өөрийн хөрөнгийн төлөвлөлтдөө стратегиа хэрэгжүүлэхэд нь шаардагдах ирээдүйн өөрийн хөрөнгийн нэмэлт шаардлагыг хэрхэн бүрдүүлэх талаараа тусгана.